***Миний абуу Гунгаа овогт Цэрэнбатаагийн мэлмий гийсний 100 жилийн ойд зориулав***

# НОГООН ДЭВТЭР

*Аравдугаар цуврал*

**БУРХАН БАГШ БЭЭР**
**ДЭЭДСЭЭС ЗАЯАСАН ТӨРӨЛХ НУТАГТ МИНЬ ЗАЛАРЧ**
**ДЭЭДИЙН НОМЫН УВИДАС ХАЙРЛАСАН НЬ**

**МБШТөв Гандан хийдийн гавж**
**Доктор, Ph/D нэрийг зүүгч Ц.Отгонбаяр**

**Улаанбаатар, 2018 он**

ДАА 294.3
ННА 86.4
О-535

**GREEN BOOK 10*th***

Executive editor: Shiravjamts Otgonbayar
(Ph.D) Student of historian programm Ëotvos Lórand university (ELTE)
Department of modern and Contemporary history

**НОГООН ДЭВТЭР 10 *дугаар цуврал***

Хянаж редакторласан: Унгар улсын доктурант О.Ширавжамц

Эх бэлтгэсэн: Доктор П.Яндий
Заямонгол овогт О.Ширавсингэ

“Бэмби сан” ХХК-д хэвлэв.
Улаанбаатар 2018 он

ISBN: 978-99978-980-2-9

Printed for free distribution by
**The Corporate Body of the Buddha Educational Foundation**
11F, No. 55, Sec. 1, Hang Chow South Road, Taipei, Taiwan, R.O.C.
Tel: 886-2-23951198 , Fax: 886-2-23913415
Email: overseas@budaedu.org
Website:http://www.budaedu.org
Mobile Web: m.budaedu.org
**This book is strictly for free distribution, it is not to be sold.**
**ЗАРЖ БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО**



## УЯЛГА ҮГ

Архангай аймгийн Батцэнгэл сумын уугуул “АмВай” /AMWAY/ компанийн алтан захирал Жамцын Булгантамир бээр хайрт өвөө Заяын хүрээний өвгөн хуврага Г.Цэрэнбатаагийн мэлмий гийсний 100 жилийн ойг тохиолдуулан энэхүү номыг ивээн тэтгэн хэвлүүлж олны хүртээл болгож байгаад маш их талархаж байгаагаа илэрхийлье. Арван цагаан буян дэлгэрэх болтугай.

**МБШТөв Гандан хийдийн гавж**
**Доктор, Ph/D нэрийг зүүгч Ц.Отгонбаяр**

# ГАРЧИГ

УЯЛГА ҮГ . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .3

БУРХАН БАГШ НУТАГТ МИНЬ ЗАЛАРСАН ТУХАЙ ЭШЛЭЛҮҮД. . .6

Бидний явсан анхны аялалын маршрут . . . . . . . . . . . . . . . . . . . . . .17

АНХДУГААР ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГИЙН ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ГАЗРЫН МАРШРУТ . . . . . . . . . . . . . . . . . .18

ХОЁР ДАХ УДААГАА ӨВӨРМОНГОЛД ХИЙСЭН ЭРДЭМТЭДИЙН БАГИЙН ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭ . . . . . . . . . . . .20

ӨВӨРМОНГОЛ ЭРДЭМТДИЙН ТАЙЛБАР . . . . . . . . . . . . . . . . . . .21

АРВАС АРЖАЙ ОРОН БОЛ ЧИНГИС ХААНЫ НАЙМАН ЦАГААН ОРДЫН ЛИН УЛСЫН ҮЕ ДЭХЬ ТАХИЛГЫН ГАЗАР МӨН . . . . . . .21

АРЖАЙ АГУЙН ДАХЬ ЧУХАЛ ХЭДЭН АСУУДЛЫГ ЗАДЛАН ШИНЖЛЭХ НЬ. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .35

ШАРЫН ШАШИН ОРДОСТ. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .47

НИНШИЯНЫ ХОТОН ҮНДЭСТНИЙ ӨӨРТӨӨ ЗАСАХ . . . . . . . . . .72

ОРНЫ ЦЭН ДҮН СИЯНЫ "ҮХРИЙН ЭВЭРТ" УУЛЫН БУРХАН ШАШНЫ ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .72

ЦАГААН ЛЯНХУА ХОТЫН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА . . . . . . .73

ОЛОН НОХОЙН ЧАРГЫН ТУХАЙ . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .74

МОНГОЛ ЛАМ НАР, ЭРДЭМТДИЙН ТҮВДЭЭР . . . . . . . . . . . . . . .82

БИЧСЭН ЛИ ОРНЫ ТУХАЙ СУДАЛГАА . . . . . . . . . . . . . . . . . . . . .82

ӨВӨР МОНГОЛЫН ЛАМ ДАРАМДАЛАЙН СУДАЛГАА. . . . . . . . . .82

ХАЛХЫН ИХ ЭРДЭМТЭН ЗАВА ХЭМЭЭХ ДАМДИН ГАВЖИЙН СУДАЛГАА . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .83

ПАХИЯАН ХУУШААНЫ ЗАМЫН ТЭМДЭГЛЭЛ. . . . . . . . . . . . . . . .90

ЭРДЭМТЭН АКАДЕМИЧ, ТҮВД СУДЛААЧ Д.ЦЭРЭНСОДНОМЫН НЭЭЛТ . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .94

Хаадын уг эх хэмэээх эртний судраас эшлэл . . . . . . . . . . . . . . . . . .99

ХУТАГТ ҮХЭРТ УУЛАНД АЙЛТГАСАН БУРХАН БАГШИЙН БОШИГ ЛҮНДЭН . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .110

ХУТАГТ ҮХЭРТ УУЛАНД АЙЛТГАСАН БУРХАН БАГШИЙН БОШИГ ЛҮНДЭН . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .128

Ц.ОТГОНБАЯРЫН ТҮВД СУДРУУДААС . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .141

ОРЧУУЛСАН АЖИГЛАЛТУУД . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .141

ЗАЯЫН ХҮРЭЭНИЙ ӨВГӨН ХУВРАГА Г.ЦЭРЭНБАТААГИЙН МЭЛМИЙ ГИЙСНИЙ 100 ЖИЛИЙН ОЙД . . . . . . . . . . . . . . . . . . . . .142

ААВЫН МААНЬ ДУУЛДАГ БАЙСАН УРТЫН ДУУНУУД . . . . . . . . .142

ЛАМ ГУРВАН ЭРДЭНЭ . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .142

ГУРВАН АЧ . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .144

ГУРВАН ЭРДЭНЭ ДОР ДААТГАХУЙ . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .148

ХУРДАН САЙХАН . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .151

ЛХАМ БУРХАНЫ МАГТ ДУУ . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .152

АСАРЫН ӨНДӨР . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .154

ӨВГӨН ХУВАРГА Г.ЦЭРЭНБАТААГИЙН ӨВРИЙН ДЭВТРЭЭС . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .156

НЭГ. ЗАЯЫН ХҮРЭЭНИЙ ЦАМ БҮЖГИЙН ГОРИМ . . . . . . . . . . .156

ХОЁР. ГАНЖУУРЫН ХУРААНГУЙ СУДАР МОНГОЛ ХЭЛ ДЭЭР ОРЧУУЛАН ХҮМҮҮСТ ТҮГЭЭДЭГ БАЙВАА . . . . . . . . . . . . . . . . . .163

ГУРАВ. ӨВГӨН ХУВАРГА Г.ЦЭРЭНБАТААГИЙН ШАШНЫ ОН ТООЛЛЫН ХЭЛХЭЭ СУДАР . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .166

МИНИЙ БУУРАЛ АБУУ МИНУУ . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .170

# БУРХАН БАГШ НУТАГТ МИНЬ ЗАЛАРСАН ТУХАЙ ЭШЛЭЛҮҮД

Сайн цагийн мянган Бурханы дөрөвдүгээр болох Шагжатүв буюу Бурхан багш, 2560 жилийн тэртээ Гурван их галавт буян хурааж, 34 бодьсадва дүр дамжин төрж эртний энэтхэгт илт тугуулгасан Бурхан болсон билээ. Мэндлээд 81 сүүдэр зооглоод нирваан дүрийг үзүүлэх хүртэл хамаг амьтаны тусыг бодоогүй ном сургааль айлдаагүй хором ховор байдаг. Сургаалийг эмхэтгэхэд Ганжуурийн 108 боть түүний тайлбар сэлт 225 боть бий. Ангилавал Винайн, Авидармийн Судрын гэх гурван аймаг савд багтддаг. Бас судар дандарын аймагт хувааж болно. Бурхан багшийн Энэхүү номлолууд дотор Бидний өвөг дээдсийн үед эх нутагт минь иш бошиг үзүүлэн ном номлосон тухай Ганжуурын хураангуй гэгддэг СУНДУЙ хэмээх их хөлгөн судäрт байдаг. “Бурхан багш Үхэрт ууланд үзүүлсэн иш бошиг” сурвалжаар дэлгэрэнгүй тайлбарлахыг оролдож буй билээ. Өмнө энэхүү сэдвээр Зава Дамдин гавж Алтан дэвтрийн хоёрдугаар бүлэгтээ Ли орон бол монголчуудын өвөг дээдэс болох тухай зан заншил соёл иргэншил нэгтэй олон зүйлээр ижил хэмээн бичсэнийг, Эрдэмтэн Ц.Дамдинсүрэн ҮЛГЭР ДОМГИЙН ЛИ орон үнэхээр манай өвөг дээдсийн нутаг гэж бичсэн ба Түүний эрдэмтэн шавь Л.Хүрэлбаатар нь бас багшийнхаа ажлыг үргэлжлүүлэн судалж Тансан лам Баруун газар зорчсон тэмдэглэл тэргүүтэй олон зохиолыг судалж Тансан ламыг монгол нутаг тэр тусмаа ЛИ оронд явж байхад тэндэхийн хүмүүс Бурханд сүжигтэйгээр барахгүй ламтан өөрөө Шанти дэва гэгээний “Бодьсадын явдалд орохуй “бүтээлийг нутгийн олонд номносон тухай түүх намтарыг судалж нийтийн хүртээл болгосон байдаг бол Академич Ш.Бира судлаад ЛИ орныг өнөөгийн хотонгууд гэж хэлдэг билээ. Мөн өөр нэг эрдэмтэн академич Д.Цэрэнсодном бээр судлан шинжилж Эртний ном зохиолд гардаг ЛИ улс болбоос тэнгэрийн орон гэж орчуулагддаг гэдгийг хэл бичгийн шинжлэлээр магдлан үзэж энэ бол монгол нутаг гэдгийг тогтоохдоо хүннү хэлэнд тэнгэрийг ЧЭНЛИ гэх буюу чэн гэдэг нь хаягдаад ли нь үлдэж гэсэн гаргалгаа дэвшүүлсэн. Жишээ нь хүннү хэлэнд үлүү гэдэг үг нь луу. үсүү гэдэг үг нь сүү гэх

зэргээр үг сунжиран ирсэнийг хэл бичгийн ухаанаар тайлбарлаж ЛИ орон бол монгол нутаг маань гэж нээлт хийсэн гэдэг. Тэд хаадыгаа ШАНЮ гэдэг байсан ба тэр нь тэнгэрийн язгуурт хөвгүүн гэж хүннү хэлнээс орчуулагдаж байгаа нь түүнийг бас давхар нотолж байна. Манайхан ч гэсэн тайж ноён удамтай тэнгэр язгууртай гэх хүмүүс одоо ч олон байдаг нь учиртай. Монголын нууц товчоонд Вөртэ Чоно, Гоо марал хоёроос эхлэн Довуу мэргэн, Түүний хатан Алангоо таван хөвүүн төрүүлж түүний сүүлийн гурван хөвгүүн Бугу хатаги, Бухату салжи, Бодончор нар эцэг тэнгэрт халисаны дараа гарсан хар элэгийн зарц малиг даяны хөвүүн хэмээн гадуурхаж хөөн явуулахад ядарч зовох тэднийг харцагаа шувууд тэргүүт жигүүртэн урьдын улбаагаар хөвүүдийг тэжээн амин зуулаг өргөсөөр том болов гэдэг ба Алангоо өчихдөө үүрээр тооноор хурц шар гэрэл орж нар зөв эргэн гарахад би хээлтдэг гэдэг нь тэнгэр хээлтүүлсэн гэх ба түүнээс хойш монголчууд тэнгэр язгууртай гэж ярьдаг болсон гэж үздэг. Эрдэмтэн их лам Шавран Ишсамбуу бээр монгол хүмүүнийг үүслийг Анааваад буюу дээд тэнгэрийн их далайгаас хун шувуун сүрэг болон байгаль далайд буун ирж түүнээс монгол хүмүүн үүссэн, галт шувуун учир гал махбодьтой, асар тэнгэр байсан учир одоо болтол хоорондоо дайсагналцдаг. Найман гишүүн төгөлдөр амттай анаавад их далайнхаа усыг санагалзан монголчууд өлсөхөөсөө урьдаж ам их цангадаг учир нь тэр хэмээн зохиол бүтээлдээ тусгасан. Үүнийг би туйлын үнэн гэж санадаг. Манай монголын эрт үеийн түүхийг харахад гадны дайсанд эзлэгдсэн нь ховор гагцхүү өөр хоорондоо тэмцэлдэж монголчуудын тамын тогоо харуулгүй өөдөө гарах нэгийгээгээ татаж унагадаг тул харуул хэрэггүй гэж гадныхан шоглож ярьдаг нь үнэний ортой. Саяхан японд Сумо бөхийнхөө түрүүг монголчуудаас яаж авах бэ хэмээн арга бодоцгоож зарим нь монголын түүхийг судлаж гэнэ. Тэгээд монгол хүн гадны хүнд дийлдэхгүй зөвхөн өөрснөө бие биенээ дийлэхийг японручууд ойлгоод хакүхо Даваажаргалыг хүргэнээ болгож япон хүнийг сумо д ялуулсан гэх онигоо байдаг. Иимээс бид эвийг хичээх чухалтайг сануулсан ишлэл юм. Дээр дурьдсан Алангоо хатны гэрлээр хээлтдэгийг эргэлзэж байгаа бол тиймэрхүү жишээ бий, тогос хэмээх ганган шувуу гагцаар байхдаа тэнгэр их дугарч бороо орох үед хээлтэй болдог сонин үзэгдэл одоо ч байсаар байна. Мөн Заваа ламын хорчойнжун буюу монголын түүх бүтээлд эзэн богдыг хаан ширээнд залах ёслолын үед нэгэн үл танигдах шувуун нисэн

ирж гурав тойрон Чингис Чингис Чингис хэмээн дуугарснаар Хааны алдарыг ЧИНГИС ХААН хэмээн нэрийдсэн. Түүгээр үл барам түүнийг их хүч чадал нууцын эзэн Очирваан бурханы хувилгаан хэмээн тайлбарлаад эзэн хааны хүч чадалыг Очирваань бурханы хувилгаан болохоор энэ дэлхийг тохинуулах хүч энергитэй төрсөн тэрнээс энэ дэлхий дээр ухаан заль төгссөн нөхөд цөөнгүй байсан ч түүнтэй адилгүй гэж үздэг. Тэгээд ч манай дээдэс олон бурхадын дотроос Очирвааныг залан тахиж монгол нутагаа даалгасан гэдэг.

Эрдэмтэн академич Д.Цэрэнсодном бээр Хаадын уг эх хэмээх босоо монголоор наймтын барын хэмжээтэй цаасан дээр биирээр бичсэн нэгэн сурвалж бичигт үхэрт хаданд бурхан заларч ном айлдсан гэж дурьдан бичихдээ.күмүсүлүн хэмээх галигласан үгийг "хүмүүн ус" хэмээн монголчилсон байгааг би түвд эх сурвалжийг нь харицуулж үзээд өөр утгатай гамасала хэмээх санскрит үг гэж бодож байна.

Эрдэмтэн Дунгарлувсанпрэнлайн тайлбараар бол сайн цагийн мянган бурхан энэхүү гамасала гэх суварга байгаа газарт заавал заларч ном айлдах бошигтой ба эхний дөрвөн бурхан заларсан гэж үздэг учир дээрх күмүсүлүн гэдэг үгийг хүмүүн ус гэж тайлбарлах нь зохимж багатай гэж үзэж байна.

Тэгэхээр олон эрдэмтэн үлгэр домогийн “ли” орныг эх нутаг минь байсан гэдгийг нэгэн дуугаар нотолж байгааг та бүхэн харж байна тэгвэл одоо үхэрт ууланд бошиглосон зарлигийн талаархи тайлбартаа орвол

1-рт Бурхан багш өөрийн аман гэгээнээрээ айлдсан болохыг хүн бүхэн хүлээн зөвшөөрч Бурханы айлдсан судрын чуулган болох Ганжуурт багтаасан нь уг сударыг жинхэнэ номлооч бурхан болохыг баталж байна

2-рт Энэхүү судар санскрит эх, түвд эх, монгол ганжуурийн эх зэрэгт ямар нэгэн зөрөө байхгүй бүгд л тэнгэрийн тэнгэр гэж Бурхан багши йг нэрлэж байгаа нь Энэтхэгт айлдсан судруудад Бурхан багшийг “гани намжийн чого” буюу хоёр хөлтөний тэргүүн гэж дээдэлж нэрлэдэг бол Ли орныхон бурхан багшийг дээд манлай хэмээн тэнгэрийн тэнгэр буюу ли орны тэргүүн лидэр гэсэн утга илэрхийлж байгаа нь манай нутгийг тэнгэрийн орон гэж тодорхой нэрлэсэн нь тэнгэрүүдийн оронд заларч багш болж хүндлэгдээд

тэдний манлай гэсэн утгаар бичигдсэн нь бас нэг нотолгоо гэж бид үзэж байна.

3-рт Бүх эх болох ганжуурт ЛИ орон гэж ямар нэгэн өөр дуудлаггүй өөр шилжсэн утгагүйгээр түвд санскрит монголоор бичиж байгаа нь ЛИ орон гарцаагүй байсан Бурхан заларсан гэдгийг ямарч эрдэмтэний маргаангүйгээр харуулж байна.

Хамгийн сонирхолтой нь Бурхан ном номлосон “үхэр уул” гэх газар олон байдаг. Непалд Бурхан багш мэндэлсэн Наганзана мөрний ойролцоо зүүн хойд талд, Энэтхэгийн хойд тал жаму касмир муж эртний моголчуудын орших тэр нутагт, түвдийн амдүүд гэх гурван газар байдаг боловч тэдгээр нь газарзүйн хувьд таарахгүй байгаа юм. Яагаад гэвэл Үхэрт ууланд бошголсон судартБурхан багш тус газарт заларч хойшоо харан зогсож ирээдүйд миний шашин умраас умарт дэлгэрнэ гэж бошголон адисласан гэтэл непал, энэтхэг улсын хойно одоогоор Бурханы шашинт улс орон байхгүй байна. Нөгөөтэйгүүр Үхэр уул нь байдаг ч ЛИ орны газарт багтахааргүйгээр барахгүй хатан гол нь ч байхгүй байгаа нь үүнийг дахин нотлоно.

Тэгэхээр энэхүү эрээд байгаа газар маань

1-д хатан голын ямар нэгэн онцгой бэлэгдэлтэй эрэг газар,

2-д Үхэрт уултай холбогдох нэршилтэй газар,

3-д хэзээ үл эвдэрэх адист суврага байх гэсэн гурван номинац хангах хэрэгтэй болсон гэж бид үзсэн.

Үүний тулд Дэлхийн монгол туургатан бурхан шашинтны их хуралын тэргүүн болох миний бие Ц. Отгонбаяр гишүүд болох, ОХУ ын сангхийн Ширээт буряд лам Балдан Базаров, Халимаг лам Орогхар Цырэндоржиеев , Тива лам Санжай, Өвөрмонголын шанши муж Сиян хотын өршөөлийг дэлгэрүүлэх хийдийн дэмчи лам Баянсан,

Өвөрмонголийн өөртөө засах орны соёлын яамнаас Буян, манж судлаач Өлзиймэнд, газарчин Хас тэргүүтэй хээрийн судалгааны баг 14 хоногийн томилолтоор хатан голын ай сав буюу Ордос хошуугаар хатан голыг даган 2500 гаруй км газар аялсан юм.Аялалын үр дүнд Бурханы шашин дэлгэрч байсан тухай олон баримтуудтай олж танилцсан.

Жишээ нь Ордсын зүүн талд орших Далт хошуунд байх Бурхан багш заларсан гэх бурханы сэрэг дүр бүтээсэнтэй танилцлаа.

Далт гэх үгэн дээр олон тайлбарыг нутгийн өвөгчүүлээс олж сонссон.

Дээр үед хонины далаар мэргэлдэг ба хонины дал бол одоогийнхоор нэрийн хуудас болдог ба тэр айлын хот, хар цагаан хил ам хүний омог зэргийг тус айлын далаар шинжиж шууд бодит мэдээлэл хэлдэгээс гадна түүнийг уул овоондоо өлгөж байгаль дэлхийдээ гэр орноо танилцуулах нэрийн хуудас болгон шүтээндээ хадгалуулан даатгадаг байжээ.

Одоо ч зарим газар тэгдэг.Мөн монголчуудыг төвдүүд Согбу гэж дууддаг үүнийг орчуулбал далт гэсэн үг болдог бөгөөд дал шүтлэгтэн гэх дээрх утгатай дүйж байна. Ордосын урд талаар хил залгах шанши мужийн зааг дээр орших МЭ 2-3 зуунд хамрагдах бурхан шашинтай байсан гэх БөөБөө хааны хотын туурьтай танилцлаа. Чингис хааны онгонд бараалхлаа. Эзний отогоор орлоо. МЭ 6-7 зуунд хамрагдах Аржийн уулын сүмээр орж танилцлаа.Энэ нь үнэхээр уул нүхэлж хаданд сууж дияан хийдэг архад лам нарын дэлхийд байхгүй хосгүй өв байлаа.Ингэж тойрч явахдаа үхэрийн холбогдолтой үхэр толгой үнээн хад гэх арваад газар очисон боловч хатан гол , суврага хоёроосоо хол эсвэл аль нэг нь байхгүй байсаар арга барагдуулж сүүлдээ манай хамт яваа нөхдүүд өөрсдийнхөө төрсөн газар луу ойртуулах арга хүртэл хийж хатан гол манай нутгаар урсаж байгаад урсгалаа солисон гэж хүртэл хэлж байсныг нуух юун.

Зарим маань залхаж бүтэн тойроод явж байтал гэнэт нэг шавар дагзанд амьдардаг ядуувтар тосгоны дэргэд эртний сүмийн туурь байхыг үзээд тэндэхийн хүмүүсээс асуугаад мэдэхгүй тул Өвөрмонголын архивийн хүмүүстэй утсаар холбогдон асуухад нисэж ирсэн сүм нэртэй байхаас гадна ойрхон үхэр хадан хошуу нэртэй газар байдаг бөгөөд түүнийхээ билиг тэмдэгээр бухан хөшөө босгосон хөх хотоос баруун урагш 150км орчим өвөр монголын чиншү хошуу шанши мужтай хиллэдэг ЛЕОНИВАН гэх газар очтол хатан гол маань огцом мушгирч яг хос загас шиг урсгалтай сайхан газрыг олж хараад найман тахилын нэг болох бэлгэдэлтэй газар гэж бид баярлаж сууж байтал нөгөө эрэг дээр нь хуучин харуулын цамхаг харагдав.. Ядан байж очиж үзвэл цаахан нь 100 м газар

хуучны дуган суварга бараг эвдрээгүй байсанд бид үл эвдрэх адист суврага хэмээн дуу алдацгааж тус газрыг энэ гэдэгт манай шинжилгээний баг найдвартай нотолсон олсон гэж ойлгож байлаа. Яг ном дагуу Хатан гол тэгэж хос загас шиг мушгирсан газар өөр байхгүй үхэрт хошуу нэртэй тохой,. үл эврэх адист субрагтай газар энэхэн дэлхий дээр өөр хаана ч үгүй бөгөөд цагаан хэрмээс хойш хүннү гүрний нутаг тул эх монгол нутагт минь Бурхан багш морилон саатаж ирээдүйд миний шашин умраас умарт дэлгэрнэ гэж бошиглон үлдээсэн газар гэдэг нь дээрхи гурван асуулганд таарч нотлогдлоо гэж бидний олон улсын баг үзэж энэ удаагийнхаа гурван улсын бүрэлдэхүүнтэй судлаач эрдэмтэдийн багтай 3000 орчим километр зам хатан голоо даган ордосыг нар зөв тойрон туулж 14хоног зарцуулсан аялал маань амжилттай төгслөө.



*Эзэн Чингис богдын онгоны дэргэд Өвөр Монгол лам Баянсан, Оросын холбооны улсын Буриадын лам Балданбазаров нарын хамт.*



*Гурван мужийн уулзвар дахь Үхэрт хавцал.*



*Хавцал дээрх суварганы суурь.*



*Өвөр Монгол лам Баянсан, Оросын холбооны улсын Буриадын лам Балданбазаров, Өвөр Монголын соёлын хорооны ажилтан Буян нарын хамт. Үхэрт хавцал дахь хийдийн туурь*



*Өвөр Монгол лам Баянсан, Оросын холбооны улсын Буриадын лам Балданбазаров, Манж судлаач Өлзиймэнд, судлаач Амараа нар.*



*Далд хошуун дахь Баясгалангийн сүм. Бурхан заларч ном номолсон түүхтэй.*



*Шанший муж МЭ 4-р зууны Бөөвөө хааны байгуулсан Цагаан хот.*
*Бурханы суваргын дэргэд.*



*Ордос, Аржийн сүм уулын агуй дотор.*



*Аржийн сүм уулын гадна талд.*



*Чингисийн онгон*



*Чингисийн онгоны үүдэнд*

## Бидний явсан анхны аялалын маршрут






## АНХДУГААР ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГИЙН ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ГАЗРЫН МАРШРУТ

2016 оны 3нсард явсан бидний эрдэм шинжилгээний багын явсан товч маршрут хөх хотоос гараад далт хошуугаар орж зандан зуу хэмээн нэрлэгдэх бурхан багшийн босоо дүртэй газраар очиж уг гарвалтай нь танилцав.Түүнийг шагжамүнийн сүм гэж нэрийддэг юм билээ.Байрлал нь Далан хар уулын монь хэмээх ноён оргилоос урагш 50км зайтай хатан голын өмнө эрэг дээр оршдог газар юм.Цааш эзэний хороогоор оров. Сүм байрладаг Чингисийн онгонд бараалхав.Цааш Үйзэн хошууны төв галуут балгадаар дайран тус хошууны хараа сүлд сумаар дамжин шанши мужид орших цагаан лянхуан хотын туурийг үзэн судлав. Тус балгад нь өвөрмонголын хил болон хятадын шанши мужийн зааг дээр байрладаг.Батын тохой гэж бас нэрлэдэг газар ойрхон байв. Монгол угсааны зүүн Жин гүрний үеийн Хайлан БөБө хаан бээр байгуусан бөгөөд хаан өөрөө Бурханы шашинтай байжээ. Олон газар мөргөлийн суварга байгуулсан туурь нь одоо ч харагдсаар байгаа.Тэр хотыг бас Холлян хот гэж тэмдэглэсэн тохиолдол олон бий гэв. Бид хамгийн урд цэг хятад өвөрмонголын хилээс нар зөв эргэн хатан голоо даган ордосын нутгийг гороолохдоо ордосын өмнөд хошуу болох олзоч балгасанд очиж тэндэхийн номын санд орж номзүйн ажил нэг хийв.Тэнд өвөрмонголын түүхч ном цуглуулагч Сундуй гуайтай хөөрөлдөв. Цааш отог хошууны улаан балгадаар оров. энд бас номзүйн судалгаа болон нутгийн хүмүүстэй уулзаж хөөрөлдөв. Цааш хөдлөн хатан голын өмнөд эрэг болох Арвис уулын энгэрт байрлах арзайн агуйн сүмд бараалхав. Энд үнэхээр олон агуйн сүмүүд бараг хэвээрээ шахуу хадгалагдаж үлдсэн маш сайхан ховор бурханы шашины дурсгалт сүмүүдийг нүдээр үзэж сайхан явлаа. Мөн бид хөдлөөд Отог хошууны олон нохойн чарга буюу Чингисийн зуун худаг гэдэг газар очиж эзэн богд маань ямар хэрсүү д ухаантай болохыг олж үзэн биширч явлаа. Биднийг Шинзо сумын дарга Үнэр дагуулан өөрийн нутаг орныг танилцуулж өвөрмөц онцлогтой зоог барин дайлав.Ингэж ордосыг нар зөв гороолов.Тэгээд цааш Зүүнгар хошууны төвд очиж тэндэхийн орон нутгийн байдалтай танилцав. Дараа нь хөххотын Чиншихэ шинин гэх газраар явж байгаад Пилаши

буюу нисэж ирсэн сүмтэй тааралдаж түүхийг нь асууж сураглаваас маш их анхааран судлах зүйл маань болж Хувилай хааны үед харуулын цамхаг байсан сүм шиг газрыг санамсаргүй олж асууж суртал алдарт Лониван буюу Үхэрт тохой нэртэй газар хатан гол хос загас мэт эргэж тохойрсон эмэгтэйчүүдийн сүмтэй суваргатай бидний хайсан газар мөн байлаа гэж үзсэн ингээд аялал маань хөх хот орж хурал хийгээд өндөрлөв.

Хос загасны бэлэгдэлийн талаар өгүүлбэл ээл ивгээл өгдөг өлзийт найман тахилын нэг ба манай төрийн сүлд болсон соёмбын голд ч байрладаг арга билгийн дээд хос төрт ёсны улбаа хэзээд ч үл аних төрийн мэргэн хараа зэргийг билэгшээсэн байдаг нь Бурханы номын дуун адистэдийн хүч хэзээ ч тасрашгүй гэдгийг сануулах маш сайхан бэлэгдэлт газар байлаа. Бидний нээлт хийсэн гээд байгаа газраас 5км зайд байх нисэж ирсэн сүмийн тухай өгүүлбэл: тэндэхийн хүмүүс эрт дээр үед нэгэн бороо орж манан бууугаад манан бороо арилахад энэхүү сүм гэнэт харагдсан гэдэг домогтой хэдий үеийг нь мэдэхгүй гэж тайлбарладаг юм билээ. Бурхан багш бээр энэхүү газар ном номлоход ядаж ном айлдахыг хүссэн өглөгийн эзнээс гадна олон мянган архад даажинба нөхөр сэлт хуран цуларсан гэж уг номонд бичсэн байдаг.

Тиймээс тэдгээр ирт чадалт шавь нар нь үүл хөлөглөн орд хийдээ ирт хувилгаанаар барьсан байж болох талтай

## ХОЁР ДАХ УДААГАА ӨВӨРМОНГОЛД ХИЙСЭН ЭРДЭМТЭДИЙН БАГИЙН ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭ

Дээрхи эрдэмтэдийн багаас цөөхөн хэсэг нь Бурхан багшийн ном номлосон газрыг дахин нэг үзэхээр аялалдаа гарав.Яагаад гэвэл Алшаа нутгийн ахмад эрдэмтэн Алшаа судлалын удирдагч бас тэр нутгийн эрдэм соёлын ордоны дарга эрдэмтэн Цогт гуай бидний аялалыг сонсоод олон удаа өгүүлэг тавьж нэг удаа нутагт минь ирж үзээчээ.Эртний үгэнд зуу сонсохоор нэг үз гэж байдаг гэсээр биднийг дуудаж бид анайхан л хөх хотдоо цугларч аваад хөх хотоос зүүн урагш Вагоноор өдөр шөнө 24цаг орчим 800 гаруй км яваад Ниншагийн хотон үндэстний өөртөө засах оронд ирэв.Биднийг Цогт тэргүүтэй албаны хүмүүс угтаж авав. Биднийг дагуулаад Чинтүнша хошуунаас зүүн урагшаа 20км яваад НЮ ШҮ ШАН буюу үхэр тэргүүт ууланд авчирлаа. Тэнд хятад хүмүүс Бурхан ном айлдсан газар хэмээж олон сүм хийд барилга дүүрэн байв. Аль нь хуучны аль нэг шинэ барьсан болохыг Цогт гуай тайлбарлаж байлаа. Үнэхээр хатан гол нь хажуудаа үхэр тэргүүт уултай олон янзын суваргатай гаас гадна одоо болтол хүмүүс Бурхан багшийн жил бүр болдог их баяр дүйцэн өдрийг тэмдэглэдэг. заншилтай бурханы орон байлаа. Нэг заншил нь Зуны тэргүүн сарын 15 ны Бурханы гурван их баяраар эндэхийн хүмүүс олноор ирж уншлаганд суугаад дараа нь хатан голд хэдэн арван машинаар нь амьд загас өргөдөг ёслолыг Бурхан башийн ном номлох тэр үеээс уламжлан авсан гэж ярьдаг нь сонин содон санагдаж байв.

Сүүлд нь өгүүлэхэд Саманда бадра буюу ерөөлийн хаан хэмээх сударт: **маонгалбаа** хэмээн долоон удаа ирээдүй сайн сайхан болгохын төлөө адислан буйгаас гадна ТАМЖИДГАДҮ ДАГИ ЧОЙДОНДҮҮ буюу амьтан бүхэнд ойлгогдох тус тусын хэлээр номоо зарлигласан заавал орчуулах шаардлаггүй хэмээдэг. Бас САНЖЭ МИДВИЙ САВЧОГ МИД буюу бурхангүй газар гэж үгүй тул тэнд энд гэж талцан түвдийн бурханы шашин, монголын бурханы шашин , энэтхэгийн Бурханы шашин гэж ангилах нь зохисгүй. Жишээлбэл амтат бурамыг аль талаас нь долоосон ч амт нь адилхан гэж Бурхан номолсончилэн ялгаварлан ангилаж болохгүйг сургасан болохоор монгол нутагт битгий хэл айл болгонд хүн бүрийн дотор бурхан оршин заларч байгаа билээ.

# ӨВӨРМОНГОЛ ЭРДЭМТДИЙН ТАЙЛБАР

## АРВАС АРЖАЙ ОРОН БОЛ ЧИНГИС ХААНЫ НАЙМАН ЦАГААН ОРДЫН ЛИН УЛСЫН ҮЕ ДЭХЬ ТАХИЛГЫН ГАЗАР МӨН

Ренчиндорж (Отго хошууны түүх ойллого
найруулах албан гэрийн дэд хянан орчуулагч)

**Агуулгын товч:** Арвас аржай орон бол Чингис хааныг тэнгэрт хальсны дараа хамгийн анх гэрээсэлсэн шүтээний цагаан ордыг байгуулсан газар болох мөртлөө XV зууны дундуур хамаг монголын ерөнхий шүтээн найман цагаан орд анх бүрэлдсэн газар болно. Өгүүлэлд Чингис хааны тахилгын зан үйл болон Аржай агуйн соёлтой холбогдсон хээрийн байцаалт, тулгар бичиг, домог яриа, эртний бууръ архивийн материалд, Арвас уул Аржай агуй бол Чингис хаан хамгийн анх цагаан орд байгуулсан орон болох бөгөөд Лин улс, умард Юаны үед Чингис хааны найман цагаан ордыг эрхшээн тахиж байсан газар болохыг нотолсон байна.

**Зангилаа үг:** арвас аржай, цагаан хорго, найман цагаан орд, хишигтэн сүм, тахилгын газар

Ордос нутаг буюу Бор тохойн орон бол эзэн Чингисийн найман цагаан ордыг эрхэмлэн тахисаар ирсэн түүхт газар юм. Ордос гэдэг нэр бол угтаа Чингис хааны их ордыг сахин хамгаалж байсан олон овог аймгаар бүрэлдсэн хишигтэн цэргийг зааж байжээ. Тэд монголын өндөрлөгөөс нүүдэллэн Бортохойд суурьшин суусны дараа Ордос гэдэг нэр аймаг бүлгийн нэрийдэл болж хувирсан байна. Чингис хаан 1206 онд монголын их хаадын улсыг байгуулсны дараа уулын аймаг, бүлэг, овог угсааг бүрэлдлийг эвдэж, түмт, мянгатын дүрмийг хэрэгжүүлжээ. Тэгээд эл Мянгатаас их ордыг сахин хамгаалах ба их ордонд үйлчлэх шадар хамгаалагч ба үйлчлэгчийг ирүүлж, олон аймаг бүлэг ба овог угсаатны хүмүүсээр бүрэлдсэн хишигтэн цэрэг буй болжээ. Чингис хаан нас нөхчөсний дараа Чингис хаан болон алтан ургтанд чин үнэнчээр үйлчилдэг хишигтэн нар Чингис хаан болон түүний гэрээсийн шүтээнд тахилга таваг өргөдөг, шинэ нэг аймаг бүлэг болжээ. Юан улс мөхсний дараа ялангуяа монгол хаант улсын нийслэл байсан Хар Хором Лин улсын цэрэгт

талхигдахын үеэр хишигтэн нар монголын өндөрлөг дэх Чингисийн орд шүтээнийг олонтой зайлуулан шилжүүлж, сахин хамгаалж, зуун дамнасан их нүүдэл хийж XV зууны дундуур Бортохойд орж иржээ. Ордосын өндөрлөгийн ноён Оргил-Уран дөш бол хатан голын ар өвөр тохойг багтаасан эртний Ордос аймгийн төв орон болох бөгөөд сүрлэг сайхан Арвасын уул нуруу үргэлжилсэн бэрх бартаатай байлдах бодлогын чухал газар юм. Уран дөшийн оргил дээр Юан улсын үеийн овог аймаг байх бөгөөд дөрвөн цагийн дэлгэрэнгүй их тахилгатай. Овооны тахилга болох бүр овооны 4 талд тус тус арван гурван нум сум агсаж тахидаг:

Чингис хааны найман цагаан ордны тахилгын сүүн цацалд “Арвас алша хаан”-ыг үзэж цацал өргө. Арвас уул Аржай оронд маш олон “цагаан хорго”, “олон хорго” гэх мэтийн эртний бууриь илэрсэн зэргээс үзвэл бартаат ууланд монголчуудын ерөнхий шүтээн болсон найман цагаан ордыг урт хугацаагаар оршуулан тахиж сахин хамгаалж байжээ.

Тус өгүүлэлд Чингис хааны тахилга болон Аржай агуйн соёлтой холбогдсон хээрийн байцаалт, тулгар бичиг, домог яриа, эртний буурь, архивийн материалд суурьлан Арвас уул, Аржай уул бол Лин улсын үед Чингис хааны найман цагаан ордыг эрхшээн тахиж байсан газар орон болохыг цаашид нотлох гэсэн юм.

**Нэг. Арваг- арбус-арбас**

Одоогийн Арвас гэх уул усны нэрийдэл болон засаг захиргааны хуваарийн нэрийдлийг XX зууны дунд Арвас гэж бичиж байсан юм.

Арвас гэх нэрийн эрэлтийн тухай түүхэн тэмдэглэл ховор бөгөөд ардын дунд “Арбазэнэд” гэх тарнийн үсгээс улирч ирсэн гэх буюу “Ирвэстэй уул” гэдгийн “Ирвэс” үсэг хувирган “Арвас” боллоо гэх мэтчилэн ярьдаг. Өвөр Монголын Нийгмийн Ухааны Хүрээлэнгийн судлаач Н.Батжаргал “МНТ” дахь газрын нэр “Арваг”, “Цуухад”-ыг шинжлэх нь” гэх өгүүлэл нийтэлж.

“МНТ”, “Судрын чуулган” зэрэг түүхэн тулгуурт тэмдэглэсэн газрын нэрсийг шинжлэхээр дамжаад “МНТ” дахь “зуур өвөл” Арвагийн олон хуланг авалваас Чингис хаан зост борыг унаж бөлгөө.

Гэдгийн “Арваг” бол одоогийн Арвас мөн гэж нотолсон юм.

Миний үзэхээр “Арваг” гэсэн үг дуудлагын талаар ба дүрсийн талаар “Арвас” болж хувирах бололцоо их буй. Монгол хэлний ярианы хэлэнд монгол үсгийн богино эгшиг гээгдэн хэлэгдэх үзэгдэл тэнд тохиолддог. Иймээс “Арваг” гэсэн үг амаар дамжигдахдаа “а” эгшиг нь гээгдээд “арваг” болж бичигджээ. Тэгвэл Уйгаржин монгол үсгийн “а” ба “с” авианы бичлэгийн дүрс маш ойролцоо байдаг болохоор хуулан бичих явцдаа үргэлж хутгалдаж, эндүү бичих явдал гардаг. Хэвлэлийн үйлс хөгжөөгүй тэр үед олон дахин гараар хуулан бичих явцдаа “а”-г “с” –р бичснээс болж “арваг” нь “арвас” болж хувирчээ.

“арваг”, “цуухад” бол богд Чингисийн эцсийн мөрөө үлдээсэн дархан орон юм. Арваг уулын хойд хэсгийн нэг өвс мод сахлаг, гол ус тунгалаг Бортолгой гэх уулын орой дээр Чингис хааны барьсан ташуур нь унснаас “эвдэрхий төрд хорлолтой энх төрд нутаглалтай үл буу үдлэлтэй үдэх хүн амралттай газар болмуй” хэмээн энэ газрыг шагшин бахархсан гэдэг. Одоогийн Мин ши балгасны эх булаг гацаанд Бортолгой гэдэг уул буй. Тэр нь яг саяхан Чингис хаан зургаа дахь удаа Тангууд улсыг дайлах үед хатан голын тохойгоор ордост орж ирсэн зам дээр байдаг. Бортолгой уулын зүүн бэлд “Хоргот” гэсэн буурь (зураг 1) буй. “Алтан ордны тайлга” гэх номд: Богд Чингис Тангуудад аялах зам зуур эндэх Бортолгой гэдэг газраар өнгөрөхдөө барьсан ташуур нь гэнэт унасанд дагагсад нь доор нь авч өгөх гэсэнд Чингис хаан авахуулсангүй. Энэ л лав нэг учир буй миний үзэхээр энэ газар бүү буу бэлчээрлэлтэй. Өвөөлж шувуу дүрийг байгуулалтай. Энэ бие жаргалтай. Энэ бие жаргалтай их сайн газар амой. Хожим намайг үхвээс энд оршуулвал зохимой” гэж сургаал хайрласан тухай Ордост удаан жил уламжлагдсан домгийг тэмдэглэжээ.

Чингис хаан хальсанд эзний алтан хүүрийг хасаг тэргэнд тээж дахин энэ газраар өнгөрөхөд хасаг тэрэг болдод хүртэл шигдэж хүлэг мориор хөтлөн ядав. Сөнидийн Гөлгөдэй баатар “эзэн богд анх үүгээр явахдаа бахархан зарлиг болсны шалтгаанаар эдүгээ тохой хасаг тэрэг чинээ шигдэв” хэмээн мөргөн очиж, өмссөн цамц, өргөө гэр өрөөсөн оймсыг тэнд онголсон.” (5)-оос арвас оронд Чингис хааны цагаан онгон шүтээн гэх номын хуудсанд хамаг анх буй болжээ. “Чингис хааны онгон шүтээн” гэх номын хуудасны эхэнд “...түүний отгон хөвүүн Тулуй (1887-1232) болон өрлөг ноёд чандрыг

нь эх нутагт нь хүргэж явах зуур мунийн хошуу (Ордос)-т, (Эзний цагаан орд) байгуулан (Хан их зайсангуудын тулга хамаг улсын шүтээн) болгон тахиж" (6) гэсэн нь яг энэ учрыг хэлж байгаа юм. Иймээс монголын хааны ордны дэргэдэх Урианхай түмний сахьсан "ар тахилбар" (7) гэж нэрийдэж байсан хамаг монголын ерөнхий шүтээн нь хожим хэдэн удаагийн шилжилтээр дамжаад XҮ зууны дундуур Ордос нутагт орж ирээд хамгийн анхны гэрээс шүтээний цагаан ордыг байгуулсан арбас оронд найман цагаан орд гэх хамаг монголын ерөнхий шүтээн анх бүрэлджээ

**Хоёр. Цагаан хорго-сүлд уул**

Отго хошууны уулын арвас сумны хэмжээнд "хорготˮ, "олон хорго", "цагаан хоргот" гэсэн нэртэй газрууд байдаг. 2001 оны 6-р сард миний бие хошууны түүхийн дурсгалт зүйлсийг хамгаалж хамаарах газрын дарга Батжаргалтай хамт "Цагаан хорго" гэсэн нэртэй хоёр газарт очиж үзсэн юм. Нэг нь Арвас сумын засгийн ордны суугаа газар Идэрмаагаас баруун хойш 15км зайтай байгаа Цагаан гол хэмээх уул гуу дахь чулуугаар өрсөн дөрвөлжин хэлбэрийн бууринууд болно. Нөгөө нэг нь Аржай агуйгаас өмнөш 5км-т буй. Түүнийг их цагаан хорго гэж хэлдэг. Энд цагаан голын цагаан хорго шиг тийм чулуун хашаан буурь байхгүй. Зөвхөн монгол гэрийн бууринууд байсан нь бүүр түүр мэдэгдэнэ. Түүний араар нь байгалийн аяндаа бүтсэн зүүн баруун чиглэлтэй чулуун хэрэм бий. Цагаан хорго гэх нэрлэлтийн тухай нутгийн хүмүүсээс асуугаад сурвалжилсанд тэд зөвхөн аль эртнээс Цагаан хорго гэж хэлдгийг мэдэхээс биш чухам малын хашаа хоргын хорго юмуу, эсвэл шан хоргын хорго юмуу гэдгийг мэдэхгүй байлаа.

Монголчууд ван гүн язгууртны суурьшалыг хорго гэж хэлдэг. Жишээлбэл: Их зохиолч Инжинаашийн эцэг Ванчинбалын ордыг "шударга бат хороо" нутаг хошууны вангийн ордон засаг яамыг отог шан, отог хорго, Чингис хааны найман цагаан ордыг энд нууцаар зээлэн тахиж байсантай холбоотой. Ялангуяа эдгээр хоргонуудыг "улаан хорго", "чулуун хорго", "хонин хорго" гэж хэлэхгүй харин "цагаан хорго" гэж хэлдэг нь монголчууд цагаан өнгийг дээдлэхтэй холбоотой. Мөн "цагаан орд", "эзэн хорго" гэдэгтэй холбоотой юм. Иймээс эдгээр Цагаан хоргонууд бол Чингис хааны найман цагаан орд зээлж байсан бууринууд байх ёстой. Ялангуяа "их цагаан хорго" гэх нь сүүлийн үе Чингис хаан Бөртгөлжин хатны цомцог ордны

оршин саатсан газрыг “их эзэн хорго” гэдэгтэй маш ижилсэж байгаа юм.

Уран дөш оргилоос өмнөх Цанхагийн голын эхэнд, бусад уулаас салангид үзэгдэх нэгэн шүрэн уул бий. Үүнийг нутгийн хүмүүс Алаг сүлдний уул гэдэг. Одоогийн Үхэи хотын Хайнан тойргийн зүүнд бас нэгэн шүрэн уул байхыг Хар сүлдний уул гэдэг. Дундад улсын ардын чөлөөлөх цэргийн ерөнхий яамны газраас 1968 онд хэмжин зурагласан 1:50000-н газрын зураг дээр “Сүлд уул” гэж тэмдэглэж байна. Сүлд тахилгын зан үйлд жил бүрийн их бага тахилгаас гадна Хар сүлдийг луу жил тохиолдох бүр тогшуулах, Алаг сүлдийг барс жил тохиолдох бүр тогшуулах бөгөөд цаг төрийг үймээн, хулгай дээрэм хулхидах, ган гачиг болох, хэжиг өвчин дэлгэрэх зэрэг ер бусын учир тохиолдох бүр сүлдээ өндөр уул хайрханы оройд залан тугшуулж, элдэв муу юманд даралга хийдэг. Иймээс Хар сүлдний уул, Алаг сүлдний уул бол тухайн үед дайнд мордох буюу ямар нэгэн шалтгаанаас болж сүлд тугшуулах үед хэрэглэж байсан талбар болно. Сонсолтоор дээр зууны үе болтол Алаг сүлдний уулын хажууд төмөр дуулга байсан гэнэ.

**Гурав. Хишигтэн-Дархад**

Арзай агуйн сүмийн тухай “Отог хошууны ойллого”-ын түүхийн дурсгалт буурийн хэсэгт: “Юан улсын үед эндэхийг сахин хамгаалж байсан хишигтэн аймгийн ноёны байгуулсан шүтээн сүм болно” гэсэн бөгөөд С. Нарсан, Төмөрбаатарын найруулсан “Ордосын сүм хийд” гэх номонд ч “уламжлалт яриа ба зарим мэдлэгтний хэлэхээр Юан улсын сүүлч буюу түүнээс орой шиг үед хишигтний ноёноос газрыг сахин хамгаалж сууж байхдаа хэрэглэж байсан агуй гэдэг” гэв.

“Монголын нууц товчоон”-д тэмдэглэснээр 1206 онд Чингис хаан Их Монгол улсыг байгуулж, урьдын наян хэвтүүл, далан торхагаар бүрэлдсэн хишигтнээ өргөтгөж түмэн хишигтэн болгов. Хишигтэн цэрэг нь түмэд, мянгад, зуут, аравтын ноёдын хөвгүүд ба төрийн хүний хөвгүүд хийгээд тэдний дагуулсан нөхдөөр бүрэлдэж, Чингийсийн гавъяат шийдийн ургаас ахлагч томилдог болохоор хишигтэнд олон овгийн хүмүүс оролцсон байна. Гэтэл түүний ноёдоос эхлээд энгийн цэрэг хүртэл Чингисийн алтан ургтны хүн байдаггүй. Өвөр Монголын багшийн их сургуулийн багш Нацаг-

Өлзий “хишигтэн хийгээд дархад” гэх өгүүлэлдээ дархан хийгээд хаан төрийн тахилгануудын харилцаанд задлалт хийж, Дархадын эл талыг хишигтний холбогдох талтай харьцуулан судлаад “Дархад бол Чин улсын үед арван чуулганаас дээш татварлагдсан хүмүүс биш, харин 13-р зууны үеийн хишигтний хойчис болно гэж нотолсон юм. Хишигтэн цэргийн ноёд чэрбий цолтой. Хишигтэн нь ажил үүргээрээ олон арван тушаалын нэр цол хэрэглэж байв. Тухайлбал: буурч, шилбич, шүүрч, зулч, үүдэч, бэлэгч, засуулч, хорчи, үлдэчи., баатар, бичээч, зальч, шувууч, агтач, тэмээч, хоньч, морьч, харчи гэрийн хөвгүүд инч (хамаарагч), улаач, хулгайч, хөтөч зэрэг болно. Сүүлийн үеийн дархдад мөн хишиг гэх зохион байгуулалт байх бөгөөд хорчи нар, алтан алтан чэрбий, засуул, засуулч, хариулч, шүүрэгч, харвуулч, шилбичин, зулчин гэх мэт олон хэсэг яам үүрэг тушаал байдаг болохоор дархад бол хишигтний хойчис болох нь илэрхий байна.

Иймээс Арзай агуйн сүмийг хишигтэн аймгийн ноёны байгуулсан шүтээн сүм, хишигтний ноён энэ газрыг сахин хамгаалж сууж байхдаа хэрэглэж байсан агуй гэдэг нь цөм Арзай агуй бол дархадын сүм байжээ гэсэн үг юм. Монголд бурхны шашин дэлгэрсэний дараа, Чингис хааныг Очирваанийн хувилгаан хэмээн бурханчлан тахисан найман цагаан уртын тахилгад тусгайлан уншлага бясалгал хийдэг нингүрэв хурах дархдын сүм хийд бий болсон байна. Үүнээс үзвэл Арзай агуйн сүм нь арвас уулны бартаатай газарт нуун хадгалж, нандигнан тахиж байсан Чингис хааны найман цагаан ордны тахилгат бясалгалын ном уншдаг сүм байжээ.

Мин улсын үед, Гүнбилэгт мэргэн жонон Ордосын олон ястан овогтныг есөн хөвгүүндээ хуваан захируулахад уулын отог хошууны нутаг дэвсгэр дээрх хэхүд шувуучин, урад тангууд отгуудыг хоёрдугаар хөвгүүн Байсанхорлон захируулжээ. Тэдгээр отгууд бүр Чингис хааны найман цагаан уртын тахилгад алба үүрдэг дархад байжээ. Шувуучин отгийн нутаг дэвсгэр одоогийн отог хошууны хойд хэсэгт байсан гэдгийн Арзай агуйнаас зүүнш хориод километр зайтай байгаа шувуучин гэх эртний газрын нэр хэрэглэж байна. Даруй хишигтий хойчис болох дархдын шувууч нэр үгээр суурьшиж байсан байна. Баруун гурван түмнийг ордос түмэнд саатуулан тахисан цагаан гэрийн тахилганы үйлийн тухай “Их хуримын ёсон” хэмээх бичигт: Ордос түмний өргөх зуун гэм албаны дотор “хэхүд

шувуучин, дотроо тангуудад найм" гэж бичиж байх нь арзай арвас орчмоор нутаглаж байсан шувуучин аймгийн Дархад эзний найман цагаан ордыг сахиж байсан бөгөөд дөрвөн цагийн тахилгат алба өргөж байсныг тусгаж байна.

**Дөрөв. Ботгоны шил-Боть цагаан ботго**

Отог хошууны Мен ши балгасын Мен ши аж үйлдвэрийн тойргоос зүүнтэй, цээл голын хойд дэнжид ботгоны шил гэсэн уул түшиж ус өвөртөлсөн дэнжлэг газар буй. Ботгоны шил гэх газрын нэрийн эрэлтийн тухай арлын дунд хоёр сайхан домог яриа уламжлагдаж байдаг. Нэг нь: Чингис хаан тэнгэрт хальсны дараа, эзний гэгээн чандрыг энд оршуулж, онгоны газрыг түмэн агтын туурайгаар гишгилэн танигдахгүй болгож, мянган цэргээр битүүмжлэн сахиулж, дараа жил болоход нь өвс мод ургаад цэлгэр тал болжээ. Тахилга тайлга хийхийн үед онгоны газрыг оновчтой олж авахын төлөө тэр тухайд нэгэн ботготой ингийг хөтлөн ирээд, ботгыг нь онгоны дэргэд алсан гэнэ. Ингэн тэмээ үрдээ туйлын хайртай нинжин амьтан болохоор хэдий хол зайлуулсан чь хичнээн удаан болсон ч, ботгоныхоо үрэгдсэн газрыг олж чаддаг гэнэ. Тэгээд тахилгын цаг болоход энэхүү ингээр замчлуулж, ингэн тэмээ уяран буйлж нулимс унагаасан газрыг Богд эзний мөнхөд нойрсон газар гэж таньдаг гэнэ. Ингээд ботгоны шил гэж нэрийдсэн гэнэ. Нөгөө нэг домог нь: Энэ шил бол Чингисийн боть цагаан ботгыг уяж байсан болохоор ботгоны шил гэж гэнэ. Эртнээс энд нэгэн хэсэг ембүү хэлбэртэй том чулуу байж, нэг сэжгүүрт нь нүхтэй гэнэ. 2001 оны 6-р сард бид хээрийн байцаалт хийж байхад Баян-өндөр гацааны далаад настай малчин Цагаанхүүхэн энэ домгийг над ярьж өгсөн юм. Тэр хэлэхдээ энэ ембүү хад соёлын их хувьсгал болтол хэвээр байсан юм. Соёлын хувьсгал дунд урвалга гаргагчид Чингисийн юм гэж дэлбэчин хаяж, түүний их хэсэг нь байшин барилгын суурь чулуу хийж, үлдээсэн жижиг жижиг хэсэг нь одоо ч мөн уул уруу дээрээ байсаар гэв. Тэгээд бид хамтаар тэр газар очиж үзсэнд үнэхээр хэмхэлдсэн чулуу газар сайгүй тархаж байлаа.

[illegible]

[illegible]

## ᠭᠤᠷᠪᠠ᠂ ᠪᠣᠭᠣᠷᠤᠯ ᠤᠨ ᠰᠢᠯᠢ — ᠪᠣᠷ ᠳᠠᠪᠠᠭᠠᠨ ᠪᠣᠭᠣᠷᠤᠯ

[illegible]

# АРЖАЙ АГУЙН ДАХЬ ЧУХАЛ ХЭДЭН АСУУДЛЫГ ЗАДЛАН ШИНЖЛЭХ НЬ

С.Сэцэнбилэг “Өвөр монголын номын сан, дэд судлаач санч”

**Агуулгын товч**: Тус өгүүлэлд аржай агуйн судалгаан дахь чухал хэдэн асуудлын талаарх өнгөрсний судалсан амжилт ба оршиж байгаа асуудлыг дэлгэн өгүүлж, аржай агуйн үүсэл хувирал ба судалгааны үнэ өртөг зураг бичээсийн талаар өөрийн үзлээ өгүүлэв. Аржай агуй нь эртнээс үүсэлтэй байж, монгол оронд шарын шашин эхлэн орж ирсэн 1578 оноос Лигдэн хаан баруунш цэрэглэхдээ Ордосыг уулгалж сүм хийдийг эвдсэн 1633 он хүртэлх 55 жилийн хооронд олонх агуй нь засагдан зураг бичээстэй болсон ба Лигдэн хааны эвдэлснээс хойш аажмаар эзгүйрч хаягдав. Аржай агуй нь эртний бөгөөд зураг бичээс нь дөрвөн зуугаад жилийн түүхтэй болж, монголчууд агуйн сүмийн соёлтой байсныг харуулснаараа үнэ өртөгтэй юм гэсэн үзлийг дэвшүүлжээ.

**Зангилааны үг**: Аржай агуй, түүх, уйгаржин монгол бичээс, ханын зураг, судалгааны амжилт, оршиж байгаа асуудал, үзэл.

Аржай агуйн судалгаа явагдаад хориод жил болж байна. Энэхүү хориод жилд Аржай агуйн судалгаа нь агуйн байгуулагдсан түүхийн судлал, уйгаржин монгол бичээсийн судлал, ханын зургийн судлал, орчин тойрон дахь хуучдын судлал ба уламжлал ярианы судлал зэрэг чухал хэдэн суурь судлагдахуунтай болж өрнөөд, тал талын эрдэмтэд билэг эрдмээ илрүүлэн өөр өөрийн үзлээ чөлөөтэй сайхан ярилцаж байна. Үүнд амжилт их, алдас бас багагүй оршиж байна.

Аржай агуйн байгуулагдсан түүхийн судлалын талаар, эрт урьдын Сяньбичуудын байгуулсан дэтүний юүнган агуй ба хяналы лүнгмэн агуй, Гансугийн дүнхуван агуй ба хашин хонгил болон хатан голын урсгал дагуу орон дахь олон агуйн бүтэц хэлбэртэй адилтган шинэчилж тэр үеийн түүхтэй холбон шинэчилж, Аржайн агуйг вэй, жин, өмнөд умард төрөөс эхлэн бараад сияа, ювэн, мин, чин хүртэлх урт удаан түүхэн цаг үед л агуйг байгуулсан гэж зарим судлаач үзсэн байна. Аржай агуй нь урт удаан түүхтэй боловч агуй дотроос эрт үесийн дурсгалын зүйлс илрээгүй нь эртний байдлыг нь ойлгож мэдэхэд баримт дутагдаж байна. Аржай агуй нь эртдээ

зураг бичээсгүй бясалгалын агуй байсан бололтой. Зарим судлаач: "Банчин Зю хэмээгч хийд байгуулагдсан түүх, он жилийн төсөв" гэх бичмэлээр уламжлагдсан товхимолын тэмдэглэл ба 7- р төрийн Дилив хутагт Жамсранжавын дурсамж зэргийг үндэслэн Аржай агуй сүмийг Юань улсын үед 5- р жарны улаан хулгана жил /1336 он/- д Наров ванчин болон дөвчин дилува гэгээн хоёр байгуулсан, Мин улсын үед Дилүв Дамбадоржоор /Ванчин Зуу/ нэрлэсэн 1542 онд сүмийг талд нүүлэгсэн ба Аржай агуй бол гажудбагийн ёсны сүм байжээ гэж үзсэн байна. Энэ магадлал нь Аржай агуй сүмийн хөгжил хувиралын нэгэн цаг үеийн түүхийг үнэнээр тусгажээ. Яагаад гэвэл, монгол оронд шарын шашин дэлгэрэхээс өмнө монголын эрх баригчид төвдийн гажудбагийн ёстныг хүндэлж байжээ. Түмэн засагт хааны үед гарма ламыг тахилын орон болгож байв. Түмэдийн алтан ханы дэргэд Дахлүн нансу гэдэг лам байсан ба гурвадугаар төрийн далай ламын залууд түүнийг ээлжээр явуулав. Тэд бол гажудба ёсны салбар болох гарма гажудба ба Дахлүн гажутбагийн лам нар юм. Тиймээс гажудба ёсны дөвчин /их бүтээлч гэсэн төвд гаралтай үг/ лам Наруба болон Дилэв нар ч ордос түмний ноёнд шүтэгдэн байхдаа ахлан орон эртний аржай агуйд бясалган сууж байсан боломжтой юм. Н. Хурцбилиг судлаачийнхаар Дилэв хутагтын хувилгаан дүрийн төрөл үеийн намтар /эрх цоржийн хувилгааны уг эхийг мэдүүлэх хуудас/ гэдгийг илрүүлэн судалж, хоёрдугаар төрийн Дилэв хутагт Дамбадаржаагаар Аржай агуйг байгуулсан гэдэг мэдээг нийтэлжээ. Энэ бол дээрх мэдээтэй агуулгаар хавитах нэн үнэ цэнтэй мэдээ юм. Дамбадаржаа бол 16-р зууны доор хагасаас 17- р зууны дээр хагаст амьдарч байсныг намтрын зохиолоос төсөөлж болох юм. Тэрээр Аржайн хуучин бясалгалын агуйд бясалгал хийж байсан ба дээр оройг дүн шөнө байгуулаад /Ванчин зуу/ гэж нэрлэсэн бололтой. Тэр үед отогийн ноён банчуг хонг тайжтай лам өглөгийн эзэний барилдлагатай байсан байна. Удалгүй шарын шашин орж ирсний дараа аржайн олон хуучин агуйг засан ашиглаад ханын зураг ба бичээстэй агуй сүм болгон байгуулсан байна. Одоо агуйд байгаа зураг урлалыг ажиглахад өнгө будаг нь соргог бөгөөд уйгаржин монгол үсгийн бичээс нь ч 16- 17- р зууны үеийн бичлэг болгон нь тодорхой байна. Аржай агуй нь монголчууд ч том хэлбэрийн агуйн сүмийн соёлтой байсаныг харуулжээ. Аржай агуй нь эртний бөгөөд зураг бичээс нь ч дөрвөн зуугаад жилийн түүхтэй болж, монголчуудын өвөрмөц агуйн

сүмийн соёлын үнэ өртөгөөрөө даянд гайхагдаж болох юм. Одоо аржай агуйн бүтцийн монгол онцлогийг илрүүлэн судлах нь үнэ цэнтэй юм. Сяньби болон тангуудын үеийн агуй сүмийн онцлогийг ч сайтар судлах хэрэгтэй байна.

Уйгаржин монгол бичээсийн судлалын талаар, хасартан нарын зохиосон "аржай агуйн уйгаржин монгол бичээсийн судлал" /люнины үндэстэний хэвлэлийн хороо, 1997 он/ бол хамгийн анхны бөгөөд дорвитой бүтээл юм. Түүнд аржай агуй дахь уйгаржин монгол бичээсийн үйлдвэр бүхнийг зураглан авч нийтэлсэн нь авралтын ач холбогдолтй ажил болсон бөгөөд хойштоо судалгаанд бодит материалыг олж өгчээ. Бас сийрүүлэл, галиглал, тайлбар хийсэн нь эрдэм шинжилгээний өндөр үнэ цэнтэй болж, энэ талын судалгааг зохих амжилтанд хүргэсэн байна. Тэд бичээсийн бичигдсэн цаг үеийг 15- р зууны сүүлч 16- р зууны эхэн үед бичигдсэн бололтой гэж бичжээ. Миний үзэхээр, бичээсүүдийн дотор 2- р төрийн далай лам Гэндэнжамц /1475- 1542/- ын зохиол "ахуй шүтээний магтаал" байгаа тул бичээсийн бичигдсэн цаг үе нь шарын шашин ордост уламжлагдан орж ирсний дараа байх ёстой. Тодорхой шиг хэлбэл 1578 оноос Лигдэн хааны цэрэг аржай агуйг эвдсэн 1633 оны хооронд бичигдсэн байж таарна. Энэ тухай би "аржай агуйн уйгаржин монгол бичгийн бичигдсэн цаг үеийг магадлах нь" гэдэг өгүүлэлдээ дэлгэрэнгүй өгүүлсэн тул энд нуршихгүй.

Ханын зургийн судлалын талаар, баруун сия улсын бурханы шашины зургийн онцлогтой гэсэн үзэл, чингис хаантай холбоотой гэсэн үзэл, хубилай хаан болон пагба ламтай холбоотой гэсэн үзлүүд дэлгэгджээ. Миний үзэхээр, аржай агуйн ханын зураг нь уйгаржин монгол бичигтэй адил цаг үед зохиогджээ. Ханын зурагнуудын дотор монгол орны бурханы шашины түүхийн зарим хэрэг учрыг тусгасан зураг ч бий. 31- р агуйн ханан дахь нэгэн зургийг зарим судлагчаас "чингис хаан ба алтан урагтны шүтлэгийн зураг" гэж тайлбарлажээ. Гэтэл, тэдний чингис хаан гэж үзсэн тэр хүн нь ламтаны малгайтай байхыг анхаарах хэрэгтэй. Бусад монгол тэрлэгтэй хүмүүсийн тэрлэгийн яг ч хэлбэр нь монголын уламжлалт "авдай хан" гэдэг зураг дахь тэрлэгтэй адил байгаа нь 16- р зууны үеийн зураг болохыг харуулж байна. Мөн 31- р агуйн хананд байгаа зураг хубилай тэргүүтэнд пагба лам санваар өгч байгаа ба ном тавьж байгаа гэж зарим судлаач тайлбарлажээ.

“Пагба ламын дууч” ба бусад түвд монгол түүхэн сурвалж бичигт тэмдэглэснээр, хубилай хаан юзүнаныг дийлж лю пэ шинд сууж байхдаа анх пагба ламтай уулзсан нь 1251 оны явдал байжээ. Хубилай хаанд авшиг өгсөн нь 1253 оны явдал, ба пагба лам араав зүс царайтай байжээ. Гэтэл, зураг дахь лам нь залуу бага насны төлөвтэй биш, дэргэдэх хүмүүсийн алинаас нь ч мяраалаг том идэр насны төлөвтэй харагдаж байна. Миний үзэхээр, энэ зураг нь содномжамц далай лам ба алтан хан нарын уулзалтын зураг болно. Энэ зураг дахь монгол тэрлэгийн янз хэлбэр нь мөн ч монголын уламжлалт “авдай хан” гэдэг зураг дахь тэрлэгтэй адил байна. Миний үзэхээр, энэ зураг бол гурвадугаар төрийн далай лам Содномжамц монгол оронд залагдан ирээд шашины ажиллагаа хийж байгаатай холбоотой. Халхын автай хан 1586 онд түмдэд ирж Содномжамц далай ламтай уулзсан тухай “эрдэнэ тунамал нэрт судар”- т тэмдэглэж байдаг. 31- р агуй дахь бас нэг зурагт нэг хувраг хүн гартаа ламын хөргийг өргөж сөгтгөн байгаагийн араас олон хувраг ба харц нар уулан хавцал шиг газар зогсож залбирч буй. Түүний дээр шиг байрд нэгэн бандидагийн малгай /шарын шашины малгай тай адил/- тай ламыг хүмүүсийн бодолд илэрч байгаа мааниар зурсан байна. Энэ зургийг пагба лам ном дэлгэж байна гэж тайлбарлахаас гурвадугаар далай ламын хувилгаан дүр даруй түргэн илрэхийг даатган залбирч байгаа зураг гэж тайлбарлавал зохих шиг байна. Миний үзэхээр, эдгээр түүхэн зураг бол 1578 онд түмдийн алтан хаан болон ордосын худагт сэцэн хун тайж нар гуравдугаар дүрийн далай лам Содномжамцыг залан уулзалт болсон, 1585- 1588 онд далай лам хоёр дахь удаагаа монголын баруун гурван түмэд ба цахар зэрэг газарт заларсан хийгээд 4- р дүрийн далай лам ёндонжамцыг түмэдээс илрүүлсэн зэрэг түүхэн хэрэг учруудыг тусгажээ. Аржай агуйн ханын зураг бол бүхнээрээ бурханы шашинд холбогдсон агуулгатай бурханы шашины соёлын хууч дурсгалын зүйлс юм.

Зарим судлаач 28- р агуй дахь зургаан ертөнцийн зурагыг “чингис хааны оршуулгын зураг” гэж тайлбарлаад, одоо болтол үзлээ баримталж байгаа нь аржай агуйн судалгаан дахь нэгэн их алдас болж байна. Бурханы шашины сургаалд төрөл сүлжих гурван орон гэж амармагийн орон, дүрстийн орон ба дүрсгүйгийн орон гэж хуваадаг. Гурван орныг дотор нь бас олон тэнгэр ба ертөнцөд

хуваадаг байна. Энэ зурагт амармагийн орны тэнгэр, асур, хүн, амьтан, бирд ба там зэрэг зургаан ертөнцийн байдлыг үзүүлжээ. Зураг дахь хамаг дээд тэнгэр нь тэнгэрийн ертөнц, тэд егүүтгэх зовлонтой байдаг гэнэ. "Чухал хэрэглэгч төгс утгат шастир"- т: дөрвөн махаранз тэргүүтэн сүмбэр уулын үес тутамд байх тэнгэр нар, толгойн алтан уулд байх тэнгэр нар, наран саран одонд байх тэнгэр нар, дамар ууланд байх тэнгэр нар, замбуутивийн ууланд байх тэнгэр нар ба галбарварс модонд байх тэнгэр нар бол амармагийн орны зургаан тэнгэр болно гэж өгүүлжээ. Хоёрдугаар тэнгэр нь асурын ертөнц, тэд үргэлж байлдан үхэлдэх зовлонтой байдгийг олон морьтон байлдаж байгаагаар үзүүлжээ. "Чухал хэрэглэгч төгс утгат шастир"- т: Асур нар сүмбэр уулын доод хөндийгөөс гарч тэнгэр нартай байлддаг. Тэр цагт долоон чингэлдүүр далайд байсан цагаан зүгт баясгагч лусын хаад асур нартай байлддаг. Лус нар асур нарыг эс дийлвээс тэнгэр нартай хамт нэгдэж асур нартай байлддаг. Хэрвээ асур нар дийлвээс тэнгэр нарыг сүйдсэн балгасанд хүртэл үлдээмүй. Тэнгэр нар дийлвээс асур нарыг буулга баригч уулын тал хүртэл үлдмүй. Тэр мэт байлдааны цагт тэнгэр хийгээд асур нарын тэргүүн ба бэлхүүс нь тасар цавчигдан үхмүй. Ертөнцөд буян үйлдэгчид олон болвоос тэнгэр нар дийлж, нүгэл хийгчид олон болвоос асур нар дийлмой. Тиймийн тул буян үйлдэгч хүнийг тэнгэр нар маш хичээж ивээн сахидаг гэжээ. Гуравдугаар тэнгэр нь хүний ертөнц, хүний ертөнцөд дөрвөн их зовлон байдаг ажээ. Гэр дотор бүсгүй хүн уйлж байгаагаар төрөхийн зовлонг, хүүртэй авсны дэргэд хүмүүс уйлж байгаагаар үхэхийн зовлонг тус тус үзүүлжээ. Дөрөвдүгээр тэнгэр нь амьтаны ертөнц, энд таван хошуу мал ба бусад амьтан жигүүртнийг зурж өгүүлжээ. Тэд тэнэг хийгээд үг хэлгүй зовлонтой байдаг гэнэ. "Чухал хэрэглэгч төгс утгат шастир"- т: Олонх адгуус нь гадаад далайн дотор нэг нэгнээн идэн, далайн долгионд өчүүхэнч амаргүй зовдог. Өчүүхэн тархагсан адгуус нь хүний газар дахь эдгээр адгуусан буй. Зарим нь ачигдах зодогдох зовлонтой, зарим нь арьс махны тул алагдах зовлонтой байдаг гэжээ. Тавдугаар тэнгэр нь бирдийн ертөнц, тэд нарийн хоолойтой бүдүүн хэвлийтэй тул өлсөвч залгиж орохгүй өлсч ундаасах зовлонтой байдгийг энд бүдүүн хэвлийтэй бирдийг зурж үзүүлжээ. "Чухал хэрэглэгч төгс утгат шастир"- т: гадаад түйдэгч бирд нь идээ ундааны чимээг үл сонсоно. Дотоод түйдэгч бирд нь өчүүхэн оловч ам нь зүүний сүвийн төдийхөн тул аманд үл багтах,

багтавч хоолой нь хялгасан мэт тул залгиж үл орох, залгиж оровч хэвлий нь түмэгийн төдий их тул үл чадах, чадавч хөл нь дайрсан мэт нарийн тул даан ядан зовдог ба идээ нь ширэм болж хэвлий нь түлэгддэг гэжээ. Зургадугаар тэнгэр нь тамын ертөнц, тэд халуунд шатагдах ба хүйтэнд хөлдөгдөх элдэв зовлонтой байдаг гэнэ. “Чухал хэрэглэгч төгс утгат шастир”- т, тамын ертөнцийг арван найман тамын оронд хуваан өгүүлсний дотроос “чөлөөгүй там”- ийн тухай дүрсэлсэн нь зурагт тусгагдсантай нилээд адил байна. Тухайлбал, тэр тамын дотор арслант их тавцан дээр буян нүгэл хоёрыг ялгагч гартаа цагаан хар тэмдэгт модыг барьсан эрлэг хаан сууж цагаан хар хоёрыг ялгаж, буянт амьтныг цагаан модоор тэмдэглэж дээд төрөлд илгээн, нүгэлт амьтдыг хар модоор тэмдэглэж эрлэгийн оронд өгч засуулмой. Тэр тамын дөрвөн зүг зовхист арслан тэргүүтэй эрлэг, барс тэргүүт эрлэг, үхэр тэргүүт эрлэг, гүрвэл тэргүүт эрлэг, шар өтөг тэргүүт эрлэг, хар өтөг тэргүүт эрлэг, хангарьд тэргүүт эрлэг, ширмэн тэргүүт эрлэгнүүд байдаг. Тэдгээр эрлэгнүүд нүгэлт амьтдыг өөр өөрийн газартаа дамжуулан аваачиж хар уулын завсарт бэлчээрэлтэл суух, толгойг төмөр төш дээр төмөр алхаар цохих, хөрөөдөх, хөлнөөс барьж буцалсан ширмэн тогоонд дүрэх, гар хөлийг төмөр хадаасаар хадан суух, харцгай шувуу дээрхийг цуулж идэх, аманд халуун ширмэнийг цутгах зэргээр засагладаг гэжээ. Бас “бага тамнууд” хэмээх сударт арван таван бага тамыг ярьсны дотор “нохой гэдэс уусныг идэх”, “хуц мөргөж алах болгох” гэж байдаг нь энэхүү зурагт гарч байна. Аряабалын маань зургаан үсэг бол эдгээр эдгээр зургаан ертөнцийн замбуулинг арилган чадагч тарни тул тэнгэр бүрт аряабалын хөргийг зурсан байна.

Аржай агуйн орчин тойрны хуучдын судлалын талаар, зарим газрын нэр ба худаг усны эсвэл эргэлтийг чингис хаан баруун сия улсыг дайлахад бий болсон гэж үзээд, “монголын нууц товчоо”- ны тэмдэглэлээс эш баримт оруулахаар зарим судлагчид чармайжээ. Чингис хаан тангуудыг дайлахдаа одооны отог хошууны нутагт цэргээн байрлуулан сууж байсан тухай эрдэмтдийн судалгаа хүмүүсийг итгүүлмээр амжилтанд хүрч байна. Гэвч, одооны аржай агуйн дурсгалт зүйлд чингис хаантай холбогдох зүйл алга байна. Нэг ч аржай агуй нь чингисийн онгод шүтээн биш. Аржай агуй бол бурханы шашины дурсгалт газар юм.

Аржай агуйн тухай уламжлал ярианы судлалын талаар, цахарын

халзан хаан аржай агуйг эвдэхэд Банчаг ноён хамгаалан байлдаж, цахарын цэрэг олноороо үрэгдэж цусан гол ясан овоо болсон газар нь "цахарын гол", "цахарын овоо" гэж нэрлэсэн гэдэг уламжлал яриа бол аржай агуйд холбогдсон уламжлалт ярианы дотор хамгаас үнэ цэнтэй зүйл болно. Энэхүү уламжлал яриаг зарим судлаач түүхийн үнэн гэж үзсэн байхад, зарим судлаач түүхийн үнэн биш, Лигдэн хааныг манж Чингийн засгийн газар гүтгэж хэлсэн үг гэж үзжээ. Миний үзэхээр, Лигдэн хаан баруунш цэрэглэхдээ Ордосын ноёнтой хямрал гарч Ордосыг уулгалан аржай агуй сүм зэргийг эвдэхгүй бол, юунд ордосчууд Лигдэн хааныг түвдийн бурханы шашиныг эвдсэн Лигдэн хаанаар зүйрлэн хараан, ордос хүний түүхэн зохиол "билгийн зул хэмээх шастирын түүвэр", "Банчин зуу хэмээгч хийд байгуулагдсан түүх, он жилийн төсөв", 7- р төрийн <u>дилов</u> хутагт жамсранжавын дурсамж ба уламжлал ярианд Лигдэн хаан аржай агуйг эвдэв гэж оргүй газар овоо босгож хэлэх вэ? "Лигдэн хаан номт хаан боловч гэнэт зүрхэнд дон орж шашиныг түйвээгээв", "хаан хилэгнэвэл төрөө эвдэе, заан хилэгнэвэл хотоо эвдэе" гэхчлэн монгол түүхэн сурвалж бичгүүдэд Лигдэн хааныг хошигнон тэмдэглэж байдаг. Лигдэн хаан шашиныг түйвээх гэдэг нь гол нь ордосыг уулгалан шүтээн цомцогийг булаах гэсэн ба сүм хийдийг түйвээсэн явдлыг хэлж буй. Лигдэн хаан манжийн цохилтонд учирсан ба зарим монгол аймаг түмнээн нэгэндээ байлгаж чадахгүй болсондоо хилэн төрж, хурц болон төмөг төмөг зэргийг дийлэн дагуулах гэгчээгээр дайн явуулсан нь худал биш юм. тэгээд олон монгол түмнийхээ сэтгэлийг сэвтүүлж дэмжлэгийг алдаад эцэстдээ ялагдлаар төгсчээ. Лигдэн хааны цэрэг аржай агуйг түйвээхэд хамгаалан байлдсан Банчуг ноёныг зарим судалгааны зохиолд <u>юань</u> улсын тус газрыг сахиж байсан хишигтэн цэргийн хойч гэж түүний гарал түүнийг балархай өгүүлсэн байна. Энэ хүний удам гарлыг сагаан сэцэний "эртний товчоо"- д тов тодорхой тэмдэглэж байгааг нэгэнт ирж олоод тодолсоныг минь анхааралдаа авч, хойшдоо зохиолд ёсчилон бичихийг хүсье.

Аржай агуйн судалгаа минь энэхүү түүхэн нууц оньсогыг шинжлэх утгач өөрөөр тайлбарлаж, түүхэн үнэнд нийцсэн зөв дүнг гаргахыг хүсэн ерөөе.

[illegible]

[illegible]

[illegible] ⑪ [illegible] ⑩ [illegible] ⑨ [illegible]

[illegible] ⑬ [illegible] ⑫ [illegible]

[illegible]

① 汤晓芳：《阿尔寨石窟的开凿与藏传佛教艺术传人的年代》，《中国蒙
古学》，2006年第5期，第7—9页。

② 巴图吉日嘎拉、杨海英：《阿尔寨石窟成吉思汗的佛教纪念堂兴衰史》，
风响社，2005年，第37—39页。

③ [illegible] 1999 [illegible] 2 [illegible]

④⑬ [illegible] 100—109 [illegible]

[illegible] 2006 [illegible] 5 [illegible]

⑤⑧ 潘照东：《成吉思汗与阿尔寨石窟》，《中国蒙古学》，2006年第5
期，第71—75页。

⑥《[illegible]》，[illegible] 1986 [illegible] 151 [illegible]

⑦ 巴图吉日嘎拉：《初释阿尔寨石窟第三十一窟壁画》，《中国蒙古学》，
[illegible] 14—18 [illegible]

# ШАРЫН ШАШИН ОРДОСТ

Төмөрбаатар ( Ордос хотын үндэсний
хэрэг эрхлэх зөвлөл дэд хянан орчуулагч)

**Агуулгын товч:** Өгүүлэлд шарын шашин Ордост дэлгэрч, ямар нөлөө үзүүлсэн тухай, Ордосын сүм хийдийн барилгын онцлог шинж хийгээд бурхан шүтээн, тахилгын эдлэл хэрэгсэл, засал чимэглэлийн тухай жич Ордосын сүм хийдийн байгууламж, сүм хийдийн эвдэгдэж сүйдсэн байдлыг тодорхойлон өгүүлжээ.

**Зангилаа үг:** шарын шашин, Ордос, нөлөө

16-р зууны сүүлчээр дөрвөд бурхны шашны шинээр мандсан гэлүгбийн ёсны шашин (шарын шашин) монгол оронд уламжлагдан дэлгэрч, хожмын Монголын түүхэнд маш гүн нөлөө үзүүлсэн байна. Шарын шашин Монгол оронд дэлгэрсэн явдал нь шарын шашны тус биеийнх нь онцлог шинж тухайн үеийн монголчуудад шаардагдаж байсан үзэл санааны нэгдэлтэй байх хэрэгцээ, монголчуудын гай зовлонгоос мултрах гэсэн хүсэл эрмэлзэл жич дөрвөд, монголчуудын газарзүйн байршил, аж ахуй дээрээ бүр нэгдэд малжсан аж ахуй болох онцлог шинжтэй харьцаа холбоотой боловч монголын хаад язгууртнуудын шарын шашинд түшиглэн өөрийн ноёрхлоо бататгах гэсэн хүсэл зорилго болон шарын шашны хутагт хувилгаадын болон монгол язгууртнуудын цэргийн хүчинд түшиглэж дөрвөдийн төр шашны ноёрхох эрхийг эзэмших гэсэн арга бодлого нь шарын шашин монгол оронд уламжлагдан дэлгэрэхэд зам тавьж өгчээ.

Тогоонтөмөр хаан Бээжингээс ухран гарч их Юань улсын урьд өмнө гараагүй бадрал хөгжил эргэлтгүй эцэслэгдсэнээс нааш, монгол оронд дотоодын хямрал үүсч, дөрвөн ойрд, зүүн монголын хооронд, монголын эл их аймаг бүлгийн хооронд байнга дахин дайн дажин үүсч, монгол орон хагацан салсан байдалд оров. Мандухай сэцэн хатан, Батмөнх даян хаан монгол орныг нэг үе нэгтгэсэн боловч дөрвөн ойрадыг эцэстээ эрхшээлдээн оруулж ч дийлээгүй. Үүний дээр даян хаан зургаан түмнийг “алтан ургатан”-даа хуваан өмчлүүлж ноёрхуулснаас түүний нэгтгэсэн зургаан

түмэн ч дэмий удалгүй тусгаарлалын байдалд орж улмаар хагацах тийшээ ханджээ. Түмэдийн алтан ханаар тэргүүлсэн баруун гурван түмэн юуны урьд зургаан түмнээс салж хүчирхэгжээд ноёрхол нь Бор тохой, Гансу, Хөх нуурт хүрч байжээ. Бүх монголыг эзэлхээр зорьж байсан Алтан ханд үзэл санааны зэвсэг ба яриа хэлэлцээний шалтаг юунаас ч илүү шаардагдаж байв. Далай ламаас Алтан ханыг “Хубилай сэцэн хааны хувилгаан”, “мянган алтан хүрдийг эргүүлэгч Загравард сэцэн хаан” гэж тодлон өргөмжилсөн явдал нь хаад язгууртнуудын дунд болон харц ардын дунд найдал буурч байсан тухайн үед Алтан ханд авч хэлвэл ямар ч хас тамга, хан цол орлож болшгүй үйлдэл, төр барих боломж гэрэл гялбаа авчирсан хэрэг болсонюм.

16-р зууны сүүлчээр хутагт сэцэн хун тайж Мандуул монголын нэг бүлэг улс түрүүчийн язгууртнууд их Юань улсын бадрал хөгжил нь Хубилай сэцэн хааны үеэс эхлэн төр шашныг зэргээр явуулснаас болсон. Монгол орон сүүлээр бутран сарнисан байдалд орж бадарч хөгжиж чаддаггүйн шалтгаан нь шашныг өргөж, төр шашин хоёрыг зэргээр явуулаагүйгээс болсон гэж үзэж байв. Ингээд хутагт сэцэн хун тайж язгууртнууд шарын шашиныг шүтэж төр шашин хоёрыг зэргээр явуулахыг зорьж байсан байна.

Шарын шашныг монгол оронд дэлгэрүүлдэгийн бас нэгэн шалтгаан бол Алтан хаанаар тэргүүлсэн баруун гурван түмний хаад ноёдын Түвд орныг эрхшээлдээ оруулах шаардлагаас болсон байна. 16-р зууны 30-аад оноос 70-аад он болтол Гүнбилэгт мэргэн жонон, Алтан хан, Хутагт сэцэн хун тайж зэрэг баруун гурван түмний ноёд хөхнуурт удаа дараа цэрэглэж, тэндэхи Түвдийг эрхшээлдээ оруулснаар барахгүй Түвд орныг нэгмөсөн эзэлхээр зорьж байв. Гэвч тэд нар хэдэн арван жилийн дайн хийсэн явцад зориг чанга, дайн байлдаанд авьяастай Түвдчүүдийг зөвхөн цэргийн хүчээр эрхшээлдээ оруулж дийлэхгүй эрхбиш түүний оюун санааных нь түшиг тулгуур болох бурхны шашныг ашиглах хэрэгтэй гэснийг олж таньжээ. Эдгээрээс бид Алтан хан тэргүүтэй монголын ноёдын шарын шашныг хүчлэн дэлгэрүүлдэгийн зорилго нь хүчээ өргөтгөж, ноёрхлоо бататгах гэсэн байдлыг ил тод олж харж болно.

15-р зууны эхээр Хөхнуурын Зонхава, Түвд бурхны шашны эл бүлгүүдийн сахил санваар суларч, лам нар эрх ашиг өнгө мөнгөнд шунахайран итгэл хүндээ алдаж байсан байдалд чиглүүлэн шашны

өөрчлөлт хийхээр зорьжээ. Гаадамбын сургаалаар суурь болгон ил ном ба тарнийн номын зэргэмжийг тогтоон урьдаар ил ном сурч, дараа нь тарнийн ном сурах, ном тарнийг уялдуулах зарчмыг тогтоон лам нарын сахил санваарыг чангатгаж, шарын шашныг үүджээ. 16-р зууны эхэн болоход шарын шашин Түвд оронд хэдийгээр нэлээд нөлөөтэй болсон боловч улааны шашин ноёрхох байрыг эзэлж, шарын шашныг шахаж гадуурчлан цаашилбал цохилт өгч байв. Лхас болон хойд Түвдийн язгууртнууд ч шарын шашныг айлган сүрдүүлэх буюу түүнд цохилт өгч байв. Энэхүү байдлын доор шарын шашны хутагт хувилгаад хөхнуурт сая хүрсэн монголын язгууртнуудын цэргийн хүчинд түшиглэж өөрийн шашны ноёрхлоо бататгах арга замыг эржээ. Тэд энэхүү зорилгод хүрэхэд хэдэн арван жилийн цагийг туулжээ. Тавдугаар далай ламын үед хүрээд сая хошуудын Гүүш хаан Түвдийг эрхшээлдээ оруулж шарын шашныг Түвдийн төр шашны ноёрхох байранд эргэж гаргасан байна.

Шарын шашин монгол оронд уламжлагдан маш түргэн дэлгэрч, хаад язгууртнуудаас харц ардуудад хүртэл найдан шүтэгдэж, монголын түүх соёлд маш гүн нөлөөлжээ. Зохих талаас авч хэлдэг л юм бол Монголчууд нэг удаагийн гүн гүнзгий өөрчлөлт хувиралтыг өнгөрөөсөн байна. Монголчуудын эрэлхэг дайчин зан чанар нь арилах хэмжээнд хүрч эрх дамар, нум сумыг нь орхиулжээ. Байдаг олон эд мөнгө нь сүм хийд, хутагт хувилгаадын гарт цугларч, ядуу зүдүү байсан харц ардын амьдрал улам ядууран доройтсон байна. Их бага ноёд язгууртнууд хойно хойноос нь хутагт лам нарыг бишрэн шүтэж, харам хайргүй өргөсөн өглөгийн ачаар сольж олсон хоосон цол, зэрэг юунаас ч арвин болсон байна. Хаад язгууртнуудын монгол хүчирхэг улс байгуулах гэсэн хүсэл эрмэлзэл нь нэр цол харамгүй хайрлагч хутагт хувилгаадын гарт дуусчээ.

**Нэг: Шарын шашин Ордост дэлгэрсэн нь**

Ордос түмний хутагт сэцэн хун тайж Түмэдийн алтан ханы дайчилгаагаар Хөхнуурын Түвдэд цэрэглэх үед шарйн шашинтай анх танилцжээ.

“Эрдэнийн товч”-ийг үндэслэвэл хутагт сэцэн хун тайж хорин долоон настайдаа 1566 онд Түвдэд морилж Силимжийн гурван голын уулзвар дээр бууж Түвдэд элч илгээн “Та манайд орж өгвөөс

бид шашин ном хийе, орж эс өгвөөс бид танаа довтолмой" гэсэнд Дархан лам тэргүүтэй гурван лам ирж хэлэлцээр хийж орж өгчээ. Хутагт сэцэн хун тайж тэндээс гурван голын Түвдийг оруулж аваад гэргэн лам, очир дүмэй гурвыг монголдоо авч иржээ. Энэ бол монголын ноёд язгууртнууд дахин Түвд бурхны шашинтай харьцаа үүсгэсэн тухай судар бичиг дэх хамгийн анхны тэмдэглэл болох юм.

1573 онд Хөхнуурын ашин лам монгол оронд ирж Алтан хаанд гурван эрдэнэ, маанийн зургаан үсгийг сурталчилснаас Алтан хан ч маанийн зургаан үсэгт тарнийг унших болов.

1576 онд Хутагт сэцэн хун тайжаас Алтан ханд: "Энэ ба хойд хоёр заяанаа хэрэгтэй шашин ном бий хэмээн мэргэд өгүүлмүй. Түүгээр эдүгээ баруун этгээд ахуй цастын орноо үзэгч эрхт их нигүүлсэгч хоншим бодисад бодит биеэрээ бий ажгуу хэмээв. Түүнийг залж эртний богд Хубилай сэцэн хаан хутагт багш Пагва лам хоёрын ёсоор шашин төрийг байгуулваас гайхамшигтай бусуу?" гэж сануулсанд Алтан хан зөвшөөрч баруун гурван түмний ноёнтой зөвлөлцөн шарын шашны түрүү лам Содномцамцад элч илгээн залав.

1577 онд Алтан хан Хөхнуурын цавчаалд сүм байгуулж Содномжамцыг угтахаар бэлтгэв.

1578 онд Алтан хан Бошогт жонон, Хутагт сэцэн хун тайж зэрэг баруун гурван түмний ноёд Хөхнуурын Цавчаал сүм дээр хүрч өв тэгш их угтах ёслол явуулж Кам орны Литан хийдээс ирсэн шарын шашны түрүү лам Содномжамцыг угтан авч уулзсан байна. Монгол, Түвд, Хятад, Уйгар үндэстний 10 гаруй түмэн хар, шар цэрэг иргэд угтах ёслолд оролцсон байна. Далай лам болон жич түүний дагагсдад үлэмж арвин эд эрдэнэс мал, мөнгөний өглөг өргөн барьсан байна. Энэ нь даруй түүхэнд алдартай "Цавчаал сүмийн уулзалт" болно. Энэхүү уулзалт нь монгол оронд шарын шашин дэлгэрэх үүдийг нээсэн байна. Алтан хан шарын шашныг ашиглаж өөрийн хүчээ өргөтгөж ноёрхлоо бэхжүүлэхийг бодож Содномжамц ч Алтан хан мэтийн монголын хаад язгууртнуудын цэргийн хүчинд түшиглэж өөрийн шашны бүлгийн хүчнээ бузгайруулж байгаад Түвдийн төр шашны ноёрхох эрхийг атгахаар бодолхийлж байсан юм. Тэдний энэхүү харилцан түшиглэж, харилцан ашиглах харьцаа холбоо байгуулах улс төрийн зорилгыг "Цавчаал сүмийн уулзалт"-

аар дэмжиж биелэгдсэн байна.

Содномжамцыг угтах ёслол дээр Ордосын хутагт сэцэн хун тайж угтах яриа тавив. Тэр яриандаа: “Эртний сайн ерөөл сайтар боловсорсон хүчнээр эдүүгээ учирсан авралын орон билээ, өглөгийн эзэн хаан хоёулаа нар, сар нэгэн цагт ургасан мэт болов. Энэхүү цагтаа ба бүрэн бид эрхт хан хурмастын Бошогоор таван өнгө дөрвөн харийг эрхэндээ оруулсан тайж богд Чингис хааны ахул ач нь бодисадь хувилгаан Хүдэн хаан Шижү, Хубилай хаан хоёр ухагдахуй, урдын эцэст хүрсэн Сэцэн бандида амьтаны итгэл номын хаан Пагва лам хоёр жич монголын номт хаад, шашин, шидтэн лам нар учирч хоёр төрийн ёсоор хотол амьтныг амгалан жаргаланд удирдсан бөгөөд Хувь төмөр ухаант сэцэн хаан ( Тогоонтөмөр ухату хаан)-аас нааш шашин төр хоёр өчүүхэн цулуйдсанаар амьтны үйлдвэр өөр болон эгнэгт хилэнцэтээр амьдран байна. Энэ учир тэмцэх цагийн удирдагч бурхан багш, шашин лугаа ялгалгүй богд ламын гэгээн ба газрын эсрүа зэрэг хүчит хаан хоёр ийм өлзийт сайн өдрөөс цусны давалгаа хөдөлсөн их мөрнийг сүүгээр үйлдсэн тунамал далай мэт болгон зохиож урьдчилан номын цагаан замын сайн журмыг нээн хайрлаваас богд лам, хаан эзэн хоёр учран барилдсан их ачит тэр бөлгөө” гэжээ. Хутагт сэцэн хун тайжийн энэхүү алдартай яриа нь Алтан ханы шарын шашныг дэлгэрүүлсэн явдлыг дээд хэмжээгээр үнэлж, төр шашин хоёрыг зэргээр явуулахыг эрхэмлэсэн байна.

“Цавчаал сүмийн уулзалт” дээр Алтан ханаас Содномжамцад “Хамгийг мэдэгч очир дари далай лам” гэсэн цол өргөв. Энэ бол даруй далай лам гэсэн цолны хамгийн анхны ирэлт болно. Далай ламыг дагасан олон шавь нарт бас их бага хамба цорж цол өгсөн байна. Содномжамцаас Алтан ханд “Мянган алтан хүрдэн эргүүлэгч Загравард сэцэн хаан” хэмээн, Бошогт жононд “Загравард сэцэн жонон хан” хэмээн, хутагт сэцэн хун тайжид “Цогцосын зүрхэн сэцэн хун тайж” хэмээн тус тус цол өгсөн байна. Бас “Арван буянт цагаан ном”-ыг олонд зарлаж монгол оронд бөөгийн шашныг цаазалж, шарын шашныг бүх талаар дэлгэрүүлэхээр тогтож лам хуваргуудын улс төр, аж ахуйн байр суурийг хууль ёсоор баталсан байна. Бас Алтан хан Хөххотод сүм барьж Бошогт жонон Ордост гурван цагийн бурхны сүм байгуулж, хутагт сэцэн хун тайж 108 боть “Ганжуур”-ыг алт, мөнгөөр бичүүлэх гэж тус тус амлав. Цавчаал

сүмийн уулзалтын дараа Содномжамц Данхар Манзушир хутагтыг Хөх хотод томилж монгол оронд шарын шашныг дэлгэрүүлэх ажлыг удирдуулав.

Ордосын хаад язгууртнууд шарын шашныг дэлгэрүүлэх ажлыг идэвхитэй хийж байв. Далай ламаар толгойлуулсан түвдийн шарын шашны хутагт хувилгаад ч монгол оронд шарын шашныг дэлгэрүүлэхийн бүх хүчээрээ дэмжиж байсан юм. Мин улсын хаан ч монгол оронд шашин дэлгэрүүлэх ажлыг идэвхтэй дэмжиж сүм хийд байгуулахад зохих хэмжээний эд бодис мэргэжлийн дөхөм үзүүлж байв.

1583 онд Ордрсын баруун гарын ноёд Хангин хошууны Байхангирт Шагжамүнийн сүм барив. Хожим нь хуучин зуу гэж нэрлэгдэх болсон энэ сүм бол Ордост байгуулсан шарын шашны ууган сүм болох юм.

1585 онд гуравдугаар дүрийн далай лам Содномжамц Түмэдийн алтан ханы Сэнг дүүрэн ханы заллагаар Алтан ханы онгоныг оршуулахаар Хөх хотод хүрэх замдаа 3 сар самадийд суун Хаянхярваа бурхныг бүтээн хутагт сэцэн хун тайжид хадаг торгон баринтагт номонд авшиг хүртээж өгөв.. Тэндээс Бошгот жононгийн ордонд хүрч гурван цагийн бурхны сүм барих газрыг нь шинжиж өгсөн байна.

1607 онд Бошгот жононгийн гурван цагийн бурхны сүм – Их зууг эхлүүлэн барьж 1613 онд барьж төгсгөн 12 насны дүрийн Шагжамүни бурхны хөргийг алт мөнгөөр бүрхэж, 1614 оны цагаан сарын арван таванд Майдар хутагтыг залж аравнайлуулжээ. 1623 онд Ариг цоржоор “Ганжуур”-ыг алтаар бичүүлж төгсгөн, их зууд залж авч ирэв.

1623 онд Ордосын зүүн гарын Мянгай дайчин, Доноров хун тайж нар өлзийт уул хэмээх газар шар ногоон шаазан вааран дээвэртэй зүүнгар зууг эхэлж байгуулав.

1624 онд Бошгот жононг нас барсанд гуравдугаар хөвгүүн Дуба тайж эх Жүнхэн хатны даалгавараар Лхас, Дашилхүмбэд хүрч далай лам Банчинэрдэнтэй учран золгож зуугийн хуарангуудад цав манз барьж Бошогт жононгийн ном буяныг хийв. Далай лам Банчинэрдэнэ хоёулаа Дуба тайжид “Тайсан хун тайж” хэмээх цол соёрхов.

1625 онд Дуба тайж буцах үедээ урьд Бошгот жононгийн амалсан мөнгөн “Данжуур”-ыг залж, дараа жил нь нутагтаа буцаж иржээ. Бошгот хутагтийн хатан Жүнхэн Ордос түмний хамаг ноёдыг цуглуулан Майдар хутагтыг залж мөнгөн “Данжуур”-т цэцэг суулгуулав. Манжчууд монгол орныг эзэлсний дараа шарын шашинд маш болгоомжтой хандан, шарын шашны хутагт хувилгаадын монголчуудад өгөх нөлөө тусгалыг бүрэн мэдсэн суурин дээр монгол оронд шарын шашныг бүх талаа дэмжин дэлгэрүүлэх төрийн бодлого авсан байв. Ордосын ван ноён Манж Чингийн энэхүү төрийн бодлогыг маш идвэхтэй хүрээлэн дагаж шарын шашны сүм хийдийг хүчлэн байгуулцгаасан юм. Чин улсын ээр засагч энх амгалан найрамдалт тив тэнгэр, тэтгэгчийн үед Ордост сүм хийд Рашичойлин, Зандан зуу, заарагийн сүм зэрэг хийдүүд хойно хойноосоо байгуулагдаж зарим хийд нь улмаар өргөжин хөгжөөд хэд хэдэн салбартай хорь гучин сүм дуганатай, шавилан суусан хуврага нь хэдэн зуу, цаашилбал мянга гарч байсан том хийд болсон байлаа. Чин улсын бүрэнт засагчийн үе ба бадралт төрийн эхэнд үймээнд эвдэгдсэн сүм хийдүүдийг сэргээн засах явцад бас нэг бүлэг бага бага сүмүүдийг шинээр байгуулсан байна. Зүүнгар хошууны Шаргын сүм, хоёр усан сүм, хар голын агуйн сүм, голын зүүн дэх отчийн сүм, Жиюүн вангийн хошууны бургастайн сүм, сартагаан сүм, цагаан чулуутын сүм, баянтолгойн сүм, садын дуган, зүрхийн сүм, шүүрийн сүм, цагаажайн сүм, хангин хошууны жаргалантын сүм, бударганатын сүм, тэрвийн сүм, өлзийт хүрээн сүм, эргүүлийн сүм, далд хошууны агуйн сүм, шангарцагийн сүм, гүнгийн нуурын сүм, мухар нуурын сүм, хув хошууны сүм зэрэг бага бага хийд бол бүр энэ үед байгуулагдсан юм. Хутагт сэцэн хунтайж Бошгот жонон, Мянгай дайчин нар Ордост шарын шашныг эхэлж дэлгэрүүлснээс нааш Ордосын баяд ноёд нэр төрийг хөөцөлдөн шарын шашныг дэлгэрүүлэхэд эд мөнгө хүч чадлаа харамгүй зориулан сүм хийд байгуулж бурхан шүтээн хийх болсон ба шарын шашны хутагт хувилгаадын өөрийн шашны хүчнээ өргөтгөхөөр авсан арга барил Манж, Чин, Иргэн улсын ноёрхогчдын монгол оронд авсан шарын шашин зэргээр дэлгэрүүлэх төрийн бодлогоос болж шарын шашин Ордост маш түргэн дэлгэрч ноёд баячуудаас эгэл ард хүртэл найдан шүтэж нийгмийн улс төр аж ахуй соёлоос аваад эгэл харчуудын аж амьдралд хүртэл гүн нөлөө үзүүлсэн байна. Сүм хийд байгуулах явдал ер тасалдсангүй явагдсаар

иржʼ Иргэн улсын эцэс болтол Ордос нийт 300 шахам сүм хийд байгуулжээ. Сүм хийдийн хуваргын тоо нь хамгийн арвин үедээ хоёр түм гарч байсан байна.

Шарын шашин нь 16-р зууны эцсээр Ордост уламжлагдан дэлгэрч Иргэн улсын эцэс болтол 300 шахам жил монголчуудын өчил ухамсарыг ноёрхож, Ордос Монгочуудын аж ахуйд хүнд ноцтой татаас учруулан хүн ам ихээр хасагдан, хөдөлмөр хүч ихээр дутагтан, нүсэр хүнд хөдөлмөрийн дараас эмэгтэйчүүдийн мөрөн дээр тохогдон байв. Монголчуудын үзэл ухамсар соёлыг харийнхан нөлөөлж Түвд үсэг бичиг нь Монгол үсэг бичгийг орлуулах хэмжээнд хүрсэн байна. Хэдийгээр тийм боловч Монголчуудын соёл урлаг, анагаах ухаан, одон орон ухаан, барилгын мэргэжлийн хөгжилтөд зохих ахиулах үйлдэл үзүүлсэн юм. Хэдэн зуун жилийн турш Ордосын лам нарын дотроос нэлээд арвин түүхч, зурхайч, зохиолч, шүлэгч, алдарт эмч нар гарсан юм. Үүний дотроос Ордосын хэдэн алдарт гэгээн ба лам нарыг дурдаж болох юм.

Хутаг бандида гэж алдаршсан Лувсанлхүнрүв бол Жиюүг вангийн хошууны хутагийн сүмийн хоёрдугаар дүрийн гэгээн болох юм. Тэр 18-р зууны үед амьдарч байв. Хорин хэдэн насандаа гүмбүм, лавран зэрэг амдуугын арван гурван хийдээр тойрч ном хаялцаад “Хутаг бандида” гэж хол ойрд алдаршжээ. Тэр “Шашны түүх эрдэнийн эрих” хэмээх түүхийн ном, амдуун гүнтэн гэгээний “Ус модны шаштир нийлүүлж, “Гэр шаштир” гэсэн сонин хачин урт шүлэг бичсэн бөгөөд “ Жидрим” үүсгэлийн зэргэмж, “Зогрим” төгсгөлийн зэргэмж, “ мэргэдийн хурим гэх мэтийн хэд хэдэн ном зохиосон байна. Түүний эдгээр зохиолууд нь монгол түвдийн олон хийдээр уламжлагдан тарсаар байна. Жиюүн вангийн хошууны тохойн зуун хоёрдугаар дүрийн гэгээн Лувсаннянраг бол ордосын алдарт хэдэн хувилгаадын нэг болох мөртлөө шашны гүн ухаантай юм. Тэр “ лайнбриа” үйлийн үрийг номлосон ном, “ламрим” мөрны зэргэмж, гэх хэд хэдэн ном зохиожээ. Эдгээр ном амдуу гүмбум, лавран зэрэг их хойд болон төвдийн лхас, дашилхүмбэд ч хүрч байсан бөгөөд “ламрин хутагт” гэж хол ойрд алдаршиж байв.

Жиюүн ван хошууны хөгийн зуугын тавдугаар дүрийн Ишданзанванжил 1854-1907 бол 19-р зуунд гарсан монголын гарамгай шүлэгчин, анагаах ухаантан мөн бөгөөд Ордосын хэдэн алдарт хувилгаадын нэг болох юм. Тэр долоон насандаа Цахарын

шулуун цагаан хошуунаас гүнгийн зуугийн гэгээнээр тодлогдон залагдаж нэг насандаа маш олон сургаал шүлэг болон сувдын унжлага, отчийн ач тусын хураангуй гэх мэтийн анагаах ухааны шүлэг зохиол бичжээ.

Зүүнгар хошууны хэдэрмэ сүмийн шавран Ишбалдан бол 19-р зуунд амьдарч байсан ордосын хэдэн алдарт хувилгаадын нэг нь болох мөртлөө түүхч юм. Тэр номын барыг сайхан сийлдэг уран хүн байж нэг насандаа 100 гаруй ном дармаллан барлажээ. Үүнээс гадна бас монгол түүхийн судлалын хамаатай “Хэтэрмээн гэгээний сүнбүм”, “эрдэнийн эрхи” зэрэг номуудыг бичсэн байна. Ламын сүмийн зургадугаар дүрийн гэгээн Ванданням 1872-1926 бол Ордосын дугуйлангийн хөдөлгөөний алдарт удирдагч мөн бөгөөд өвөр монголын ардын хувьсгалт намын байнгын гишүүн, цэргийн комиссарын түшмэлийг хариуцаж байгаад богдод байхдаа умартын цэргийн эрхтний тагнуулд хорлогджээ.

Хангийн хошууны Бүгдийн Шарзуугийн лам Лодойсамбуу 1882-1938 бол шүлэгч бөгөөд өвөр монголын ардын хувьсгалт намын хангийн хошууны гол удирдагч байсан юм. Тэр сургаал шүлэг болон “Гянданы ханын шүлэг”, “жинч хүүхэн”, отог уушгийн эвтийн бүлэг”, их ардчилсан үзэл”санаатай шүлэг зохиожээ. Түүний шүлэг нь монгол үндэстний орчин үеийн утга зохиолд нэлээд нөлөөтэй байдаг. Үүнээс гадна лам нар эгэл харчуудын дотор Жамба мэт нэрт оточ, зүүнгарын Бүрэнжаргал мэт уран дархан маш олон гарч өнгөрсөн юм.

**Хоёр: Ордосын сүм хийдийн барилгын онцлог шинж хийгээд бурхан шүтээн, тахилгын эдлэл хэрэгсэл чимэглэлийн тухай**

1583 онд Ордосын баруун гарын ноёд хангины Баянхангин(Өнөөгийн хангин хүшууны Их-Ус сумын Баянхангин гацаанд бий.)-т Шагжамуни сүм барьсанаас нааш Иргэн улсын үе хүртэл ордост шарын шашны сүм хийд байгуулах явдал ер тасалдсангүй. Иргэн улсын эцэс болтол манай мэдэгчээр Ордост 300 шахам сүм хийд байгуулагдсан байна. Байгуулагдсан он жилийн эрт орой болон сүүлээр нь удаа дараа өргөтгөж байсан хэр хэмжээний адилгүйгээс болж эл сүм хийдийн барилгын хүрээ хэмжээ нь ч харилцан адилгүй байсан юм. Бага сүмүүд нь ердөө

тав гурван бага дуган арав хорин тасалгаа, шавь нарын орон гэртэй байхад их шиг сүм хийд нь арав хорин сүм дугантай нэг хоёр зуун тасалгаа шавь нарын орон гэртэй, хэд хэдэн хашигтай байв. Онц зарим их хийд нь гуч дөчин сүм дуган, хэдэн зуун тасалгаа цаашилбал мянгаад тасалгаа шавь нарын орон гэртэй байсан. Бага сүмийн их дуган нь ердөө 25 тасалгаанаас хэтэрдэггүй, их шиг сүм хийдийн их дуганууд нь 35, 42, 49, 64, 81 тасалгаатай. Тэр мөртлөө олонх нь хоёр гурван давхартай байдаг. Хэдий ийм ч баргийн сүм хийдэд бурхан тахидаг зуун дуган, сүм хамгаалах сахиусыг тахидаг мигминсан, Махранзын дуган, хурал хурдаг цогчин дуган, мөргөл хийдэг суварга, сүмийн хамааралтайзэд зэвийн газар, шавь нарын суух орон гэрүүд байдаг юм. Зарим ор ганц дуганатай сүм гээд ч дугандаа хурлаа хурж, хоймортоо бурхнаа тахиж, дуганы үүдэнд Махранзын хөрөг шуумлыг тахидаг. Суврага бол сүм хийдийн барилгын чухал бүрэлдэхүүн болохоор баргийн сүм хийдэд дуталгүй байдаг.хамаг цөөхөндөө 1-2, хамаг олондоо 200 гаруй байдаг. Тэгэхдээ балдан барайбун цогц суврага, кашүрийн суварга, жагар суварга, балба суврага гэх мэтийн олон янз хэлбэртэй байдаг.

Ордосын сүм хийдийн бараг бүр үзэмж сайтай ус, модтой уудам саруул тал дээр буюу уул довын энгэр дагууланд цогчин дуган, зуны дуганаар гол шугам болгож бусад сүм дуган барилгуудыг түүний эргэн тойронд тэгш хэмийг баримтлан барьсанаас бүх барилгын дархалт нь их эмх дэглэмтэй байдаг. цогчин дуган зуугын дуганыг ер нь өндөр хайсан дээр бусад сүм дуганаас онцгой өндөр уужим, уран нарийн барьдаг болохоор бусад барилгаас гоёмсог харагддаг. Зуу вангийн зуу, Занданжуу, шинэ усан зуу, засаг зуу, дашичойлан, шар зуу зэрэг хошуу ба чуулганы их хийдийн гол гол сүм дуган нь бүр хоёр гуравхан давхартай. ногоон шаазан ваараар дээвэрлэж, саравчинд нь зааны хошуу, нисэх луу мэтийн амьтны дүрийг гаргаж шогнож хийсэн сүмийн оройд том том алт шижирлэсэн гуулин зэмсэг боди гөрөөс, сүмд маш олон алт, мөнгө, гуулин бурхан тахилгын эдлэл хэрэгсэлтэй, сүмийн дотрох дулаагуур нь нарийн хийсэн хивс, ороолттой жич элдэв зүйлийн үнэт будаг ширээр урлаж зурсан юм. Эдгээр сүмийн барилгын аугаа сүрлэгээр авч хэлсэн ч урлагийн гоёмсгоор авч хэлхсэн ч түмэдийн ширээт зуу, майдар зуу, их зуу зэрэг алдарт хийдээс өмнө суугдах хийдэд тоосгон модон бүтэцтэй нь олонхи тоог эзэлж, цул чулуун бүтэцтэй нь маш ховор

байв. Барилгын хэв намба дээрээ түвд маягийн сүм хийд урчуудын гараар байгуулагдсан болохоор хятад сүм хийдийн хэв намбын нөлөө ч багагүй байсан юм. Ерөнхийдөө түвд маягийн, хятад маягийн, түвд хятад холилдсон маягийн гэх 3 зүйлийн хэлбэртэй байдаг. Үүшин, засаг, жиюүн вангийн хошууны сүм хийдэд хятад маяг нь голлож отог, хангин зэрэг хошууны сүм хийдэд түвд маягийнх нь олон байдаг. Ордосын сүм хийд нь хэлбэр маяг дээрээ олон янзтай байсан боловч шарын шашны сүм хийдийн гол онцлог болох сүм дуганы оройн ганжир, зассан, хорол, бодь гөрөөс зэрэг нь ижлэвтэр байсан юм. Лам нарын орон сууцанд шавар тоосгон байшин, алаг байшин, арвин байдаг боловч зарим лам нар нь монгол гэр, монгол гэрийн хэлбэр маягтай бургас шавраар барьсан шал гэрт суудаг байсан.

Ордосын сүм хийд нь барилгын хэв намба дээрээ түвд, хятад, түвд хятад холилдсон гэх мэтийн олон янз байдаг боловч сүм дуганы дотрох бурхан шүтээн, хурал номын багаж хэрэгсэл, тахилгын эдлэл хэрэгсэл, засал чимэглэлийн зүйл нь түвд Хөх нуурын шарын шашины сүм хийдтэй үндсэндээ адил байдаг. Бурхан шүтээнд шавар шуумал бурхан голловч алт, мөнгө, гууль, модон бурхан шуумал бурхан бас маш олон байдаг. Цогчин дуган, цанид мэтийн үргэлж ном хурал хурдаг сүмд тулгуурын хоорондуур мөр олбог жавдэнтай ширээ дүүрэн тавьж байдаг. Ширээтийн ширээний суудал нь өндөртэй, богинотойгоор үл барам дээр нь дэвшсэн олбог дэвсгэрийн нимгэн зузаан нь ч харилцан адилгүй байдаг. Хурал хурдаг лам нар нь хувь хувийн тушаал хэрэм, эрдмийн цолын өндөр богиныг ялгаж тогтоосон суудалд сууж хурал хурдаг.

Сүм дуганд олон зүйлийн шуумал бурхан байдгаас гадна, торгон хатгамал бурхныг сүмийн оройдоо залдаг байдаг. Үүнээс гадна сүмийн тулгуурын хооронд сүмийн оройгоос таван өнгийн торго дурдангаар урлаж оёсон лавир, жамсаг, туг мэтийн элдэв зүйлийн гоёл чимэглэлийн зүйлийг өлгөж байдаг.

Зарим дуганы хойморт тусгай бурхан тахих ширээ тавьж, тахилга дайлгын зүйлийг нь тавьж байдаг. Тахилгын зүйлүүд нь доорх мэтийн зүйлүүд байдаг.

Долоон эрдэнэ хэмээх хүрд маань (хатан, түшмэл, заан, морь, жанжин зэрэг)

Өлзийт найман тахил хэмээх (өлзий занги, бадам цэцэг, шүхэр, дун, лавай, алтан хүрд, ялгуулсан дуваз, эрдэнийн бумба, алтан загас зэрэг )

Найман тахил хэмээх толь (гиван, тараг, тор өвс, бялуу, жимс, цагаан лавай, шанз зэрэг)

Долоон эрдэнэ хэмээх урт гэр (суудал, гутал, шаахай, сэлэм, хувцас, могойн арьс, цэцэрлэг зэрэг)

Тахилгын зүйлүүд нь (ус, цэцэг, хүж, зул, цай, будаа, жимс зэрэг)

Хуурсан арвайн гурилаар зассан балин (хуурсан арвайн гурил шар тос, чихэр хийсэн лодур хэмээх жилийн балин)

**Гурав. Ордосын сүм хийдийн байгууламж**

Ордосын шарын шашины сүм хийдийн байгууламж нь Хөх нуур, Түвдийн шарын шашины сүм хийдийн байгууламжид үндэслэн, монгол газрын бодит байдалтай уялдуулж байгуулсан болохоор бага сага адилгүй зүйлийг гаргавал Түвдийн шарын шашины сүм хийдийн байгууламжтай эдийн засаг, хурал номын гэх 2 төрөлд хуваах болох бөгөөд тэдгээр нь тус тусынхаа үүрэг тушаалаа хэрэгжүүлж, харилцан харшилдаггүй. Хурал номын ажлыг голдуу гисгүү, унзад зэрэг тушаалтай лам нар голлон хариуцаж, сүм хийдийн эдийн засаг болох жисааны ажлыг голдуу шансуун, дэмчи, нярав мэтийн тушаалтай лам нар голлон хамаардаг. Цогчин дуган ба эл рашаанууд нь бүр эш даган хурал ном жисаа зэргийн байгууламжтай байж, даган аж ахуйн тооцоо хийдэг. Зарим сүм хийд нь ярны жисаа, маанийн жисаа гэх мэтээр гол гол хурал хүртэл асдаа жисаатай байжээ. Ас асдаа аж ахуйн тооцоо хийдэг. Дүди хийд ба зарим их хийдүүд нь тус сүмээ хамаарахаар барахгүй доороо бас харьяалагдах шавь хийдүүдийн лам нар нь тус хийдүүдийнхээ шашины ажиллагаанд оролцохоор барахгүй харьяалагдах их хийдийн шашин номын ажиллагаанд бас оролцдог. Эл сүмийн их бага нь харилцан адилгүй болохоор сүмийн байгууламж нь ч харилцан адилгүй байдаг.

Дунд бага сүм хийдийн байгууламж: дунд бага сүм гэдэг нь 1. Тоо 1 зуу цэнгэгийн сүм буюу хэдэн бага сүмтэй хийдийг хэлдэг. Ийм сүмд сүмийн хэрэг мэдэгч 1 шавиран буюу лам (ширээ лам) –тай байж. Шиврэн лам буюу да лам нь сүм хийдийн хэрэг явдлыг

ерөнхийлөн захирдаг.

Их хийдийн байгууламж: Их хийд гэдэг нь цогчин, цанид, зодва дүйнхор мэтийн хэд хэдэн ялгаатай. Сүм дуган арвин, шавар олон сүмийг хэлдэг. Ийм их сүм нь ердөө дороо харьяалагдах шавь хийдтэйбайдаг. Ийм хийдэд гэгээн буюу дүдид лам, эсвэл хамба лам нар сүм хийдийн хэрэг явдлыг ерөнхийд нь захирдаг боловч дороо тусгай сүм хийдийн хамааралт байгууламжтай байжээ. Сүм хийдийн өдөр тутмын хэрэг явдлыг хамаардаг. Ордосын сүм хийдийн материалаас үзвэл зарим сүм нь 10 цогтойн тоо нь олон бол бас дотроо дээд дунд доор гэж хувааж ажлын талаар нарийн хувиартай байдаг. Үүсинжүү сүмээр жишээлбэл: тус сүм нь цогтой, тэгэхдээ дээд 10 цогтой дунд 10 цогтой доод 10 цогтой гэх мэтээр 3 дэцэд хувааж ажлын нарийн хувиартай байдаг. Дээд 10 цогтой нь цогчин хамба, цанид хамба, дүйнхэр хамба, цогчин ба 2 маналын , 4 гэвгий, 1 начин, гэгээн шангийн шансуд ба хошуу дэмчи зэрэг 10 хүнээр бүрэлддэг. Энэ 10 цогтой нь хийдийн засаг захиргаа хурал ном, лам нарын эрдмийн цол мяндаг тушаал олгох зэрэг хэргүүдийг хамаардаг. Дунд 10 цогтой нь ярнайн дэмчи, дүйнхэр рашааны дэмчи, цогчин чавир, цанид чавир дүйнхэр чавир цогчин хаяг, цанид хаяг, 2 нянган, 1 чобонбо зэрэг 10 хүнээр бүрэлддэг. Энэ 10 цогтой нь сүмийн хурал ном, ёс дэглэмийг хамааран өдөр тутмын ажлыг бодитой хийдэг. Доод 10 цогтой нь 8 дэгүр, 2 бургасан гамбаар бүрэлддэг. 8 дэгүр нь бол лам нарын барьсан суусан зээл гудамжийн 8 тойргийн дарга болно. Хоёр бургасан гамба нь бол сүмийн хоригуул, доной шугуйч, бут бургасыг голчилон хамгаалж харж хэн хэрвээ эвдэж сүйтгэхэд хүрвэл торгодог юм. Цогтойн бүрэлдэхүүнд лам тушаалтан оролцдогоор барахгүй хар тушаалтан нугууд бас ордог. Отог зуугийн 60 цогтойд цогчин лам цогчин дэмчи, цогчин гэбхүй, цогчин унзад, да нярав, рашаан лам, рашаан гэбихүй, рашаан нярав, рашаан унзад канцин гамба мэтийн лам тушаалтан оролцдогоор барахгүй бас зураач, суман занги мэтийн хар тушаалтнууд бас ордог байв. Зарим сүм хийдийн их дэмчийг бас хар хүн хийдэг байв. Цогтой нарын эрх гүйцэтгэх байгууламж бол даруй цогчин жисаа хэмээх их жисаа болно. Цогчин жисаанд цогчин дэмчи буюу бага нярав 1-2 байжээ. Өдөр тутмын ажлыг хамаардаг. Бас бичээч гэж 2-4хүн байжээ. Сүм хийдийн дэнсэн бичмэлийн ажлыг хийдэг. Их жисаа бол хийдийн эрхт байгууллага болохоор

хошуу засаг ба ноён түшмэдийг угтан зочлох жисаагийн мал таринаы орлогыг хамаарч лам нарын хурлын зардлыг тохируулан өглөгийн эздийг хүлээн авч хурал мөргөлийг нь тохируулах зэрэг ажилуудыг хийдэг. Зарим их сүм хийдийн их жисаанд бас гяндан, хар ташуур, гав гинж зэрэг шүүхийн багажтай байжээ. Сахил санваар эвдсэн лам нарыг занчих, хорих, шарыг нь тайлан үлдэн хөөх буюу шашин номд халдаж эвдэгсэдийг шийтгэх эрхтэй байдаг.

Цогчин дуган ба эл рашаануудын байгууламж: цогчин дуган гэдэг бол их чуулганы сүм гэсэн утгатай юм. бүх сүмийн лам нарын хурал хурдаг газар болох юм. эл сүм хийдэд дутал үгүй байдаг. Цогчин дуганы хамгийн их лам нь бол цогчин лам болно. Ердөө цогчин хамба гэх буюу цогчин ширээ лам гэдэг. Цогчин дуганы ажлыг ерөнхийд нь хамаардаг. Түүний доор нь цогчин гэбихүй гэж 1-2 хоёр байжээ. Хурал номын эмх дэглэм, лам нарын сахил санваарыг хамаарч, сахил санваар эвдэрснийг шийтгэх эрхтэй байдаг. Цогчин дуганд бас унзад гэж 1-2 байжээ. Хурал номын дэс дарааг голчлон хамаардаг. Үүнээс гадна бас цогчин нярав буюу дэмчи гэж байжээ. Цогчин жисаагийн ажлыг хийдэг. Рашаан гэдэг бол шарын шашины сүм хийдийн шашины ухааны дээд сургууль болох юм. Ордосын их их сүм хийдэд багадаа 1-2 рашаантай. Хамгийн олон нь 15 рашаантай байв. Ордосын сүм хийдэд голуу цанид рашаан, дүйнхэр рашаан, мамба рашаан, ламирам рашаан зэрэг рашаан байв. Цанид рашаан бол шарын шашины гүн ухааны дээд сургууль, дүйнхэр рашаан бол шарын шашины цагийн хүрдний дээд сургууль, мамба рашаан бол шарын шашины анагаах ухааны дээд сургууль, ламирам рашаан бол шарын шашины мөрийн зэргэмжийн дээд сургууль болох юм. рашааны хамгийн их хэрэг мэдэгч лам бол рашаан лам болох юм. ердөө рашаан лам гэж дуудах буюу ямар ямар рашаан лам эсвэл хамба лам гэдэг. Рашаан лам бол шарын шашины дээд сургууль болох рашааны захирал болох юм. рашааны хэрэг учрыг ерөнхийд нь захирдаг. Түүний доор нь цогчин дуган лугаа адил 1-2 гэбихүй унзадтай байжээ. Лам нарын сахил санваар ба ном хурлыг хамаардаг. Бас дэмчи, нярав мэтийн тушаалтай лам нар байжээ. Рашааны эдийн засаг болох жисааны ажлыг хамаардаг. Үүнээс гадна шарын шашины сүм хийдийн үндсэн зохион байгуулалт болох рэгүр, канцан гэдэг нь одоогийн хотын зээл гудамжийн суугуул ардын зөвлөл шиг зохион

байгуулалт байжээ. Лам суурьшилын ажилуудыг хамаардаг. Бас ил сүм дуганд гонир гэгч лам байдаг. Тэр бол сүм дуганыг хамгаалж, цэвэрлэж, тахилга хийдэг лам болох юм.

**Дөрөв. Ордосын сүм хийдийн эвдэгдэж сүйдсэн байдал**

Шарын шашин Ордост дэлгэрснээс нааш хэдэн зуун жилийн турш сүм хийд байгуулах ажил ер тасалдсангүй явсаар ирсэн боловч Ордосын сүм хийд нь бас хэдэн удаагийн их сүйдэл хохиролд учирсан юм. Түүхэн материалаас үзэхэд:Ордосын сүм хийд нь 3 удаагийн их сүйдэлд учиржээ. Анх удаагийн сүйдэл бол Чин улсын улсын бүрэнт засагчийн үе (1862-1874)-д гарсан түүх сударт Ордосуудын муу хулгай гэж хэлдэг хотонгийн уравлаг гаргагчдын сүм хийдийг эвдэж сүйтгэсэн явдал болно. Бүрэнт засагчийн 6-р он (1867 он) –оос арваннэгдүгээр он (1872 он)-ы хооронд Ниншиян Гансугийн Ма Хува Лүн тэргүүтэй хутгийн урвуулаг гаргагчид хэдэн удаа Ордост дайран орж, Ордосын долоон хошууны сүм хийд, эгэл ардын гэр малыг цөлмөн дээрэмдэж энэ удаагийн хотончуудын үймээнд Ордосын 7 хошууны удаан жилийн түүхтэй зуу шахам сүм хийд сүйджээ. Үүнд Отог хүшууны 22 сүм гэх мэт сүйдэж байгаад соёлын хувьсгалын үед бүрэн устгагдаж сүйдсэн гашуун түүх байна.



[illegible]

[illegible] 300 [illegible] 100 [illegible] 1583 [illegible] 19 [illegible] ⑯ [illegible] 7 [illegible] 19 [illegible] (1854 —1907) [illegible] ⑮ [illegible] (1882 —1938) [illegible] (1872 —1926) [illegible] ⑭ [illegible] ⑰

ᠰᠠᠷ᠎ᠠ᠂ ᠬᠠᠭᠠᠰ ᠰᠠᠷ᠎ᠠ᠂ ᠳᠣᠯᠤᠭᠠᠨ ᠶᠢᠨ ᠰᠡᠷᠡᠭᠦᠨ ᠰᠠᠷᠢᠨ ᠳᠤ 4 ᠤᠳᠠᠭ᠎ᠠ᠂ 1 ᠵᠢᠯ᠂ ᠤᠯᠠᠨ ᠬᠦᠢᠲᠡᠨ ᠲᠠᠷᠠᠭ ᠳᠤ ᠵᠢᠯ ᠰᠢᠨᠵᠢᠯᠡᠬᠦ ᠬᠡᠷᠡᠭᠲᠡᠢ᠃ ᠬᠠᠮᠤᠭ 10 ᠮᠢᠨᠦ᠋ᠲ ᠡᠴᠡ ᠲᠣᠮᠤᠷᠬᠠᠢ ᠰᠠᠷ᠎ᠠ᠂ ᠮᠢᠨᠦ᠋ᠲ᠂ ᠮᠢᠨᠦ᠋ᠲ᠂ ᠬᠣᠶᠠᠷ 10 ᠮᠢᠨᠦ᠋ᠲ᠂ ᠬᠤᠪᠢᠶᠠᠷᠢ 10 ᠮᠢᠨᠦ᠋ᠲ ᠤᠷᠲᠤ ᠬᠣᠨᠤᠭ ᠪᠣᠯ 3 ᠤᠳᠠᠭ᠎ᠠ ᠬᠤᠪᠢᠶᠠᠷᠢ ᠰᠢᠨᠵᠢᠯᠡᠬᠦ᠂ ᠲᠣᠭᠣᠯᠠᠬᠤ ᠲᠣᠭ᠎ᠠ ᠪᠣᠯ ᠨᠢᠭᠡᠳᠦᠭᠡᠷ᠂ ᠬᠣᠶᠠᠷ ᠲᠣᠭ᠎ᠠ ᠶᠢ 30 ᠮᠢᠨᠦ᠋ᠲ ᠬᠦᠷᠲᠡᠯ᠂ ᠬᠠᠮᠤᠭ ᠤᠷᠲᠤ ᠬᠠᠮᠤᠭ 10 ᠬᠠᠮᠤᠭ᠂ ᠬᠣᠶᠠᠷ᠂ ᠬᠣᠶᠠᠷ ᠤᠳᠠᠭ᠎ᠠ ᠰᠢᠨᠵᠢᠯᠡᠬᠦ᠂ ᠲᠠᠷᠠᠭ ᠳᠤ ᠬᠣᠶᠠᠷ ᠪᠣᠯ ᠵᠢᠯ ᠰᠢᠨᠵᠢᠯᠡᠬᠦ ᠬᠡᠷᠡᠭᠲᠡᠢ᠃ ᠲᠡᠳᠦᠢ ᠶᠢ 60 ᠮᠢᠨᠦ᠋ᠲ ᠬᠦᠷᠲᠡᠯ ᠪᠣᠯᠭᠠᠨ᠎ᠠ᠃ ᠮᠢᠨᠦ᠋ᠲ ᠢᠶᠠᠷ ᠬᠣᠶᠠᠷ ᠢ ᠲᠡᠳᠦᠢ ᠪᠠ ᠪᠣᠯ ᠬᠣᠨᠤᠭ ᠪᠣᠯ ᠬᠤᠪᠢ ᠲᠣᠭ᠎ᠠ ᠶᠢ 10 ᠮᠢᠨᠦ᠋ᠲ ᠬᠦᠷᠲᠡᠯ᠂ ᠬᠤᠪᠢ ᠲᠣᠭ᠎ᠠ ᠶᠢ 24 ᠴᠠᠭ 30 ᠮᠢᠨᠦ᠋ᠲ ᠬᠦᠷᠲᠡᠯ᠂ ᠰᠢᠨᠵᠢ ᠳᠤ ᠪᠠᠷᠢᠨ 5 ᠬᠣᠨᠤᠭ ᠤᠷᠲᠤ ᠪᠣᠯᠭᠠᠨ᠎ᠠ᠃ ᠲᠡᠭᠦᠨ ᠳᠤ ᠲᠣᠭ᠎ᠠ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠳᠤ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠬᠤ ᠲᠠᠯ ᠲᠡᠳᠦᠢᠯᠡ᠂ ᠲᠣᠭ᠎ᠠ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠳᠤ ᠲᠣᠭᠣᠨ ᠬᠤᠪᠢᠶᠠᠷᠢ ᠳᠤ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠲᠣᠭᠠᠨ ᠢ ᠰᠢᠨᠵᠢᠯᠡᠨ᠎ᠡ᠃ ᠮᠢᠨᠦ᠋ᠲ ᠢ ᠰᠢᠨᠵᠢ ᠲᠠᠯ

2. ᠪᠢᠶ᠎ᠡ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠳᠤ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠬᠤ᠃ ᠪᠢᠶ᠎ᠡ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠶᠢ ᠲᠣᠭᠠᠯᠠ᠂ ᠮᠢᠨᠦ᠋ᠲ᠂ ᠮᠢᠨᠦ᠋ᠲ᠂ ᠲᠡᠳᠦᠢ ᠲᠣᠭᠠᠨ ᠢ ᠰᠢᠨᠵᠢᠯᠡᠨ᠎ᠡ᠃

1. ᠬᠣᠶᠠᠷ ᠪᠣᠯ ᠲᠣᠭ᠎ᠠ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠳᠤ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠬᠤ: ᠬᠣᠶᠠᠷ ᠪᠣᠯ ᠲᠣᠭ᠎ᠠ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠶᠢ 1 ᠲᠣᠭᠠᠯᠠ ᠪᠣᠯᠭᠠᠨ᠎ᠠ᠃

[illegible]

# НИНШИЯНЫ ХОТОН ҮНДЭСТНИЙ ӨӨРТӨӨ ЗАСАХ ОРНЫ ЦЭН ДҮН СИЯНЫ "ҮХРИЙН ЭВЭРТ" УУЛЫН БУРХАН ШАШНЫ ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Нэг:** газар зүйн байрлал " Үхрийн эвэрт" уулыг Чин дүн сия хотоос 20 километрийн зай дахь хатан голын зүүн эрэгт байрладаг. Жүн нин сия ба Чин дүн сия нь хөндлөн сундалж уул нурууны нийт талбай нь 440 кват километр байдаг. Өмнөөс хойно зүгийн хадтай байц, баруун бэл нь эгц асга, зүүн бэл нь налуухан байдаг унжлагатай тус уулын бас нэгэн онцлог гэвэл хоёр оргил нь өргөгдөц нь зөвхөн 4.5 метрийн зөрөөтэй ихэр хоёр асгаар барилдаж, хоёр асга нь хоорондоо зөвхөн 500 метрийн зайтай байж холоос харахад үхэрийн эвэр шиг учраас "Үхрийн эвэрт" уул гэдэг нэрийдэлтэй болжээ.

**Хоёр:** түүхийн ул мөр: " Үхрийн эвэрт" уулын газрын байцыг даган бурханы шашны сүм хийд луглайн сүндэрлэж, нарс майлс хөхрөн Нiншиан бурханы шид орох гэлтэй. Хол ойрдоо алдартай "Их диваажин" "Бага диваажин" "Алтан эрдэнийн суварга" гэх мэт олон бурхан шашны сүм хийд байж өргөн олон сүсэгтэний жаргалын орон юм. "Ниншианы түүх": "Шүвв фан тэмдэглэл" зэрэг түүхийн ном сударт тэмдэглэснээр : "Үхрийн эвэрт" уулын бурханы сүм хийд эрт урьдаас хөгжөөнтэй байж бурхан багш Шахимуни бие илаарч бурхан ном уламжилж "Их хүлэг"-ийн номыг үлдээсэн уламжлал яриа байдаг ба дундад улсын дөрвөн их бурхан шашны нэрт уултай зэрэгцээ байдаг. Чин улсын Эе бээр засагчийн арван найман оны (1661) "Гурван хувилгаан" сүмийг дахин байгуулсан хөшөөнд тэмдэглэснээр : "Үхрийн эвэрт" уул бол Си Сияны бурхан шашин уул ажээ. Эрт Хан Дан улсын үесээс эхлэн байгуулж хийсэн байна. Чин Төр Гэрэлт хааны "Усан дусал сүмийн хөшөө"-нд тэмдэглэснээр : "Үхрийн эвэрт" уулын сүм хийд Дан улсын Зе хатны үе эхлэн байгуулж, Мин улсын Ван Лигийн үед засан сөнөөв" гэсэн байна. "Өлзийт сүм" –д тэмдэглэснээр: "Үхрийн эвэрт" уулан сүмийг Данаас эхлэн байгуулав гэж тэмдэглэж байна. Ойроос нэг зууны тэртээ "Үхэрийн эвэрт" уулны бурхан сүмүүд Чин гүрэний бүрэн засагч хоёрдугаар онд "Ма хува лүн" сүмийг эвдэж хөмрөг байгуулж 1944 оны 9 сард Ма хун хүй баруун хойдын цэргийн эрхтэн

сүмийг эвдэж, цэргийн бэхлэлт байгуулсан.1958 оны уулсыг хагалж чулуу үйлдвэрлэн ойг хөнөөж материал цуглуулж, 1966 оны соёлын хувьсгалын гай зовлон зэрэг дөрвөн удаагийн эвдрэлээр дамжаад эцэст нь түүхээ уламжилсан бөгөөд сүм хийд цөм устав. Одоогийн байгаа сүм хийдийн олонх нь дундад улсын 13он (1924) сэргээн байгуулагдсан юм.

**Гурав:** Одоогийн байдал: “Үхрийн эвэрт” уулсын бурханы шашны хийд нь баруун хийд болон зүүн хийд хоёр их бүрэлдэхүүнтэй. Баруун хийд нь “Түмэн сахиусын дээд” “Шүвв пиеэ дияан “ИХ диваажин” “Бага диваажин” “Аршийн сүм” “Гурван зүүн хийд нь алтан эрдэнийн хийд, Жу овогтын хийд, Бугийн хийд, Хатан гол хийд зэргээр хийдүүд баригджээ.

## ЦАГААН ЛЯНХУА ХОТЫН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Нэг: Цагаан лянхуа хотын газарзүйн байршил : Цагаан лянхуа хот нь манай улсын таван төр арван зургаан улс (304-409) оны үеийн Хеэнийн тэргүүн Хе Лиян Бүе Бүеийн байгуулсан Их Сиян улсын ниислэлийн бууръ мөн. Бас “Элжигин Чихт хааны хот” гэдэг одоогийн өвөр монголын өртөс өндөрлөгийн зүүн өмнө зах, Эү Дин Хе гол Хун Лиү Хе голын хойно эрэг дэх Шаши мужийн Девжин Сияны Хун Дүн Зияа балгасын Би Чен тосгонд байршиж байна.

Хоёр: Цагаан лянхуа хотын түүхийн ул мөр:Таван шадуны түүхийн үеийг өнгөрч одоогийн байдалтай болжээ. Анхны хөгжлийн шаду гэвэл баруун Хан улсын Шав Ян Сияны хатны суурин дээр өртөө байгуулав. Умард Ви улсын Сия Мин Ди хааны үеийн л Ду Яваны тэмдэглэснээр : Ви Лияны долдугаар онд Июү ши усны умард, хар голын өмнө Их Жанжин Лиян Хүн ли томилон тус хотыг байгуулж Цагаан лянхуа хот гэж нэрийлээ.

Таван төр арван зургаан улсын үед Хенүгийн Тияв Пе ястан Ордосын зүүн өмнө хэсэгт суурьшиж байжээ. Хе Лиян Бүе Бүе хаан суусны долдугаар жил (413он) Хе Лиян Бүе Бүе арван түмэн иргэнийг зохион байгуулж, арван жилийн хугацааг хэрэглэн Цагаан лянхуа хотыг хөгжүүлэн байгуулжээ. Энэ бол Цагаан лянхуа хотын хамгийн оргилын үе мөн. Гэвч он тооллын 427 онд Цагаан лянхуа хуа Умард Ви улсад дийлэгдэн эзлэгдэв. Энэ бол хоярдугаар түүхэн Шаду үе

мөн. Дан улсын сүүлчид Данийн төрд хувиралт гарч Дэн Чиян хүн зүчи нүүдэллэж Цагаан лянхуа хот Дэн Чиян хүнд эзлэгджээ.

Баруун Сия 1217 онд Япон улсад мөхөгдөв. Монголчууд газар нутгаа өргөтгөн Цагаан лянхуа хот улс төр, цэргийн явдал, арилжаа худалдааны аль талаар тийм их байр суурьгүй болж, удаан түүх ул мөр хоосон болж хоцорчээ.

Газар нутгийн элсэрхэгээс болж Цагаан лянхуа хот элсний гүнд булandaв. 1841 онд Хувай Яван Сияны ноён Эде Бин Шиүн дээр Шадуны орон Ли Си Лингийн заавраар Цагаан лянхуа хотын буурийг мөрдөн байцааж ертөнцийн нүдэнд Цагаан лянхуа хот дахин илрэв.

Гурав: Цагаан лянхуа хотын одоогийн байдал: Цагаан лянхуа хотынбуурь нь Гадар хот ба Тодор хот хоёр хэсгээс барилджээ. Тодор хот нь мөн зүүн хот ба баруун хот зэрэг хоёр хоттой.одоогоор үлдээж байгаа хамгийн бүрэн дүүрэн хотын Тодор хотын баруун хот болно.

## ОЛОН НОХОЙН ЧАРГЫН ТУХАЙ

Нэг: газарзүйн байршил: Олон нохойн чарга нь Өвөрмонголын өртөө засах орны Ордос хотын отог хошууны гүн чарга балгасны өмнө хэсэг байрладгаар байршлын байгаа тосгоныг мөн олон нохойн чарга гэж нэрлэдэг. Орон байрын хувьд авч үзвэл тус газар нь өмнө талаар Шинэ зуу сумын ногоотой гацаа баруун талаар Арвис сумын Шилбээ гацаатай хөршилдөж, хошууны засгийн газрын төв улаан балгасаас 95 километр зайтай байж Арзай агуйгаас 20 километр зайтай байдаг, газарзүйн чигээр зүүн уртрагийн 10757”, умард өргөргийн 3959”-д байрлаж байна. Буурийн байршлын газар геологийн унжлага нь цөлөрхөг тал нутгаар голлож, буурь нь зууван хэлбэртэй тэгш доворхог байдаг.

Хоёр: Олон нохойн чаргын түүхийн ул мөр: Олон нохойн чаргын ирэлтийн тухай: Хэн зохион байгуулж байгуулсан нь одоо хүртэл яг тодорхой түүхэн тэмдэглэл байгаагүй байсаар зөвхөн ардын уламжлал ярианд яригдахаар: “Нэг нь Сүн улсын жанжин Яан Ян зуу зэрэг цэрэг морьдын усны асуудлыг шийдвэрлэхийн төлөө нум сумаар харваж гаргасан гэдэг. Бас нэг уламжлал яриа гэвэл

эзэн богд Чингис хаан баруун Сияг дийлэхэд энэ хэсгээр ан агнал хийж байгаад авын нохдыг чангалснаас хүн томилон худаг малтаж ус гаргасан байна. Гэхдээ тус орны хүн “Олон нохойн чарга” гэж нэрлэдэг. Одоогийн судалгааны үр дүнгээс харахад олон нохойн чарга нь Сүн Юуван улсын үед малтагдсан нь итгэмжээр их шиг байна.

Нийтийн он тооллын 1226 онд их богд Чингис хаан баруун Сияг эзлэхээр хатантайгаа хамт зургаа дахь удаагийн дайныг эхэлсэн байдаг. “Монголын нууц товчоо” –ны 265 хэсэгт тэмдэглэснээр их богд Чингис хаан нохой жилийн намар хатантайгаа цэрэг дагуулан Тангадыг дийлэхээр мордов. 1226 оны өвлийн үеээр богд Чингис хааны цэрэг ордост хүрч ирээл отог хошуунд Хатан голын эрэгт тангадын цэрэгтэй эсэргүүцэлджээ. “Монголын нууц товчоо”-нд бас тэмдэглэснээр “ Өвөл ар бөхөд хүрээ ав хийж байгаад их богд Чингис хаан мориноос ойчиж шархдав. Түүхэнд тэмдэглэснээр ар бөх бол одоогийн ордосын Арибөхийг хэлж байгаа. Шуурхайчид гэдэг нь олон уулт газар гэдэг утгатай. Судлаачдын үздэгээр ар зайг хэлж байна гэдэг. Дээрх олон түүхэн үнэн болж олон монгол газрын айн нотлолтоос үзвэл их богд Чингис хаан тангад. Тухайн цэргийн хөдөлгөөн отог хошуу орчимд цэргийн усны асуудал нь цэргийн ялалттай шууд холбогддог. Ар зайгаас 20 километрийн зай дахь олон нохойн чаргын үлдэгдэл нь үүнтэй холбоотой байдаг.

Гурав: Олон нохойн чарга: Өвөрмонголын өртөө засах орны арын чулуун агуйгаас 20 километрийн зайд нэг хэсэг нэг хавтгай 4 километр хүрэхгүй хэмжээнд 80 гаруй гүн худаг байрлаж ихэд аугаа сүрлэг байдаг.

Нүд алдам өндөрлөгт урт нь 3000 метр өргөн 100 метр 80 гаруй худаг бүрэн тархаж гүндээ арав гаруй метр худгийн хана унжгай гүн оромгүй худагт буудаг алс шуруйд булагдахаас сэргийлэн метр орчим чулуун халхавчийг байгуулсан байдаг. Тус гөзрын малчид айлын хэлснээр энд 108 гүн худаг байсан гэнэ. Он цагийн улирлаас болж алс шуруйд булагдан одоо зөвхөн 80 гаруй үлдэж байна.

[illegible]

ᠮᠣᠩᠭᠣᠯᠴᠤᠳ ᠤᠨ ᠲᠣᠪᠴᠢ》 ᠬᠡᠮᠡᠬᠦ ᠪᠠᠷ ᠪᠢᠴᠢᠭᠳᠡᠭᠰᠡᠨ ᠪᠣᠯᠤᠨ᠎ᠠ ::

ᠪᠠ 《ᠠᠯᠲᠠᠨ ᠲᠣᠪᠴᠢ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢ》, 《ᠦᠢᠯᠡ ᠶᠢᠨ ᠬᠣᠷᠢᠶᠠᠩᠭᠤᠢ》, 《ᠰᠢᠷ᠎ᠠ ᠲᠤᠭᠤᠵᠢ》, 《ᠪᠣᠯᠣᠷ ᠲᠣᠯᠢ》, 《ᠡᠷᠳᠡᠨᠢ ᠶᠢᠨ ᠲᠣᠪᠴᠢ》, 《ᠨᠢᠭᠤᠴᠠ ᠲᠣᠪᠴᠢᠶᠠᠨ》 《ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠨ ᠲᠣᠪᠴᠢ》 ᠰᠤᠳᠤᠯᠤᠯ ᠤᠨ ᠪᠦᠲᠦᠭᠡᠯ ᠦᠨ ᠲᠣᠬᠠᠢ ᠳᠤ ᠬᠡᠯᠡᠪᠡᠯ ᠡᠨᠡ ᠪᠦᠲᠦᠭᠡᠯ ᠬᠡᠯᠡᠨ ᠬᠡᠯᠡᠯ ᠬᠡᠯᠡᠨ ᠰᠤᠳᠤᠯᠤᠨ ᠲᠣᠪᠴᠢ ᠪᠢᠴᠢᠭᠳᠡᠭᠰᠡᠨ ᠪᠠᠢ᠌ :: ᠪᠦᠲᠦᠭᠡᠯ ᠬᠡᠯᠡᠨ ᠲᠣᠪᠴᠢᠶᠠᠨ᠂ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠨ ᠪᠢᠴᠢᠭ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠨ ᠪᠢᠴᠢᠭ ᠦᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠬᠡᠯᠡᠨ ᠦ ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ ᠳᠤ ᠣᠯᠠᠨ᠎ᠠ ᠡᠷᠭᠦᠭᠳᠡᠭᠰᠡᠨ ᠦ 13 ᠣᠨ (1924) ᠲᠥᠷᠥᠭᠰᠡᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠭᠳᠠᠭᠰᠠᠨ ᠠᠵᠤ ::

ᠰᠤᠷᠭᠠᠭᠤᠯᠢ ᠳᠤ ᠰᠤᠷᠤᠯᠴᠠᠬᠤ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠬᠡᠯᠡᠨ ᠦ ᠰᠤᠷᠭᠠᠭᠤᠯᠢ ᠶᠢ ᠲᠡᠭᠦᠰᠦᠭᠡᠳ ᠡᠷᠳᠡᠮ ᠰᠢᠨᠵᠢᠯᠡᠬᠦ ᠤᠬᠠᠭᠠᠨ ᠤ ᠬᠦᠷᠢᠶᠡᠯᠡᠩ ᠳᠦ ᠠᠵᠢᠯᠯᠠᠭᠰᠠᠨ ᠪᠥᠭᠡᠳ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠬᠡᠯᠡᠨ ᠤᠳᠬ᠎ᠠ ᠵᠣᠬᠢᠶᠠᠯ ::

ᠤᠨ ᠪᠢᠴᠢᠭᠳᠡᠯ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠭᠳᠠᠭᠰᠠᠨ᠂ 1958 ᠣᠨ ᠡᠷᠳᠡᠮ ᠤᠨ ᠵᠡᠷᠭᠡ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠵᠤ ᠰᠤᠷᠭᠠᠭᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠪᠠᠭᠰᠢ ᠪᠠᠷ ᠠᠵᠢᠯᠯᠠᠭᠰᠠᠨ ᠲᠤᠷᠰᠢᠯᠲᠠ ᠳᠤᠯᠤᠭᠠᠨ ᠳᠤ᠂ 1966 ᠣᠨ ᠤ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠨ

ᠬᠡᠯᠡᠨ ᠦ ᠨᠢ ᠰᠤᠳᠤᠯᠤᠯ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠭ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠭᠳᠠᠵᠤ᠂ 1944 ᠣᠨ ᠤ 9 ᠰᠠᠷ᠎ᠠ ᠠᠴᠠ ᠡᠬᠢᠯᠡᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠭ ᠰᠤᠷᠭᠠᠭᠤᠯᠢ ᠳᠤ ᠬᠠᠮᠲᠤ ᠳᠤ ᠰᠤᠷᠤᠯᠴᠠᠨ ᠬᠡᠯᠡᠨ ᠦ ᠨᠢ ᠰᠤᠳᠤᠯᠤᠨ᠂ ᠬᠠᠮᠲᠤ

ᠰᠤᠷᠤᠭ ᠤᠨ ᠨᠢᠭᠡ ᠬᠡᠰᠡᠭ ᠦ ᠬᠡᠪᠯᠡᠯ 《ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠨ ᠲᠣᠪᠴᠢ》 ᠰᠤᠳᠤᠯᠤᠯ ᠤ ᠪᠢᠴᠢᠭ ᠬᠡᠯᠡᠨ ᠦ ᠪᠠᠷ ᠬᠠᠮᠤᠭ ᠪᠦᠬᠦᠨ ᠦ ᠪᠢᠴᠢᠭ ᠰᠤᠷᠤᠯᠴᠠᠨ ᠣᠨ ᠤ ᠬᠤᠷᠢᠶᠠᠩᠭᠤᠢ

ᠰᠤᠷᠤᠯᠴᠠᠭᠰᠠᠨ ᠬᠡᠯᠡᠨ ᠦ 《ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠡᠪᠯᠡᠭᠰᠡᠨ ᠪᠠᠷ 《ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠨ ᠲᠣᠪᠴᠢ》 ᠰᠤᠳᠤᠯᠤᠯ ᠬᠡᠯᠡᠨ ᠦ ᠨᠢ ᠬᠡᠮᠡᠨ ᠬᠡᠷᠡᠭ ᠰᠤᠳᠤᠯᠤᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠭᠳᠠᠵᠤ ᠪᠠᠶᠢᠭ᠎ᠠ ᠬᠡᠪᠯᠡᠭᠰᠡᠨ ᠪᠠᠶᠢᠨ᠎ᠠ ::

ᠬᠡᠯᠡᠨ ᠦ ᠬᠡᠯᠡᠨ ᠬᠠᠮᠤᠭ ᠤᠯᠠᠭᠠᠨ ᠳᠤ ᠳᠡᠭᠡᠷ᠎ᠡ ᠰᠤᠳᠤᠯᠤᠨ ᠤ ᠰᠤᠷᠤᠭ ᠰᠤᠳᠤᠯᠤᠯ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠭᠳᠠᠵᠤ᠂ ᠬᠠᠮᠤᠭ ᠤᠯᠠᠭᠠᠨ ᠳᠤ ᠲᠡᠭᠦᠨ ᠦ ᠰᠤᠷᠤᠭ ᠡᠴᠡ ᠬᠡᠯᠡᠨ ᠰᠤᠳᠤᠯᠤᠭᠰᠠᠨ》 ᠬᠡᠮᠡᠨ ᠪᠠᠶᠢᠨ᠎ᠠ :: 《

ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠭᠳᠠᠵᠤ ᠬᠡᠮᠡᠨ ᠪᠠᠶᠢᠨ᠎ᠠ :: ᠲᠤᠬᠠᠢ ᠰᠤᠳᠤᠯᠤᠭ ᠬᠡᠪᠯᠡᠭᠰᠡᠨ ᠰᠤᠷᠤᠯᠴᠠᠨ ᠤ 《ᠰᠤᠳᠤᠯᠤᠨ ᠰᠤᠳᠤᠯᠤᠯ ᠬᠡᠯᠡᠨ ᠦ ᠳᠤ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠭ》 ᠢ ᠰᠤᠳᠤᠯᠤᠭᠰᠠᠨ ᠬᠡᠷᠡᠭ᠂ 《ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠨ ᠲᠣᠪᠴᠢ》 ᠰᠤᠳᠤᠯᠤᠯ ᠤ

ᠰᠤᠳᠤᠯᠤᠭᠰᠠᠨ ᠬᠡᠷᠡᠭ 《ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠨ ᠲᠣᠪᠴᠢ》 ᠰᠤᠳᠤᠯᠤᠯ ᠪᠠᠷ ᠪᠠᠨ ᠰᠢᠨ᠎ᠡ ᠳᠤ ᠪᠢᠴᠢᠭ ᠲᠡᠦᠬᠡ ᠰᠤᠳᠤᠯᠤᠯ ᠬᠡᠮᠡᠨ :: ᠰᠤᠳᠤᠯᠤᠯ ᠰᠢᠨ᠎ᠡ᠂ ᠬᠡᠮᠡᠨ ᠤᠯᠠᠭᠠᠨ ᠳᠤ ᠰᠤᠷᠤᠭᠰᠠᠨ ᠪᠠᠢ᠌ ᠬᠡᠯᠡᠨ

ᠲᠤᠬᠠᠢ ᠤᠯᠠᠭᠠᠨ ᠳᠤ ᠰᠤᠳᠤᠯᠤᠨ ᠬᠡᠯᠡᠨ ᠳᠦ ᠰᠤᠳᠤᠯᠤᠨ ᠰᠢᠨ᠎ᠡ ᠣᠨ ᠤ (1661) 《ᠡᠷᠳᠡᠨᠢ ᠶᠢᠨ ᠲᠣᠪᠴᠢ》 ᠢ ᠬᠡᠮᠡᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠭᠳᠠᠭᠰᠠᠨ ᠪᠢᠴᠢᠭ》 ᠳᠦ

ᠰᠤᠳᠤᠯᠤᠭᠰᠠᠨ ᠰᠤᠳᠤᠯᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠪᠠᠶᠢᠵᠤ᠂ ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ ᠳᠤ ᠬᠡᠪᠯᠡᠭᠰᠡᠨ ᠲᠣᠪᠴᠢ ᠪᠢᠴᠢᠭ ᠦ ᠰᠤᠳᠤᠯᠤᠨ ᠰᠤᠳᠤᠯᠤᠯ ᠬᠡᠮᠡᠨ ᠲᠡᠭᠦᠨ ᠦ ᠪᠣᠯᠤᠨ᠎ᠠ ::

[illegible] (413 [illegible]) [illegible]

[illegible]

[illegible] (304--409) [illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible] 1841 [illegible]

[illegible] 1217 [illegible]

[illegible] 427 [illegible]

ᠵᠠᠷᠢᠮ ᠪᠠᠶᠢᠨ᠎ᠠ ::

ᠡᠨᠡᠬᠦ ᠤᠨ ᠬᠣᠪᠣᠷᠬᠠᠨ ᠢ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠤᠯᠠᠭᠠᠨ ᠨᠣᠮ ᠳᠤ ᠣᠷᠣᠭᠤᠯᠤᠭᠰᠠᠨ ᠪᠠᠶᠢᠨ᠎ᠠ᠂ ᠮᠥᠨ ᠡᠨᠡ ᠨᠢ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠨ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯᠳᠠ ᠳᠤ ᠪᠠᠶᠢᠨ᠎ᠠ

ᠣᠷᠣᠭᠤᠯᠤᠭᠰᠠᠨ ᠪᠠᠶᠢᠨ᠎ᠠ᠂ ᠮᠥᠨ ᠪᠠᠰᠠ ᠬᠣᠶᠠᠷ ᠤᠨ ᠣᠨ ᠤ ᠪᠣᠯᠪᠠᠯ 《 ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠤᠯᠠᠭᠠᠨ 》 ᠨᠣᠮ ᠳᠤ ᠣᠷᠣᠭᠤᠯᠤᠭᠰᠠᠨ ::

ᠪᠣᠯᠤᠨ ᠪᠠᠢᠭᠠ ᠶᠢᠨ ᠪᠠᠶᠢᠭᠠᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠶᠠᠯᠠᠯ ᠤᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ᠂ ᠬᠡᠯᠪᠡᠷᠢ ᠵᠢᠨ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯᠳᠠ ᠶᠢᠨ ᠪᠠᠶᠢᠳᠠᠯ ᠤᠨ ᠲᠥᠯᠦᠪ᠂ ᠰᠤᠳᠤᠯᠤᠯ ᠤᠨ ᠠᠷᠭ᠎ᠠ᠂ ᠪᠣᠯᠪᠠᠰᠤᠷᠠᠯ ᠢ ᠵᠣᠬᠢᠶᠠᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠬᠤ

ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ ᠤᠨ ᠲᠡᠷᠭᠡᠭᠦᠨ ᠳᠦ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠭᠳᠠᠬᠤ ᠠᠮᠢᠲᠠᠳ ᠤᠨ ᠵᠦᠢᠯ ᠳᠦ ᠣᠷᠣᠭᠤᠯᠤᠭᠰᠠᠨ ᠪᠠᠶᠢᠨ᠎ᠠ :: ᠡᠨᠡ ᠨᠢ ᠲᠤᠰᠬᠠᠢ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯᠲᠠᠢ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠭᠳᠠᠬᠤ ᠵᠦᠢᠯ ᠢ ᠵᠣᠬᠢᠶᠠᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠬᠤ

ᠶᠠᠮᠠᠷ ᠴᠤ ᠠᠷᠭ᠎ᠠ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠬᠡᠷᠡᠭᠯᠡᠬᠦ ᠳᠦ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯᠲᠠᠢ ᠪᠠᠶᠢᠬᠤ : 《 ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠵᠦᠢᠯ 》 ᠢ ᠮᠥᠷᠳᠡᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠪᠣᠯᠣᠨ ᠠᠮᠢᠳᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠣᠷᠴᠢᠨ ᠲᠣᠭᠣᠷᠢᠨ ᠳᠤ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠤᠯᠠᠭᠠᠨ ᠨᠣᠮ ᠤᠨ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯ ᠤᠨ ᠵᠦᠢᠯ᠂ ᠡᠨᠡ ᠨᠢ ᠪᠠᠶᠢᠭᠠᠯᠢ ᠶᠢᠨ ᠪᠠᠶᠠᠯᠢᠭ ᠢ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠬᠤ ᠬᠠᠤᠯᠢ ᠴᠠᠭᠠᠵᠠ ᠶᠢᠨ ᠳᠠᠭᠠᠤ ᠪᠠᠶᠢᠨ᠎ᠠ

ᠰᠤᠳᠤᠯᠭ᠎ᠠ : ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠤᠯᠠᠭᠠᠨ ᠨᠣᠮ ᠤᠨ ᠬᠣᠶᠠᠳᠤᠭᠠᠷ ᠬᠡᠪᠯᠡᠯ

ᠪᠠᠶᠢᠨ᠎ᠠ ::

ᠪᠠᠶᠢᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠪᠠᠶᠢᠷᠢᠰᠢᠯ ᠤᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠶᠢᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠳᠤᠮᠳᠠᠳᠤ ᠬᠡᠰᠡᠭ ᠲᠦ ᠣᠷᠣᠰᠢᠵᠤ᠂ ᠪᠠᠶᠢᠭ᠎ᠠ ᠢᠨ ᠲᠣᠭᠠᠨ ᠳᠤ ᠬᠢᠷ ᠤᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ

20 ᠮᠢᠩᠭ᠎ᠠ ᠭᠠᠷᠤᠯ ᠪᠠᠶᠢᠨ᠎ᠠ᠂ ᠬᠣᠶᠠᠷ ᠤᠨ ᠤᠨ ᠳᠠᠯᠠᠢ ᠶᠢᠨ ᠲᠡᠪᠰᠢᠨ ᠡᠴᠡ 107°57′᠂ ᠬᠣᠢᠳᠤ ᠥᠷᠭᠡᠷᠭᠡ ᠶᠢᠨ 39°59′ ᠳᠤ ᠪᠠᠶᠢᠷᠢᠰᠢᠵᠤ ᠪᠠᠶᠢᠨ᠎ᠠ ::

ᠲᠤᠬᠠᠢ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡ ᠬᠣᠶᠠᠷ ᠤᠨ ᠪᠦᠬᠦᠯᠢ ᠶᠢᠨ᠂ ᠰᠤᠳᠤᠯᠤᠯ ᠤᠨ ᠨᠢᠭᠡ ᠨᠢ ᠬᠣᠶᠠᠷ ᠨᠢ ᠵᠦᠪᠯᠡᠯ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠪᠠᠶᠢᠭ᠎ᠠ ᠲᠠᠢ 95 ᠮᠢᠩᠭ᠎ᠠ ᠭᠠᠷᠤᠯ ᠪᠠᠶᠢᠨ᠎ᠠ᠂ ᠲᠡᠭᠦᠨ ᠦ ᠲᠠᠯ᠎ᠠ ᠲᠠᠢ

ᠲᠤᠷᠰᠢᠯᠲᠠ ᠪᠠᠶᠢᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠰᠤᠳᠤᠯ ᠲᠠᠢ ᠲᠠᠯᠪᠢᠬᠤ ᠲᠣᠬᠢᠷᠠᠯ᠂ ᠭᠠᠵᠠᠷ ᠬᠣᠶᠠᠷ ᠨᠢ ᠲᠡᠭᠦᠨ ᠢ ᠬᠣᠶᠠᠷ ᠨᠢ ᠬᠠᠢ ᠨᠢ ᠬᠤᠪᠢ ᠶᠢᠨ ᠳᠣᠲᠣᠭᠠᠳᠤ ᠬᠣᠶᠠᠷᠢᠨ᠂ ᠪᠠᠢᠭᠠᠯ ᠬᠣᠶᠠᠷ ᠨᠢ ᠲᠡᠭᠦᠨ

ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠭᠰᠠᠨ ᠤᠨ᠂ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠬᠤ ᠳᠤ ᠪᠠᠶᠢᠨ᠎ᠠ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯ ᠤᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠤᠯᠠᠭᠠᠨ ᠨᠣᠮ ᠳᠤ ᠣᠷᠣᠭᠤᠯᠤᠭᠰᠠᠨ ::

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠤᠯᠠᠭᠠᠨ ᠨᠢ ᠲᠤᠰᠬᠠᠢ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯᠲᠠᠢ ᠳᠤ ᠲᠤᠰᠬᠠᠢᠯᠠᠨ ᠬᠣᠷᠢᠭᠯᠠᠭᠰᠠᠨ ᠠᠮᠢᠲᠠᠳ ᠢ ᠲᠤᠰᠬᠠᠢ ᠠᠷᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠲᠤᠰᠬᠠᠢ ᠰᠤᠳᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢ ᠪᠦᠬᠦ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯ ᠢ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠨ

ᠰᠤᠳᠤᠯᠤᠭᠠᠴᠢᠳ ᠨᠢ ᠣᠨ ᠳᠠᠷᠠᠯᠠᠯ ᠨᠢ 1226 ᠣᠨ ᠳᠤ ᠴᠢᠩᠭᠢᠰ ᠬᠠᠭᠠᠨ ᠲᠠᠩᠭᠤᠳ ᠤᠯᠤᠰ ᠢ ᠳᠠᠶᠠᠯᠠᠬᠤ ᠶᠢᠨ ᠡᠮᠦᠨ᠎ᠡ ᠠᠪᠤ ᠵᠢᠯ ᠤ ᠬᠠᠷᠠᠭᠠᠨ ᠪᠠᠷ ᠲᠡᠮᠳᠡᠭᠯᠡᠭᠰᠡᠨ ᠪ ᠬᠠᠮᠲᠤ ᠤ ᠲᠡᠮᠳᠡᠭᠯᠡᠯ ᠪᠠᠢᠨ᠎ᠠ :: ‹‹ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠨ ᠨᠢᠭᠤᠴᠠ ᠲᠣᠪᠴᠢᠶᠠᠨ›› 265 ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠳᠦ ᠴᠢᠩᠭᠢᠰ ᠬᠠᠭᠠᠨ ᠲᠠᠩᠭᠤᠳ ᠤᠯᠤᠰ ᠢ ᠳᠠᠶᠠᠯᠠᠬᠤ ᠪᠠᠷ ᠣᠴᠢᠵᠤ ᠶᠠᠪᠤᠭᠠᠳ ᠬᠤᠳᠠᠯᠳᠤᠭᠰᠠᠨ ᠤ ᠬᠡᠰᠡᠭ ᠲᠦ ᠪᠣᠢ ᠮᠣᠷᠢᠳᠠᠨ ᠤᠨᠠᠵᠤ 1226 ᠣᠨ ᠤ ᠨᠠᠮᠤᠷ ᠴᠢᠩᠭᠢᠰ ᠬᠠᠭᠠᠨ ᠲᠠᠩᠭᠤᠳ ᠤᠯᠤᠰ ᠢ ᠳᠠᠶᠠᠯᠠᠨ ᠮᠣᠷᠳᠠᠵᠤ ‹‹ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠨ ᠨᠢᠭᠤᠴᠠ ᠲᠣᠪᠴᠢᠶᠠᠨ›› ᠳᠤ ‹‹ᠨᠣᠬᠣᠢ ᠵᠢᠯ ᠦᠨ ᠡᠴᠦᠰ ᠲᠦ ᠮᠣᠷᠳᠠᠪᠠ›› ᠬᠡᠮᠡᠨ ᠲᠡᠮᠳᠡᠭᠯᠡᠭᠰᠡᠨ ᠪᠠᠢᠨ᠎ᠠ :: ᠡᠨᠡ ᠨᠢ ᠬᠥᠯ ᠤᠨ ᠡᠷᠳᠡᠮ ᠦᠨ ᠡᠷᠭᠢᠯᠲᠡ ᠳᠦ ᠴᠢᠩᠭᠢᠰ ᠬᠠᠭᠠᠨ ᠲᠠᠩᠭᠤᠳ ᠤᠯᠤᠰ ᠢ ᠳᠠᠶᠠᠯᠠᠬᠤ ᠶᠢᠨ ᠡᠮᠦᠨ᠎ᠡ ‹‹ᠬᠠᠪᠤᠷ ᠤᠨ ᠡᠬᠢᠨ ᠳᠦ ᠬᠠᠷᠢᠶᠠᠯᠠᠭᠰᠠᠨ›› ᠬᠡᠮᠡᠨ ᠲᠡᠮᠳᠡᠭᠯᠡᠭᠰᠡᠨ ᠢ ᠬᠡᠯᠡᠵᠦ ᠪᠠᠢᠨ᠎ᠠ :: ᠬᠡᠷᠪᠡ ᠡᠭᠦᠨ ᠢ ᠨᠣᠬᠣᠢ ᠵᠢᠯ ᠦᠨ ᠡᠴᠦᠰ ᠲᠦ ᠨᠡᠢᠯᠡᠭᠦᠯᠪᠡᠯ ᠵᠢᠯ ᠦᠨ ᠳᠣᠷᠣᠭᠰᠢ ᠪᠣᠯᠵᠤ ᠪᠠᠢᠨ᠎ᠠ :: ᠡᠨᠡ ᠪᠣᠯ ᠮᠠᠨ ᠤ ᠲᠣᠭᠠᠴᠠᠭᠠᠨ ᠤ ᠤᠯᠠᠮᠵᠢᠯᠠᠯ ᠲᠠᠢ ᠵᠣᠬᠢᠴᠠᠵᠤ ᠪᠠᠢᠨ᠎ᠠ ::

ᠡᠭᠦᠨ ᠢ ᠬᠡᠯᠡᠬᠦ ᠳᠤ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠨ ᠤᠯᠠᠮᠵᠢᠯᠠᠯᠲᠤ ᠵᠢᠯ ᠲᠣᠭᠠᠯᠠᠯ ᠳᠤ ᠴᠢᠩᠭᠢᠰ ᠬᠠᠭᠠᠨ ᠲᠠᠩᠭᠤᠳ ᠤᠯᠤᠰ ᠢ ᠳᠠᠶᠠᠯᠠᠬᠤ ᠳᠤ ᠮᠣᠷᠳᠠᠭᠰᠠᠨ ᠵᠢᠯ ᠢ ᠬᠡᠯᠡᠬᠦ ᠳᠦ ᠡᠭᠦᠨ ᠡᠴᠡ ᠪᠤᠰᠤ ᠵᠢᠯ ᠳᠦ ᠪᠣᠯᠵᠤ ᠪᠠᠢᠨ᠎ᠠ :: ᠡᠨᠡ ᠨᠢ ᠵᠢᠯ 20

ᠵᠢᠯ ᠦᠨ ᠬᠣᠭᠣᠷᠣᠨᠳᠤ ᠪᠠᠢᠭᠠ ᠨᠣᠬᠣᠢ ᠵᠢᠯ ᠢ ᠳᠠᠭᠤᠷᠢᠶᠠᠨ ᠬᠡᠯᠡᠵᠦ ᠪᠠᠢᠭᠠ ᠶᠢᠨ ᠲᠤᠯᠠ ᠡᠨᠡ ᠵᠢᠯ ᠢ ᠮᠣᠷᠢᠨ ᠵᠢᠯ ᠦᠨ ᠡᠴᠦᠰ ᠬᠡᠮᠡᠨ ᠤᠶᠠᠯᠳᠤᠭᠤᠯᠬᠤ ᠪᠣᠯᠤᠨ᠎ᠠ ::

ᠡᠬᠢᠯᠡᠯ : ᠮᠣᠷᠢᠨ ᠵᠢᠯ ᠦᠨ ᠡᠴᠦᠰ ... (ᠭᠠᠷ ᠪᠢᠴᠢᠭ)

ᠡᠭᠦᠨ ᠦ ᠳᠠᠷᠠᠭ᠎ᠠ ᠨᠢ ᠮᠣᠷᠢᠨ ᠵᠢᠯ ᠦᠨ ᠡᠴᠦᠰ ᠲᠦ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠨ ᠵᠢᠯ ᠲᠣᠭᠠᠯᠠᠯ ᠤᠨ ᠲᠠᠪᠤᠨ ᠵᠢᠯ ᠤᠨ 20 ᠡᠭᠦᠨ ᠡᠴᠡ ᠬᠣᠶᠢᠰᠢ ᠡᠬᠢᠯᠡᠬᠦ ᠪᠣᠯᠪᠠᠰᠤ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠨ ᠤᠯᠠᠮᠵᠢᠯᠠᠯᠲᠤ ᠵᠢᠯ ᠲᠣᠭᠠᠯᠠᠯ ᠪᠣᠯᠵᠤ ᠪᠠᠢᠨ᠎ᠠ :: ᠲᠡᠭᠦᠨ ᠦ ᠨᠠᠰᠤ ᠶᠢ 80 ᠭᠡᠵᠦ ᠲᠣᠭᠠᠴᠠᠭᠰᠠᠨ ᠪᠠᠢᠨ᠎ᠠ ::

ᠡᠨᠡ ᠮᠡᠲᠦ ᠲᠣᠭᠠᠴᠠᠭᠠᠨ ᠳᠤ 3000 ᠵᠢᠯ ᠂ ᠨᠢᠭᠡ 100 ᠵᠢᠯ ᠤᠨ ᠬᠣᠶᠠᠳᠤᠭᠠᠷ ᠤᠨ 80 ᠨᠠᠰᠤᠨ ᠲᠣᠭᠠᠴᠠᠭᠠᠨ ᠪᠣᠯᠪᠠᠰᠤ ᠂ ᠭᠡᠪᠡᠴᠦ ᠂ ᠨᠠᠰᠤ ᠮᠠᠨ ᠳᠤ ᠨᠡᠢᠯᠡᠭᠦᠯᠬᠦ ᠂ ᠲᠣᠭᠠᠴᠠᠭᠠᠨ ᠤ ᠪᠠᠷ ᠂ ᠡᠨᠡ ᠡᠴᠡ ᠬᠣᠢᠰᠢ ᠂ ᠨᠢᠭᠡ ᠵᠢᠯ ᠦᠨ ᠲᠣᠭᠠᠴᠠᠭᠠᠨ ᠪᠣᠯᠪᠠᠰᠤ ᠂ ᠲᠣᠭᠠᠴᠠᠭᠠᠨ ᠤ ᠶᠠᠮᠠᠷ 80 ᠨᠠᠰᠤ ᠬᠦᠷᠴᠦ ᠪᠣᠯᠵᠤ ᠪᠠᠢᠨ᠎ᠠ :: ᠡᠭᠦᠨ ᠢ ᠮᠠᠨ ᠤ ᠲᠣᠭᠠᠴᠠᠭᠠᠨ ᠤ ᠪᠢᠴᠢᠭ ᠲᠦ ᠬᠡᠯᠡᠬᠦ ᠳᠦ ᠮᠣᠷᠢᠨ ᠵᠢᠯ ᠦᠨ ᠡᠴᠦᠰ ᠲᠦ ᠪᠠᠷᠢᠭᠰᠠᠨ ᠶᠢᠨ ᠬᠣᠶᠠᠳᠤᠭᠠᠷ ᠨᠢ ᠮᠠᠨ ᠤ ᠨᠠᠰᠤ 80 ᠭᠡᠵᠦ ᠲᠣᠭᠠᠴᠠᠭᠰᠠᠨ ᠪᠣᠯᠤᠨ᠎ᠠ :: ᠡᠨᠡ ᠨᠢ ᠵᠢᠯ ᠦᠨ ᠲᠣᠭᠠ ᠪᠣᠯᠵᠤ ᠵᠢᠯ 108 ᠨᠠᠰᠤᠯᠠᠭᠰᠠᠨ ᠪᠣᠯᠬᠤ ᠶᠢᠨ ::

# МОНГОЛ ЛАМ НАР, ЭРДЭМТДИЙН ТҮВДЭЭР БИЧСЭН ЛИ ОРНЫ ТУХАЙ СУДАЛГАА

## ӨВӨР МОНГОЛЫН ЛАМ ДАРАМДАЛАЙН СУДАЛГАА

Өвөр монголын баарин хошууны гэвш дарамдалагийн бүтээл ИХ МОНГОЛ ОРНОО БУРХАНЫ ШАШИН ДЭЛГЭРСЭН ТҮҮХ гэх номноос ишлэбэл: Тухайн эрдэмтэн маань тэр үеийн улс төрийн өнгө аястай зохиол бүтээлээ тууривасан байдаг, их эртнээс бидний гарал үүсэл Бөртө чоно, Гоо марал нарыг түвдийн Нятизамбуу хаанаас гаралтай хэмээн эхлэдэг, гэвч түүхийг тойрч гарна гэж байдаггүй учир ил эрдэмтний бүтээлд манай сэдвийн дагуу ишлэх зүйл олон буй за.

Монгол орон нь Энэтхэгийн баруун зүгээс умард хязгаар хүртэл маш уужим агуу их мөн тэдгээрээс Энэтхэгийн зүүн хойт зүгийн их Монголын орноо Лало нэрийн төдийхөн ч үгүй болой. Туган ринбүүчийн зохиосон Тогтсон таалал Болор толь д Солон ба Баргуудын аймаг зарим нэгээс бусад Монголын оронд тиртига хийгээд лало тэргүүтний үзэл нэрийн төдийхөн ч үгүй бөгөөд урьдын гарсан Сажа ба Гармагийн үндсийг баригчид нь ч одоо үгүйн тул Шар малгайтны үнэн ёсон ямагтаар түгээмэл болсон болно гэж номлосон байна.

Тиймийн тул энэхүү орон нь Бурхан багшаас Шашин умраас умарт дэлгэрнэ гэж иш үзүүлсний хоёрдугаар умард мөн болно энэ нь Бурхан багшийн сургааль номлосон газар газар одоогий пакистан афганистан биш гэдгийг нотлож байгаа хэрэг билээ.

Тэр мэтчилэн Түвдийн зүгт Шар гэртэн Цагаан гэртэн Хар гэртэн гэх гурав байна. Шар гэртэн нь Хөх нуурын умар зүгт долоо найман хоног явах газарт Шар гэрт хэмээх Монголын язгуур угсаатан бүхий тэднийг хэлнэ. Тэр нь Гонлүн хамба Агваангэлэгжамцын мэндэлсэн орон мөн. Тэр нутагт Бадахор хийдийн ором суурь нь ч бий гэнэ. Цагаан гэртэн нь Хам газрын эхний хувьд Ма мөрөн, Ври мөрөн, Зан мөрөн гэх гурван мөрөн бүхий Ври мөрний харьяанд багтах газарт монгол язгуурт Цагаан гэрт хааны нутаг бий болой.гэдгээр гэсэр хааны туулиас ишлэн монгол газар нутгийн байршлыг тогтоожээ.

Мөнхүү : Жамбалзаржүд буюу Манзуширийн үндсэн дамжлага судраас Хятадад манзушир машид бүтэх болно гэж Бурхан багш өөрөө манзуширийг адислан Хятад оронд иш үзүүлснийг тодолжээ. Иймээс Манзушир бурханы орон гэдгийг ишлэн үзүүлжээ. Билгийн зүрхэн хэмээх сударт Бурхан багш айлдсан үг байддаггүй боловч Жанрайсиг бурхан, Шаарийбуу хоёрыг адислан айлдуулсан байдаг. үүнийг бурханы сургааль гэдэгчилэн Манзушир бурханыг адислан хажууд заларсан байж болох гэсэн нэг санаа гарч ирж байгаа юм.

Бас нэг ишлэл дурьдвал : Хан улсын 26 хаан гарсны тавдугаар ҮДИ хааны үед монголын нутгаас авчирсан бараан дотроос Бурхан багшийн сэрэг дүр нэгийг олж түүнийг тахиснаар хятад оронд бурханы шашин дэлгэрэхийн эхлэл байсан гэсэн нь хятадаас өмнө монголчууд Бурханы шашинтай байсныг хятадын өөрийн эх сурвалжаас олж нотолжээ.гэх мэт ховор баримтуудыг Дарамдалай гэвш хөндөн тависан байдаг.

## ХАЛХЫН ИХ ЭРДЭМТЭН ЗАВА ХЭМЭЭХ ДАМДИН ГАВЖИЙН СУДАЛГАА

**"ИХ МОНГОЛ ОРОНД БУРХАНЫ ШАШИН ДЭЛГЭРСЭН ТҮҮХ" бүтээлийн эшлэлийг дурьдвал:**

Монголын газарзүйн тойм Монголын төв нутгийг өмнөд умард төв гэсэн гурван хэсэгт хуваадгийн төв хэсэгт нь хуучнаар Халх долоон хошуу буюу өдгөө дөрвөн хошуу хийгээд дөрвөн аймаг наян засаг хошуунд алдаршсан буй бөгөд түүний газрын хэлбэр байрлал нь Баруун талаасаа нууцын эзэн Очирваанийн орд харш Отгонтэнгэрийн уул нурууд болон гол мөрнүүд зүүн талаасаа Махаранз тийн сонсогчийн хөвгүүний \Намсрай\ орд харш хэнтий ханы уул нурууд болон гол мөрнүүд өөр хоорондоо харилцан чандмана баясгалант уйлгын \гачил\ хэлбэрт зөрөлдсөн газрын төв хүйс нь ямар мэт мэргэний эрхт Зая бандид бээр: Эзэн хаан Очир бээр Их монголын Очирт суурин Хоёрдугаар Бурхант лугаа адил Эрдэнэд алдаршсан зууг байгуулсан хэмээн зарлигласан мэт Монгол төв нутгийн уурхай Эрдэнэзуугийн хийд хийгээд Замбуутивийн умар зүгийн амьтаны цэцэг туссан хувьт бурхан аврал итгэлт их Очирдара Жавзандамба хутагтын их суурин газар цогт Да хүрээ

тэргүүтэн их бага номын аймгийн чуулган тэнгэрийн нар сар од гурвыг элэглэхийн ёсонд оршин буй билээ Мөнхүү замбуу тивийн газрын голд байдаг болохоор Халх тэргүүтэн монголын төв нутгийн хүмүүсийн нүүрний хэлбэр нь Замбутивийн хэлбэр мөн болой хэмээн Миндол Номун хан бээр номлосон болой. Халхын баруун хойт, хойт, зүүн хойт тэргүүтэнд Урианхайн олон аймаг ба Хамняган тэргүүтэн Монголын олон аймаг байдаг бөгөөд урьд цагт ихэнхдээ онгодод аврал одуулан шүтэж байсан боловч эдүгээ ихэнх нь Бурханы номд орсон билээ Тэдгээрийн умард хаяа залган Буриад баруун хошуу байдаг юм. Халхын өмнө зүгт олон мянган бээр үргэлжлэх энгүй их ээрэм талыг гэтэлбээс Монголын дөчин ёсөн их хошуу цахар найман хошуу тэргүүтний аймаг байваас өвөр дөчин ёсөн их хошуу тэдгээрийг Их зуу, Улаанцав, Шилийн гол Жирэм, Зуун уд, Зос буюу их зургаан аймагт Манзушири их эзэн хаан бээр хуваасан байдаг билээ. Өвөр монголын дөчин ёсөн их хошуу нь Ордосын зургаа юм уу долоон хошуу, Түмэдийн хоёр, Баарингийн хоёр, Найман болон Ухайн нэг, Огнядын хоёр, Цоохор халхын нэг, Хишигтэний нэг, Ар хорчингийн нэг, Зүүн хорчингийн арав, Зүүн түмэдийн нэг, Монголжин харчингийн нэг Харчин гурван хошуу сэлт буюу зургаан чуулганд хураасанууд болой. Тэдгээрээс хятад монголын завсарын Нинша хэмээх хятад хотын ойролцоо Ордосын отог хошууны нутагт Хатан голын амны Үхэр уул хэмээхүйд Гомосала суварга хэмээн алдаршсан гайхамшигтай нэгэн орон шүтээн байдаг юм Урьд тэнд нэгэн маань ч лам бээр эвдэрснийг сэргээж үйлдэхийн тухайд гадна талын бүтэн хагас алдын хэмжээтэй давхар суваргыг эвдээд доошоо ухсаны дотор машид баттай хөх цагаан чулууны дотроос хумхын дээд цээжин тал нь хүний биеийн хэмжээ төдий чулуун суварга гарсны хумхын өмнө талд нэгэн өчүүхэн хайрцагны дотор жүлада адил \ лада мэт зүйлээр урласан \ улбар шаргал өнгөтэй номын хувцас хийгээд нэгэн өчүүхэн судар байсан ба хумхын доод тал нь хөх чулуунаас ургасан мэт байсныг малтаж гаргасан ч тахилд агуулсан болой. Хумхын дээр нь аяганы амсрын чинээн ёсөн нүх байсан тэргүүтнийг олон хүмүүн нүдээр үзсэн зэрэг гайхамшигтай зүйл олон байв.Дараа нь хуучинаар булж сэргээсэн нь одоо ч хятад, түвд, монголчуудын мөргөлийн газар болжээ.Эгүүний газрын байрлал нь Ли орны зүүн хязгаар лугаа нийлэлдэх бөгөөд өмнөд хатан голын ард, алагшаагийн архад зуны оршил зохиосон ба умарт нь нинша хэмээх хот цайз болон баруунд нь лүнжүгийн жүгмирийн

их бурхан амгалан гарахын орон байна гэжээ.

Эрдэмтэн сүмбүү хамба Ишбалжар бээр:Суварга Гомасалаганда түүнийг хятадын хаан бээр тахих ба түвд монголд ойрхон хэмээгээд Манлан гүрү богд болон Богд зонхава гэгээний багш ловон Рэндаваа тэргүүтэй мэргэд очиж үзээд Үхэрт уулын суварга эгүүнийг Гомасалаганда хэмээн алдаршсан нь мөн хэмээн таалсан байдаг. Ли орны хотонгуудын газар нутагт буй хэмээн "Судар нарны зүрхэн "ээс гарсан ишлэл гэж айлджээ.Тэгээд Үхэрт уулын энэ суварга нь Балба орны суварга хутагт шингүн ба ли орны Гомасалаганда адил бөгөөд үр мөн чанарын үүднээс ялгалгүй долоон үеийн Бурхад заларсан тэдгээрийн лагшингийн ренсүрэлийг хадгалсан нь эргэлзээгүй гэжээ.

Эрдэмтэн Заваа хэмээх Дамдин гавжийн бас нэгэн эшлэлд :Ли орны эглийн хэл нь энэтхэг хятад хоёртой адилгүй, үсэг нь хятадтай нилээд төстэй, ертөнцийн ёс нь хятадтай ихэнх нь адил, номын ёс ба номын хэл нь энэтхэгтэй бараг адилхан байжээ.Тэндэхийн Бурханы шашинт хаан бээр Зармаан гэх хийдийг байгуулав. Тэрхүү хаан Түүнчлэн заларсан Бурханыг үзэхийг хүсэхэд гэлэн Бэйрузана бээр Бурхан багшийг шавь нарын хамтаар хувилгаж үзүүлжээ.

Тэр үед хаан сүжиг төрөөд маш сайнаар тахил өргөсөн тэр үеийн Бурхан багш ба шавь нарын өлмийн мөр үлдсэн гэдэг. Арван зургаан архад их эрдэнийн идээний хэрэгсэл нэг нэгийг өргөснийг санд нуугаад ЛИ орны шашин доройтох цагт хуврагуудын хэрэгсэл болгохоор хадгалжээ. гэж судард дурьдагдсан бол,

Мөн нэгэн лусын хаан бээр Хачэ орны долоон бурханы чандараар сүншиглэсэн суврагыг залж ирээд ЛИ орны Зармаа хийдэд залжээ.

Тэндээс долдугаар үеийн хааны үед Майдарын хувилгаан ли богд Бизаябиргяа хэмээгч гараад, дөрвөн архадыг энэтхэгээс залахын тулд Гүмадирийн сүмийг босгов. **Бас үхэр толгой уулын дээр Гэүдошангийн хийдийг бариад хааны нэг хүү архадын үрийг олсон нь ли орны хамгийн** анхны архад мөн тул мөрийг үзүүлэгч буюу дэрму гүдэши хэмээн нэрийдэв. Хожим бүх хутагт нарыг тийнхүү алдаршуулах болсон.

Түүнээс хойш гуравдугаар хааны үед хаан Бизаяа хэмээгч бээр хятадын хааны охин Бунэяашурийг авав. Архад Самгха гошааг урин залаад суварга болон хийд олныг байгуулжээ. Хаан түүнд

гурван хүү байсаны том нь энэтхэгт оджээ. Дунд хүү нь архадын үрийг олсон юм.

Харин бага хүү Бизадхарма нь хаан болоод Дродири хэмээгч урьд Сарангэрэл хааны тэргүүнээ өглөгт өгсөн нутаг хийгээд ли орныг эш үзүүлэх үед Бурхан багш болон Газрын зүрхэн хоёр бээр адисласан Чадашого ууланд Бродирийн хийдийг байгуулав. Түүний ууган хүү Доддой хятад оронд алагдах түшмэлийнхээ оронд өөрөө очсонд цус нь сүү болон гараад алж чадаагүй бөгөөд хаан бээр эд таваар өгсөнөөр Саддирийн хийдийг байгуулжээ. Бизаядхармаан хүү Бизаясидха бээр Соманийн хийдийг байгуулсан юм. Бизаягирди дрүня хийдийг байгуулав. Бизаясамгарма Дхадмадира хийдийг байгуулав. Бизаясидха Шусэрма хийдийг байгуулаад Майдарын цагийн тахилыг эхлүүлэв.Түүнээс хойш долдугаар хаан Бизаясамгарма бээр бурхан лагшингийн дүрс огторгуйгаас залрах хийгээд Зөөлөн цогт МАНЗУШРИ болон Газрын зүрхэний тухайд мохорагийн тахилыг эхлүүлүэв. Түүнээс тавдугаар үеийн хаан Бизаягирди бээр Бхани хийдийг байгуулав.Түүнээс тавдугаар үеийн хаан Бизаягирди бээр Бхани хийдийг байгуулав. Түүнээс гуравдугаар үеийн хаан Бизаягирди бээр Бхани түвдийн нийслэлд Майдар бурхан бүтээсэн бөгөөд түүнээс ли орон түвдийн доор орсон байна.ингэж холилдон байсныг түвдээс шашин дэлгэрсэн мэт үзэж болохгүйг заваа лам баримтан тулгуурлан нотолжээ.Ер нь ли орны долдугаар хаан Бизаягирдийн үед архад Гэндүнпэл бээр Хоёр мянган жилийн хойно шашин жаргах бөгөөд тэр цагт төвд оронд хятадын нэгэн гүнж болон долоон хийд гарах ба хятадын хаан бээр дэүшагийн ёсыг барьснаар хятадын шашин жаргах хийгээд суваргын дэргэд лус Элаан навч бээр биеэ орхиж, ли болон түвдийн бүх хуврагууд энэтхэгт очоод Гоушамба хийдэд бүгд бие биенээ хөнөөнө. Тэр цагт нийт замбутивд шашин доройтно хэмээн эш үзүүлсэн бөгөөд **ер нь ли орон Шагжамуни бурханы хорин нэгдүгээр ордон мөн хэмээн номложээ.** Энэхүү ли орныг малаяапхор, бага тогар, үтэн, хутэн, хотон тэргүүтэн нутаг нутгийн хэллэгээр нэрлэдэг бөгөөд **Үхэрт ууланд эш үзүүлсэн** судар болон ли орныг эш үзүүлсэн хэмээн нэршсэн. **Хир үгүй гэрэл нэрт охин тэнгэрийг эш үзүүлсэн** судар нь уулыг эш үзүүлсэн, орныг эш үзүүлсэн, бодьгалыг эш үзүүлсэн гэх гарчигийн ялгаанаас өөр ерөнхий өгүүлэгдэхүүний суурь утга нэг байна. Судраас эш үзүүлсэн

ли орон түүнийг балбууд буюуНепалууд Намсрай болон Моугалын хөвүүн бээр усыг нь шавхсан газар нь балбын Памтин мөн хийгээд Гомасалагийн суварга нь Пагбашингүн мөн гэж үзсэн ба балбын өөрийн нутгийн мөрний цаад эргийн талыг балба гээд, наад талыг ли орон хэмээн нэрлэж үйлддэг ажээ. Түүнчлэн түвдийн рон нутгийн багш рондон Шэйжагүнриг тэргүүтэн түвдийн эрт болон эдүгээ үеийн олон мэргэд бээр ч ли орон гэдэг нь балба орон мөн хэмээн өгүүлжээ.Тэгэхээр судлаач хүн бээр нэг талыг барих ёсгүй учир байгаа асуудалыг нухацтай авч үзэх хэрэгтэй. Бурхан багш миний шашин умраас умарт дэлгэрнэ гэж хойшоо харж зогсоод айлдсан байдаг тэгэхээр балбаас хойшоо хараад зогсохоор афганистан пакистан зэрэг дундад азийн орнууд харагдана тэгэхээр миний бие энэ арай ч биш боловуу гэж бодож байна. яагаад гэвэл нэгдүгээрт газарзүйн хувьд таарахгүй эгүүнийг мөн" үхэрт ууланд бошголсон судapт" умар зүгт цэнгэг устай далай бий түүнийг Бурхан багш адисласан байдаг энэ нь байгаль далай байх магадлалтай гэж үзэж болно.Хоёрдугаарт :хатан голын эрэг дээрхи үхэр хад уул гэж дээрхи судapт заасан тул тэр нь балбад алга байна гэж бас болохоор байна.Гэвч балба монгол хоёр нь гарал үүсэл нэгтэй гал махьбодтой ширба нар байдаг учир бас балбыг монгол нутагт оруулж болох талтай.

Мөн Эрдэмтэн заваа хэмээх Дамдин гавж маань дээр хийсэн нотолгоогоо үгүйсгэсэн тайлбарыг бас хийжээ.Богд Манлүнба болон багш Рэндава нар бээр хятад орны гансү мужын Нинша хотын ойролцоо газарт Нюүшан хэмээх уул буй түүнд Гомасала нэрт суварга байгаа тул түүнийг ли орон мөн гэж үзэх хэрэгтэй хэмээн номложээ гэсэн мөртөө тэдгээр номлолууд нь балба болон хятад орны тухайн уул ба суваргын аль алинд судраас эш үзүүлсэний адил төстэй төдий зүйл харагдаж байгаагаар шалтгаалан ертөнцийн яриа лугаа зохилдуулж өгүүлсэн төдий болохоос, судрын утгатай ерөөсөө таарахгүй байна. Учир нь тэдгээр нутагт Үхэр уулыг эш үзүүлсэн судрын эш үзүүлсэн бусад зүйлүүдийг нэг бүрчлэн оноох зүйл юу ч байхгүй бөгөөд Цагийн хүрдний дандараас ли орон нь түвдийн хойно байдаг хэмээн зарлигласантай зөрчилдөж байгаа юм. Түүнийг тодруулваас "Сударын аймагийн нарны зүрхэн" ээс Кашагийн нутгийн газрын хөхийн орон, үхэр уулын өмнө, Галада мөрний хойгт Чадагч аршийн орон Гомосала гандха суварга хэмээгч

их суваргын орон нь лусын эзэн бээр өгсөн тул гарт нь хадгалуулахыг тушаамой. хэмээн зарлигласаныг каша нутаг нь хүннүгийн нутагтай ойр нутаг хэмээн үзэх хэрэгтэйг дээр өгүүлсэн мэт Зөөлөн цогтын үндсэн дандараас: Ли орон, түвд, балба хэмээсэн байдаг бол гэвш Долүнба бээр: Энэтхэгийн баруун зүүнд ли ба балбын орон хэмээн ли балба хоёрыг тусдаа улс орон хэмээн зарлигласан байна.

**Бас Жомдан Ригбийралди бээр**: Газар хөхөгчийн эзэлсэн ли орон нь энэтхэг түвдийн завсарын балба биш хэмээжээ.

**Баву Зүглагба бээр**: Гадаад дотоодын долоон орон зургаан орны цаг учралын ли орон нь балба байх боломжгүй. Учир нь тэр түвдийн хойно байх ёстой атал балба нь дээд даваа болон аарийгийн завсарын өмнө талд байна шүү.гэж гзарзүйн хувьд байх боломжгүй хэмээн судлаач надтай адил нотолгоо хийжээ.

**Эрдэмтэн аваа хэмээх Дамдин бээр**: дээр өгүүлсэн бага тогар буюу хэүтэн хэмээх орон тэр нь **Үхэр уулыг эш үзүүлсэн судраас зарлигласан ли орон** мөн болох нь магадтай байна. **Учир нь тэр нь түвд орны хойно байгаа хийгээд энэтхэг, хятад, түрүг, монгол, түвд тэргүүтэн бээр дамжин гарсан хуушан Пахияан болон Тансингийн замын тэмдэглэл,** Зандан зуугийн домог, уйгарын сурвалж бичгүүдэд түүнийг Ли орон мөн болох учрыг тодорхой гаргасан байгаа болой. Тэр нь ч хятад түвд монголын газрын уулзвар монголын Годан хаан бээр Сажа бандидааг урин залсан хот Лянжу дөрвөн аймаг хэмээн алдаршсаны баруун өмнө зүгт "Үхэр уулын судраас эш үзүүлсэн" үхэр уул хийгээд хот тосгон, гол мөрөн, суврага бурханы дүр, орон хийд тэргүүтэн яг тэр ёсоор байгаа боловч эдүгээ лалууд эзэлсэн тул суврага болон орон хийдүүд нь ором туурь төдийгөөс өөр зүйл үлдээгүй бөгөөд бурханы лагшингийн дүрүүдийн томоор нь тариалангийн усны хаалт, багаар нь хүүхдийн тоглоом хийсэн байна гэж сонссон. Үхэр уул түүнийг өдгөө лалууд бээр горубэшэ, гоума мөрийг гоушаси мөрөн хэмээн нэрлэж байна гэсэн. Түвд монголын зарим мэргэд нийт монгол орныг ли орон хэмээн оноосоор байгааг шинжлэх хэрэгтэй. Учир нь тэгвээс энэхүү монгол орон нь Цагийн хүрднээс номлосон зургаан орны дотроос ли орны газар нутгийн дотор багтах хийгээд Зөөлөн эгшигт их дээдсийн (манжын хаан) Илт шастир хэмээх сурвалж бичигт Ойрод ба халх тэргүүтэн гадаад монголчуудын бүгд зөвхөн хотонгийн аймагт багтана хэмээн номлосон тэргүүнтэй ихэд

зохилдож байгаа болович, банчэн орныг (Цагийн хүрднээс номлосон) зургаан орны их хятадын орон хэмээх үзсэн байдаг жаахан зөрж байна гэж үзэж байгаа нь Заваа лам маань ли орны тухайд жаахан эргэлзээтэй байгаа нь харагддаг..

Ямар ч байсан хятад болон түвд оронд бурханы шашин дэлгэрэхээс машид өмнө монгол оронд бурханы шашин дэлгэрсэн нь тодорхой юм. Түвдээс өмнө хятад оронд шашин дэлгэрсэн түүх нь ихэд түгээмэл билээ. Харин монгол оронд хятадаас ч өмнө шашин дэлгэрсэн түүх нь хятад оронд шашин залрахын өмнө урьд өгүүлсэн Цинвангийн үеэс хятад монгол хоёр газар нутгаа булаалдан тэмцэлдэх үед хятадын цэргүүд монголын орон хийдүүдийг сүйтгэж, сүм болон лагшин зарлиг тааллын шүтээнүүдийг эвдэн шатаах зэрэг таагүй үйл олныг үйлдэж байсан тухай" Хувилгаан толь" хэмээх хятад, монгол, манжийн сурвалж бичигт номлосон байдаг. Хангийн үед хятадуудын монголчуудаас булаасан газар нутгуудад байсан монголын зарим нэгэн хуучин хийдүүд одоо хятадын хийд болсон хийгээд монгол хийдийн туурь гэсэн зүйл ч олон байдаг хэмээн хятадууд ярьдаг юм.

Тэр нь ч хятад оронд хан гүрний арван дөрөвдүгээр үеийн хаан Минди хааны үеэс бурханы шашин түгэн дэлгэрсэн бөгөөд тэр үед хятад орноос энэтхэгийн төв нутагт очсон их хэлмэрч нарын анхдагч Пахиян хуушан хэмээгч бээр Ханши хааны ширээнд суусан хоёрдугаар онд (энэтхэг) хутагтын орноос гурван аймаг савын номыг залахын тулд Шэн анпүгээс наран шингэх зүгийн замд гараад зорчихуйяа бэрх уул даваа, гол мөрнийг гаталсаар хятад, түвд, монгол гурван завсар дүнхуанд уйгурын сэрүүн орнуудаас Шэнаша хэмээх оронд очиход хаан нь ном төгөлдөр хийгээд түүний дэргэд дөрвөн мянга шахам хуврагууд бага хөлгөний номд суралцаж байжээ. Үхэрт уулын сударт: Умар зүгт Шэнаша хэмээх оронд Түүнчлэн Бурхан заларсаны Шэнаша хэмээх дүрс газрын дотроос гарах хийгээд орны хил хязгаарыг сахих болно хэмээн эш үзүүлсэн орон бас таарч байгаа юм.

# ПАХИЯАН ХУУШААНЫ ЗАМЫН ТЭМДЭГЛЭЛ

**Пахияан хуушаан баруун зүгт зорчиход зам зуурын уйгурын нутгуудад дээдийн ном түгэн дэлгэрч,** өөрсдийн орны хэл байсан ч хуврагууд нь энэтхэг хэлэнд суралцаад, энэтхэг судрын дагуу ном хурж байжээ.Түүнээс цааш 15 хоног яваад үжа оронд ирэв.Мөн тэнд дөрвөн мянга орчим лам хуврагууд бага хөлгөний номонд шамдан суралцаж винай ёсыг нарийн чанд мөрдөж байв. Тэндэхийн хаан Гүнзүн бээр Пахияан хуушанд зам зуурын хүнс хайрласныг аваад баруун өмнө зүгийг чиглэн аглаг хоосон талууд хийгээд, аймшигт мөрнийг гатлан нэг сар тав хоног явж хэүтэн буюу ли оронд хүрсэн юм.Тэр орны бүх хүмүүс жаргалтай дээдийн номыг шүтдэг ба суварга олон сүм хийд тоолж баршгүй олон бөгөөд хэдэн түмээр тоолох хуврагтай тэд бүгд их хөлгөний ном баримталдаг ба винайн ёсыг чанд сахидаг байжээ.Тэр орны хаан Пахияаныг Гүмадирийн хийдэд байрлуулаад хэрэгтэй эд зүйлсийг гарган өгч хүндэтгэв.гэж биччээ. энэ нь Ли орныг эш үзүүлсэн сударт : Алин цагт миний асрахуйн газарт, Энэхүү ли орон гарах аваас, Гүмүдирийн үзэсгэлэнт орон энд, Гайхамшигт номын хааны суварганд, залран номхотгох болно гэсэн эшлэл ном дагуу таарч байгаа нэг нотолгоо юм.Хэүтэн гэж тэмдэглэгдээд байгаа нь одоогийн хүйтэний цаст оргилууд байж мэдэх талтай. Пахияан хуушан цааш тэмдэглэхдээ: Тэндэхийн хүмүүс хаан албатгүй бүгдээр дээдийн номонд сүжигтэй байсан гэжээ. Тэр орон жилбүр 4-рсарын нэгнээс 15ны хүртэл "шүтээний тив эргэх"хэмээх ёслолыг өдөр бүр хийд тус бүрээс алт мөнгөөр бүтээсэн бурхан бодьсадва нарын гайхамшигт лагшингуудыг дөрвөн дугуйтай морин тэргэн дээр торго даавуугаар урласан, янз бүрийн их эрдэнээр чимэглэсэн асарын дотор залаад хуврагууд угталгын хөгжимүүдтэйгээр их хотын зүг явдаг ажээ.Тэр үед хотын зээлийн газруудыг сайтар чимэглэн, хотын үүдэнд том дэвсгэр бэлтгэж, түүн дээр элдэв янзын тахилыг эгнүүлэн тавьж хаан хатан бээр голлосон үзэсгэлэнт бүсгүйчүүл эгнэн зогссон байдаг.Морь тэрэгтэй шүтээн гол хаалганы өмнө 100 орчим алхамд ирэхэд хаан их л хүндэтгэлийн байдалтай хөл нүцгэн титэм шинэ хувцастай цэцэг хүж барьсаар, дотоодын олон түшмэлээ дагуулсаар гарч шүтээнүүдийг угтан мөргөж тахил өргөж байв.Шүтээнийг хаалгаар

ороход залуу охид бүсгүйчүүл хаалганы дээрхи сайн гэх өргөөнөөс цэцгийн хур доош буулгаж баясал үйлдэх бөгөөд сүжигтэн хүмүүс шүтээн хуврагуудад тахил өргөн мөргөн хүндэлдэг цагийн их баяр болой.Үхэрт ууланд бошголсон сударт:Басхүү энэ орон миний их дүрийг морин тэргэнд залан Буянт хэмээх хотын дотор авчраад тахилгын орон болгох гэсэн үгтэй Пахияаны тэмдэглэлийн утга дүйж байна.Энэ ёслол нь Өнөөгийн майдар эргэх ёслолтой дүйж байгаа бололтой.

Эргэн Пахияан хушаны тэмдэглэлд орвол : Ли орноос гараад хорин тав хоног яваад зүхожи гэх оронд очив. Тэр оронд бас л шашин дэлгэрсэн их хөлөгний номлол дагадаг мянга шахам хуврагуудтай хийд оронгууд байв гэжээ. Эгүүнийг Эрдэмтэн Заваа Дамдин гавж бээр : Монголын өмнөд аймаг их хухангийн орон "Ли орныг иш үзүүлсэн" сударт гардаг ГАРДО орон мөн хэмээн нотолжээ.

Цааш Пахияан хушангийн тэмдэглэлд монгол гэх ли орны тухай гарахгүй боловч замын бичгийг товчлон хурааж тойм төдий оруулая.Тэндээс гарч өмнө зүгт 4 хоног яваад цүнлүн хэмээх уулын дотор орж юүхо иү гэх газар хүрч алжаалаа сэргээв.Ахин 25 хоног зам хөөж хачи буюу одоогоор исламын шашинтай пакистан хавьцаа очжээ.Тэндээс энэтхэгийн хойд хэсгийг зүглэн оджээ. Аймшигт цасан уулын дундуур нэг сарын турш зүдэрч явж байж арай гэж энэтхэгийн хойд хязгаарт хүрэв. Тэнд бурханы сургаалийг хайсан боловч нутгийн багш нар винай болон бусад бүх сургаалийг цээжээр уншдаг тул судар нэгийг эс олов. Цаашлан нутгийн гүн магадха д очив.Тэнд зургаан жил сууж санскрит хэлэнд суралцаж, гурван аймаг номын савыг судлаад зэди хийдийн архадуудын эмхэтгэсэн гурван аймаг савын номыг зээлэн авав. Ингээд өмнөд энэтхэгээр дамжин усан онгоцонд суугаад сингалыг тивд очоод хоёр жил суужээ. Дараа нь худалдаачидын онгоц даган явсаар хятад орондоо эргэн ирж Винайн судрыг өөрөө хятад хэлэнд орчуулан шашин амьтаны тусыг ихээр үйлджээ.

## "ТАНСИН ЛАМ баруун газар зорчисон нь" тэмдэглэлээс

Пахияны энэтхэгт морилсноос гурван зуу орчим жилийн хойно их тан гүрний маха бандида Тансин лам хэмээн алдаршсан тэр бээр хутагтын оронд зорчих хэрэгтэй гэсэн тааллыг үүсгээд, тангийн хоёрдугаар хаан Тайзүнгийн үед энэтхэгярианы хэлэнд суралцаж, замын тэмдэглэлийг бариад, баруун зүгт зорчсон юм. Гүцэн хийгээд дүнхуаны орныг дараалан дамжаад, монгол орны уйгурын хааны удмын нэгэн Гаучингийн ордонд очжээ. Урьд уулзаж байсан нэгэн худалдаачин түүнийг таниад Гаучин хаанд айлтгав. Хаан түүнийг дуудаад үг хэлэлцэн үйлдсэнээр таалал сэтгэлд нь нийцжээ. Хаан хатан нөхөр сэлтэд Билгийн чанадад хүрэхүй Гэгээн ялгуулсаны судар тэргүүтэн зарим нэгэн судар аймгийг номлов.

Өдгөө сагяугийн нутагт уулын нэгэн сэжүүр нурсаны мухраас бурханы олон дүрүүд олдсон тэр газарт Тансин лам бараа болоочдын хамт Энэтхэг рүү морилон яваа дүрүүд гарч ирсэнд, түүнийг үзсэн түвд монголчууд ихэд гайхсан хэдий ч, тэр нутаг нь урьдын Гаучингийн орон хэмээх нь энэ мөн болох нь тодорхой байна гэж Эрдэмтэн заваа хэмээх Дамдин лам нотолгоо бичжээ.

Тансингийн баруун газар зорчсон тэмдэглэлдээ эргэж орвол Хаан хатан хоёр дээдийн номыг тансин ламаас сонсож үнэнч шавь нар нь болсон тул явуулахгүй гэж хаантан энэлэл хатуугаар багшийгаа тахихын тухайд хориглон үйлдэвч сонсолгүйгээр, гурав хоног амжиргаагаа тасалсанд арга барагдаад, замын хүнсэнд зориулан зуун лан алт, гучин хүлэг морь, тавин нутгийн дээл, замын тэмдэглэлийн зүйл хорин дөрвийг өргөж, жаран морьтноор хамгаалуулан, монголын хаан Их хуханы дэргэд хүргэсэн юм. Бүх хувцасаа монголын хаанд бэлэг болгон өргөв. Монгол хаан бээр ч халамж хишиг хэмжээлшгүйг зохиосон хийгээд тэндээс тиезманыг хүртэл арван зургаан албат байгаа бүгд түүний эрхшээлийн доор байсан тул өдөр бүр арван морьтноор хамгаалуулан, уналага, идээ ундаа тэргүүтнийг бэлдэж, Махазина орны хаан бээр дүүгээ дээдийн номыг олуулахаар илгээсэн байна хэмээн тунхаг дуурсган илгээсэн байна.

Тиезман хэмээх бат төмөр хаалга тэр нь Их хан гүрний үед

урласан гэдэг бөгөөд хан гүрний баруун зүгийн хил мөн билээ. Тэндээс гараад тогарын харьяа орны хэсэг мянган мод газар байдгийг туулж, тэр хязгаараас эхлэн монголын өмнөд аймгийн хуханы орон мөн гэдэг юм. Тэр нь ч хятадын сурвалж бичигт их хухан хэмээн гарсан нь их хагаан гэсэн монгол орны хүмүүс бээр бидний удам угсаа (өвөг дээдэс) нь баруун зүгийн тэртээ их монголын гэдэг нэгэн байдаг хэмээн хуруугаар заах газар байхгүй ч ярьсаар байдаг орон нь мөн боловуу.

Тансин бээр тэндээсээ цаашлан явсаар арван дөрвөн жилийн турш энэтхэг орны төв хязгаар бүхэнд хэсүүчилж, адистэд ихтэйд алдаршсан орон болон шүтээн бүгдэд мөргөж, алдарт бандида бүтээлчин олонтой уулзаад суралцан зохиосоноор махабандидагийн суудлыг олсон тул гадаад дотоод бүгдэд их хөлгөний тэнгэр хэмээн яруу алдар нь дуурссан юм. Хятад орноос түрүү хожуу энэтхэгт очсон олон их багш байдаг ч хутагтын орныхны дунд их багшийн суудлыг олсон, олон хаадуудын тахилын орон болсон нь **гагцхүү их багш энэ мөн билээ.** Хутагтын орноос олон төрлийн гурван шүтээн хийгээд зарлиг шастирын энэтхэг судар олныг нэгэн их заанд ачаалан залаад эргэн буцсанаар хятад орны баруун хязгаар гуандийд иржээ. Түүнээс дотогш хаан бээр зарлиг бичгийг хүргүүлсэнчлэн улаагаар морилох үед гурван шүтээн нь арван дөрвөн морин тэрэгний ачаа болж байсан гэдэг. Тэр мэт хутагтын оронд арван дөрвөн жил, замдаа гурван жил, нийт арван долоон жилийн турш уул даваа олныг туулсанч, алжаал зүдрэл, хатуужил бэрхшээл юу ч гараагүй нь ер нь Тайзүн хаан газрын дээр эрх хүч ихтэй байсан хийгээд тэр үед энэтхэг хятад хоёр ч аль алин нь энх амгалан байсан, түүний дээрээс монгол хаадууд зохилдох шалтгааныг зохиосон тэр нь мөрд одсон, хамгийн гол нь их багш өөрийн таалыг үүсгэсэн болон үйлс ерөөл нэн ариун бүрдсэний хүч мөн хэмээн Хятад орноо ном дэлгэрсэн ёс номноос зарлигласан байна.

# ЭРДЭМТЭН АКАДЕМИЧ, ТҮВД СУДЛААЧ Д.ЦЭРЭНСОДНОМЫН НЭЭЛТ

Зууны мэдээ сонин. 2013.11.29-ны дугаар

Орчлонгийн дайдад бий хэмээн үлгэр домогт дурьддаг ч эрдэмтэн судлаачид олж тогтоож чадаагүй Тэнгэрийн орныг судлан хаана байгааг баттай зааж чадахаар болсноо академич Д.Цэрэнсодном өчигдөр зарлав. Түүнийг дугаарын зочноор урьж, шинжлэх шинэ нээлтийн тухай сонирхлоо.

Хүннүгийн газар нутгийг судалснаар үлгэрт гардаг Тэнгэрийн орон болохыг нь тогтоолоо гэсэн таны судалгаа анхаарал татлаа. Олон хүн үлгэр, домгийн дүрслэгдэхүүн болохоос бодитой зүйл биш гэж боддог бололтой?

Зава Дамдин гавжийн "Хор чойнжин" гэдэг номын "Алтан дэвтэр" бүлэгт эртний номт Ли орны тухай гардаг. Олон газрыг нэрлэсэн нь баахан үсчсэн маягтай. Тэр нь эрдэмтэн судлаачдыг Номт орон тэнд ч байж магадгүй, энд ч байж болзошгүй хэмээн санал бодлоо уралдуулах өгөөш болсон. Мэдэхгүй хүмүүсийн хувьд ёстой үлгэр домгийн орон гэж боддог байж болох. Ли орон чухам хаана байгааг тогтоох нь ач холбогдолтой гэдгийг эрдэмтэд ойлгож байсан. Гэвч тогтоож чадаагүй, энэ нь тэр ч байж магадгүй, энэ ч байж магадгүй хэмээн таамаг дэвшүүлж ирснээс ойлгогдоно. Би тэр бүхнээс үндэслэн 20 гаруй жил судалснаар Тэнгэрийн орон Ли Юүлийг тэр гэж хуруугаар заах газрыг тогтоолоо. Мөн нэрийг нь ч бас тогтоосон.

Хамгийн гол нь та тэнгэрийн орон бол Хүннүгийн нутаг гэдгийг юугаар нотолж байна вэ?

Би ч эхэндээ гайхаж байсан. Гэхдээ эргээд бодоход хүмүүс өөр, өөр газрыг нэрлэж байсан нь аргагүй юм билээ.Яагаад гэвэл тэр Ли орон эрдэм ном дэлгэрсний учир өргөсөн нэр юм байна. Ли Юүл гэдэг нь тэнгэрийн орон гэсэн гаралтай үг юм. Хүннүгийн нутаг агуу том шүү дээ. Хянганы нуруунаас эх авч Хятадын Цагаан хэрмийн хойд талаар Тангадын нутаг, Төвд баруун талаараа Тэнгэр уул, Эрээн хавирга, хойшоо Байгаль далай хүртэлх агуу том газар

нутгийг эзэмшиж байсан.

**Д.Цэрэнсодном:Тансан ламын очсон тэнгэрийн орон нь Хүннүгийн нутаг юм.**

Тийм агуу том орон олдвор нь энд тэндээс олдоод байна шүү дээ. Тэгэхээр тэр ч байж магадгүй, энэ ч байж магадгүй гэхээс аргагүй. Гэхдээ тэр орны зүрх, тархи, ууpаг нь хаана байна вэ гэдгийг бид сая тогтоолоо. Тухайлбал, Хатан гол, түүний хойг маягийн хэлбэр үүсгэн урсч буй газарт Тэнгэрийн орон бий гэж сударт заасан нь бий. Зава Дамдин гавж бол баруун талд нь Хотонгийн нутаг гэсэн, тэгвэл Хотонгийн нутаг гэсэн, тэгвэл хотончууд тэр хэсэгт бий. Хотонгийн нутагт хийсэн малтлагаар үхэр зоос гарсан байдаг. Энэ олдворууд бие биеэ баталж байгаа юм.Хамгийн гол нь "Хаадын уг гарвал, язгуур гэх бичмэл судар бий. Тэр судрын гурван хувилбар надад олдсон. Тэр сударт Ли орныг нутгийг зааж хэлээд байгаа юм.Тэдгээр зүйлүүд хөдөлшгүй баримтууд болж байна.

**Хатан голын хойг, Хүннүгийн үхэр шүтээн олон зүйлийг батална.**

Тэр тухай өгүүлсэн өөр судар бичгүүд байна уу?

Зава Дамдин гавжийн "Үхэр уулын эш үзүүлсэн судар", "Тансан ламын баруун этгээдэд зорчсон тэмдэглэл", "Хиргүй охин тэнгэрийн эш үзүүлсэн судар" зэрэгт Ли орны тухай бас гардаг. Тэгэхээр бурхан багшийн номлосон "Үхэр уулын эш үзүүлсэн судар" гэдгээс улбаалж "Хаадын уг гарвал, язгуур" гэх судар дотор үзвээс Үхэр уул нь Хатан голын хойг дотор байгаа юм. Харин Үхэр уулын дотор Хүмүслэн хад гэж бий.Тэр Хүмүслэн хад гэдэгт удаа дараа бурхан ирж адистад, дивангард үзүүлсэн гэж ном сударт тэмдэглэсэн нь бий. Тэгэхээр тэр бол Тэнгэрийн орон, тэнгэрийн авшигтай, адистэд оршсон газар юм гэсэн санаа тэнд байна. Тэнгэрийн орон гэдгийг таамгаар хэлж бас болохгүй.

Хамгийн гол нь яагаад Тэнгэрийн орон гэж нэрлэж, тэнд гэж оноож байна бэ?

Энэ бас учиртай. Хан улсын сударт Тэнгэр гэдэг үгийг Хүннү хэлээр Ченли гэдэг юм гэж тэмдэглэсэн байдаг. Эртний монгол хэлэнд tngri гэж бичнэ. Монгол хэлэнд т, ч үсгийг сэлгэдэг. Тэгэхээр тэнгэр гэдэг үгийг cenli гэж хэлэх, бичих бололцоотой. Р үсгийг ч

сэлгэх бололцоотой, гулир гэж ярьдаг шүү дээ.Нэрийн тухайд ийм байна. Түүнээс гадна эртний Хятадын түүхэн сурвалжуудад Хүннүгийн Модунь Шаньюйг Cheng-li-Li kut, u гэж бичдэг байсан. Тэр нь тэнгэрийн хөвгүүн гэж байгаа юм.

Энэ мэт баримтуудаас үзээд Хүннү нар Тэнгэр гэхийг cenli гэдэг юм байна гэдгийг тогтоосон. Харин cenli нь яагаад Li болов оо гэдэг асуулт гарна.Тэгвэл cenli нь Li болжээ гэдгийг би монгол хэлний баримтаар тогтоож буй юм. Монгол хэлэнд хураагдах, товчлогдох ёс бий. Жишээ нь, үлэг гүрвэл гэж үг байна. Энэ үг монгол хэлний үлү гэдгээс гаралтай. Үлү гэдэг нь аварга том гэсэн утгатай. Тиймээс үлэг гүрвэл, түрэг хэлэнд үлэгбэк гэнэ. Тэгэхээр энэ тохиолдолд ү нь гээгдээд лу болсон гэж үзэх үндэслэлтэй.

Зарим хүн Хятадын лун гэдгээс гаралтай гэж үздэг юм билээ. Тэгж маргах хүн ч цөөнгүй гарах байх?'

Зарим судлаач гэж тайлбарладаг юм. Гэвч тэр худал. Яагаад гэвэл, Хятадын лун гэдэг хэрэг дээрээ лон байгаа юм. Түрүүчийнх нь задгай үе бол Хятадынх битүү үе байгаа биз. "Хоорондоо огт адилгүй. Тэгэхээр үлү гэдэг үг товчлогдоод лу болсон байна. Мөн үсү гэдэг үг байна.

Эртний монгол хэлэнд сүүг үсү гэдэг байсан. Ойрадууд үстэй цай гэж ярьдаг. Ордосууд мөн тэгж ярих жишээтэй. Тэгэхээр үсү гэдэг үг товчлогдоод сүү болсон байна. Иймд cenli гэдэг үг товчлогдож "Li болох бололцоо монгол хэлэн бий гэдгийг баримтаар хөөж үзээд монгол хэлни хууль зүйд нийцэж байна гэж үзсэн.

Ли гэдэг маань явж явж явж юу гэсэн утгатай вэ гэвэл тэнгэр гэсэн утгатай Хүннү гаралтай үг юм байна гэдгийг тогтоосон. Үүнээс үзэхэд Ли орон гэсэн үг юм. Тэр нь агуугаараа ч, хэлбэрээрээ ч нийцэж байна. Ийм учраас монголд шашин ном дэлгэрч байсан, Бурхан багш энд ирж байсан, тэгэхдээ Үхэр ууланд ирж адистэд үзүүлсэн гэдэг нь хадны цууриа шиг юм биш. Өөрөөр хэлбэл, үнэний хувьтай юм байна гэдгийг баримтуудаар хөөж гаргалаа.

**Монголчууд Түвд, Хятадаас өмнө шашны соёлыг авсан.**

Тэгэхээр түүх сударт өгүүлэгддэг Тэнгэрийн орны хаана байгааг, мөн тэнд Бурхан багш ирж, адистэд буюу ном үзүүлсэн болохыг тогтоосно байна. Тухайлбал, түрүүнд өгүүлсэн Хүмүслэн

хад гэдгийн хүмүслэн гэдэг үг энэтхэг гаралтай үг гэдэг. Түүнийг нь би сэжиглэж байгаа учир нь хүмүслэн гэдгийн санскритаар бичсэн хадмал эх ямар нэгэн шалтгаанаар гээгдсэн байж болзошгүй.

Түүнээс биш хүмүслэн гэдэг нь хүмүн ус гэдэг монгол үг. Түүний хажууд тангад, түвдээр мичү гэнэ гэсэн байгаа юм. Тэр нь монгол хэлэнд орчуулбэл, хүмүн ус гэсэн үг л дээ. Эх сурвалжууд ингэж бие биеэ баталж, барьж өгөөд байна. Тэгэхээр Монгол орон Түвдээс бүр өмнө, Хятадаас ч өмнө Энэтхэгээс шашин номыг авсан нь үнэн юм. Мөн энэ холбоо, хэлхээний үзмээр зүйлүүд ч байна.

**Тухайлбал, ямар баримтуудыг сөхөж үзэх ёстой бэ?**

Энд үхрийн тухай яримаар байгаа юм. Жишээ нь, Энэтхэгүүд үхрийг шүтдэг. Хүннүгийн бэлгэ тэмдэг үхэр байдаг.Түүний дараах Тоба улс ч үхэр шүтээнтэй байсан. Тэгээд үхэр уул гэж бий. Энэ бүхэнд ямар нэгэн учир холбогдолтой байна. Тэр байтугай Чингис хаан 1227 оны гал гахай жил Ордос нутагт таалал болсон. Тэнд их хааны найман цагаан өргөөг байгуулсан. Чингисийн сүр сүлд тэнд хоргодсон учир Гилгүдэй баатар шүлэг хайлсан зэрэг түүхэн баримтууд байгаа шүү дээ. Өнөө хүртэл Чингисийн онгон тэнд бий. Тэр бүхэн зүгээр хүний зугааг гаргасан яриа биш, алсын улбаатай, үнэний ул мөртэй баримтууд юм.

Тэгэхээр судалж нягтлах хэрэгтэй. Дээр үед манайхан мэдэхгүй болгоноо байхгүй гэж байсан. Одоо байдал өөр болсон. Өөрийн мэдэхгүй зүйл руу анхаарах хэрэгтэй. Нөгөө талаас шинжлэх ухааны нэвтэрч чадаагүй, одоогоор хараахан хүрч чадаагүй зүйлүүд олон байна.

Тэр болгоныг байхгүй юм уу, боломжгүй байхгүй юм уу, боломжгүй гэх бололцоо байхгүй. Иймд түүхэн сурвалжид хэлээд байгаа зүйлүүдийг эрхбиш анхаарах хэрэгтэй. Судлаачид ч анзаарах учиртай.

Тэгэхээр бид 70, 80 жилийн турш шашин дэлгэрсэн түүхийг ярихдаа Түвдээс оруулж ирсэн гэж ярьж, бичиж ирсэн шүү дээ. Тэгэхээр таны судалгаа тэр үзэл ойлголтыг урагшлуулж байна. Түүх, тэр дотроо шашны түүх, Хүннүгийн судалгаанд нэлээд том ахиц дэвшил гарах нь ээ дээ?

Би нэг л зүйлийг хэлдэг.Бид шашны түүхийг авч үзэхдээ

могойгоор бол зөвхөн сүүлийг нь шувтраад яриад байдаг. Эх бие толгой, хэл амыг нь олж харж чадахгүй, судлахгүй байна. Яах аргагүй шашны дунд дэлгэрэлтийн үе, Хубилай сэцэн хаан, Юань гүрний үед Түвдийн лам нар монголд ирсэн нь үнэн. Сажа Бандид, түүний үеэл Пагва лам Лодойжалцан, тэгээд удаа дараа Сажийн угсааныхан орыг нь залгаж суусан. Тэр үеэс Буддын шашин монголд орж ирсэн мэтээр ойлгож, ярьж бичээд байгаа юм, манайхан. Өмнөх үеэ огт дурсдаггүй. Ярина гэхээр бариад ярьчих юм байхгүй. Баримт алга. Тэгэхээр би цоо шинэ баримт гаргаж өглөө. Энэ санаагаа би хоёр зүйлийн ач холбогдолтой гэж үзэж байна. Шашны түрүү үеийн дэлгэрэлтийн орныг тогтоолоо. Ингэснээр шашны эртний дэлгэрэлтийн бүдэг бадаг үеийг тодруулахад энэ бол шинэ баримт, шинэ хэрэглэгдэхүүн орж ирж байна. Хоёрдугаарт, Хүннү гүрний судлалд шинэ баримт гаргалаа.

Манайхан Хүннү гүрний 2200 жил гээд байдаг, Ноён уулын булшнаас өөр тоймтой зүйл ярьдаггүй. Бид газар доор байгаагаас гадна хөрсөн дээр ил байгаа, өөрсдийнхөө тархи толгойд байгаа өвгөдийн ном сударт байгаа зүйлүүдийг өнгийж харах хэрэгтэй. Үүгээрээ Хүннүгийн судлалд шинэ хуудас нэмж байгаа болов уу гэж бодож байна.

Хэлний чиглэлд ч гэсэн шинэ судалгаа гаргаж ирсэн бололтой?

Бид хэлний мэргэжилтнүүд учраас үгийн гарлын үүднээс судалсан. Хэл зүйн хувьд ийм байх бололцоо байна уу, үгүй юу гэдгийг мэргэжлийн үүднээс зөв тогтоож өгөх хэрэгтэй. Энэ бол бидний хувьд үүрэг юм.

Тиймээс энд учиргүй айхтар тэмээ гэхийг ямаа гэчихсэн юм нь гайгүй болов уу. Нэлээд баримттай тогтоосон гэж бодож байна.

### Хаадын уг эх хэмээх эртний судраас эшлэл

### “Хаадын уг” эх хэмээх судар дахь Ли орны тухай мэдээ

Хадны голын хойш оршихын зүүн хөвөө баруун урагш буюу эргэн оршихын баруун талд хуян мэт оршжээ. Хүмүслэн хэмээнэ. Хүн ус хэмээх нь энэтхэгийн нэр тангууд ч хэмээмой. Хятад хуван хэ сар гол хэмээснийг монгол хүн хуван хэ хэмээснийг хатан хэмээюү, хатан гол хэмээмой. Ли улс хэмээгч эдүгээ Шанши линд болой. Энэ мэт рэнчин шүтээн ойр байхыг мэдсэн сүсэг ерөөн сайдууд хүрч мөргөвөл юутай сонин болно. Бас ч энэ даширмагийн цагаан толгой холбодос хэдэн үг өгүүлсүгэй.

Бурхан багш хүнийг жар наслахад залран ирж номын хүрдийг арван хоёр зүйлээр орчуулан зохиосон энэ шашин нь хүний зуу наснаас жарзн нас хүртэл алд шагжамуны шашин дэлгэрмүй. Далан наснаас жаран нас хүртэл маанийн шашин дэлгэрмүй. Жаран наснаас нь тавин нас хүртэл зарлигийн хураангуйн шашин дэлгэрэх. Энэ шашин нь омог зүгийн шамбалын оронд дэлгэрмой. Лхас их зуу цанид зуу эднийг тэр орноо залмой. Тэр цагт шашин үгүй болмой. Тэр цагт баруун Лид баруун линд газарт нэг зүлгэн уул бүлгээ. Асарын хадны дүрстэй хэмээгч нь одоо лин ту газар дор нэг...

***/”Хаадын уг эх” судар дахь Ли орны тухай мэдээ (B-2)/ 1-р нүүр буюу хуудас***

Самадари ариг болох очирвани бас эрдэнэ тэргүүтэн бодьсадва нар ба далай мэт охин тэнгэр нарын аймгууд эгэл эр эм лам харын дүрс дор барьж цаг үргэлжид шашин орших олон хүний тус жаргаланг бүтээсүгэй хэмээн өчсөн нь бурхан сайн сайн тэр мэт үйлс хэмээн зарлиг болгон соёрхсон энэ үхэр уул нь ордосын долоон хошууны баруун урд этгээд хатан голын хойш оршихын зүүн хөвөө, баруун урд этгээд хатан голын хойш орших зүүн хөвөө , баруун урагш буюу эргэн оршихын баруун тал хониг мэт орших хүмүслэн хэмээсэн нь хүмүн усны суврага хэмээжээ. Хүмүн ус хэмээх энэтхэг нэрийг тангад манж хэмээмой. Хятад улс шарын өнгийн хун ажгуу.Гэтэл монголчууд бид тасарч хатан гол хэмээсэн нь Хурмас хэмээх хатун хэмээсэн үг болгож Хатан гол хэмээн нэрийджээ. Ли улс хэмээсэн нь Шанши Линг тодотгох болой. Энэ мэт хэмээн шүтэзн үхэр байхыг

мэдүүл. Сүсэг зузаан сайд хүн мөргөвөөс юутай сайн, богд Чингис хаан хорин хоёр он сууж тэнгэр болсныг үзтэл түүний хоёр хүү, гутгаар хөвгүүний үед хаан залараад он сууж үүний хүү

***/“Хаадын уг эх” судар дахь Ли орны тухай мэдээ (С-4)/ 5-р нүүр буюу хуудас***

Эдүгээ (өдгөө) Бандид гэгээн бээр дорно зүг залран одоод ойр газар дархан сант хэмээх гүр цагаан чулууны дээр бурханы баруун хоншоорт гишгэсэн дор өлмийд нь оюун буй. Үүний доорх гуурын үгээр сайшааж харвааc зовлонтой амрах нэгэн адистат чуулган буй. Үүнийг үлгэрлэн бодвоос бурхан багш хялбарт анхлан заларсан лав бололтой. Тэрээр буцахдаа шилийн голын чуулганаа ирж ийн үйл дэлгэрүүлж, адисласнаар бандид гэсэн танаа сүсэглэсэн сүмийн шашин, хуврага ихэд дэлгэрч буй болой хэмээсэн нь энэ болмуй гэж санагдмой.

Бурхан багш үхэр уулыг хэргэсүүр хэмээмүй. Гашиба шахай заяны бидний дөрвөн бурхан тэнд адислав. Ирээдүй цагт цусан заналаа ариутган буугаад ирж адиславай хэмээжүхүй. Энэ нутагийн хүмүүслэн хадны суврага нь эртний цагийн суврагыг басч хашив. Бурхны суврага, энэ хоёр суврага нь маш их адисдаттай хэмээн айлджээ. Хиргүй гэрэлтийн орчсон сударт Лахийн орныг нь энэ хэмээх үхэр уулны хүмүүслэн хадны суврагыг манзушир...

***/“Хаадын уг эх” судар дахь Ли орны тухай мэдээ (С-3)/ 4-р нүүр буюу хуудас***

Даруй цуглуулж тэрхүү мөнх ри шидэт уулын арын чуулганд хотол төгс үхэж шавь нар нь шагширч баймой хэмээн дүрс сийлээд өөрийн улсын зүг авч одон зүүн далайн тэртээ явсан ажгуу. Түүний суусан хотын орон нь хялбарын өөр зүгийн зүүн этгээд уулын зүүн хойд ард гол хааны цаг хот хэмжээ их хүрээлэн хормын орон улс байшингийн бууриь хийгээд гадуур урссан гол суваг болвоос бас өмнө этгээдэд мөн хялбар эү тэйгийн зүг хандуулан боссон чуулганд нэгэн гэртээ амьтны зүрх барьсан хүний дүрс сийлсэн ба амар энэ төрлийн этгээдийн босгосон суврага хэмээн нэрийджээ. Янху бусын эрхэмсэг зэргүүд эдүгээ эв илэрхий буй болой. Тэр гүрнийг Манжушир үзэж, равнай айлдаж, хойд цаг дор амьтны тусын тулд буйн их үйлдэх хэмээснээр Манзуширын орон хэмээдэг болой. Үүний хойно Жамъяншадавын гэгээн та ер хурцын газар заларчээ. Та энэ эү тагийн адистидийн цаглашгүй учрыг сайшаана

уу. Шанъяа шинэ дэлгэрчээ. Түүнээс хойш хялбарын цагаан эх тай хэмээн алдаршив.

***/"Хаадын уг эх" судар дахь Ли орны тухай мэдээ (С-2)/ 3-р нүүр буюу хуудас***

Зүлгэн уул бүлгөө. Асрын хадны хөндий гэгч нь ар лин ту хэмээх Манзуширын агуй буй Язгуур олон богд лам нар мянган гэгээн эхлэн буман сайн улаан хадыг настан тонилгогч бодьсад эртний цаад цусаар сорхчигсон газар мөн хэмээжээ. Ванчин ренбүүчиин айлдсан нь бурхан багшийн үүсэгснээр таван өнгийн гэрэл сацарснаас дөрвөн зүйлийн гэрэл нь хэдийн өрнө зүг тусжээ. Нэгэн анги гэрэл нь монгол орноо туссан тэр бээр зүг хялбар хэмээх цөмийг нь эү тэй танаа мөн болмой.Үүнийг санаваашанши эү таи хэмээн энэрэнгүй Бодьсадва сан энэхүү хялбар хэмээх Монгол утай лугаа таван үзүүртэй болжээ. Энэ таван ордын адислан чин нэгэн адил болой эд агуур хуучин авшигийн хэлэлцсэнгүй, өстийн дотор бурхан таван зуун сард сууж уулан дээрсууж маань адистат уулан дээр суужээ. улсын хааныг номхотгохыг айлдаж залран бүхийд хуулийн хаан өөриig эс сүсэглэсэнд буцаж заларсны хойно хуулийн хаан чуулганы

***/"Хаадын уг эх" судар дахь Ли орны тухай мэдээ (С-1)/ 2-р нүүр буюухуудас***

















# ХУТАГТ ҮХЭРТ УУЛАНД АЙЛТГАСАН БУРХАН БАГШИЙН БОШИГ ЛҮНДЭН

/Монгол орчуулга. Гавж доктор Ц.Отгонбаяр/

***Энэтхэгийн хэлбээр арьяа гоши багаа нараа махааяанаа судраа түвдийн хэлбээр лан рэ лүндэнбийн тэгва чинву до шижава шүгсо монголын хэлбээр хутагт үхэрт ууланд айлтгасан бурхан багшийн бошиг лүндэн хэмээх их хөлгөн судар оршвой***

Ялж төгс нөхцөгсөн зөөлөн эгшигт залуу манзуушир бурхан дор мөргөмэй, ийн хэмээн айлтгасан нэгэн цаг доор тэнгэрийн тэнгэр ялж төгс нөхцөгсөн бурхан шагшаа түваа бээр тоолошгүй гурван их галавт буян хураасаны үрээр үр боловсорч үнэхээр туулгасан бурхан болоод замбуулин тивийн орон өөр бүгдийг хураасан хүмүүнийг тийн боловсруулан зохиож ямбаажин хэмээх оронд зүгийг чадагч их дансран аршийн орон бурханы ордонд бодь садваа махасадва хутагт майдар тэргүүтэй олон бодьсадваа цуглараад найдан шаарийбууу хийгээд монголжии буу тэргүүтэй шарбагаа нар мянга хоер зуун тавь хийгээд цамба буюу асар тэнгэр жажин тэргүүт олон тэнгэрүүд цуглараад тэнгэрийн хаан Намсрай буюу бясманий хөвгүүд болон орчлон тэтгэгч нар цуглараад мөн лусийн их хаан цуглараад Ножин буюу ягчисийн их хүчтэнгүүд цуглараад, Диса буюу гандирисийн хаад зүгпүд тэргүүтэй олон нүдэнд үл үзэгдэх нөхөд, хүн хийгээд хаанд зохистой үйлдэх тэргүүтэн цуглараад, Сүгжин нямбуу хаан тэргүүтэй замбуулингийн хүчит хаадууд нэгэн дор цуглarах арга эв нь тохион оршсон болой. Тэгээд тэр цагт тэнгэрийн тэнгэр ялж төгс нөхцөгсөн бурхан шагж түва бээр хойдийн **цагийн буянт орон дор даган таалахийг илт үзүүлэн зохиож цугларсан олон дор зарлиглаваа: Язгуур тануу хөвүүд хойд зүг дор харан зогсоод үхэрт тугалын ойролцоо хатан голын зах дээр чадагч их аршийн ордон суварга гамасалаган хэмээх нэгэн байх бөгөөд тэгүүнд үл шамшаагдах ажил үйлс төгөлдөр нэгэн бөгөөд тэгүүний тулд тэгүүн дээр бурхан шагжаатүва залрах цаг дор буувой.Тэгээд тэр цагт**

**тэнгэрийн тэнгэр ялж төгс нөгцөгсөн бурхан бээр ихэнхдээ огторгуй дор хутаг үзүүлж гандирсийн зүгпүд тэргүүтэй хаан гандирс тоолошгүй нугууд нь өмнө нь тэнгэрийн хөг аялгуу элдвийг үйлдэж хүмүүн хийгээд хаан тэргүүтэнд сэтгэл зохистой бүхнийг үйлдэн тахил өргөх үйлэн дор үйлдээд ялж төгс нөхцөгсөн бурхан эгшиг яруу тэнгэрийн хэлбээр зохистой магтсанд цугларсан тэдгээр нугууд тахил тэргүүтэй сэлтийг өргөж үхэрт уул хаан байгаа тэнд залран саатсан болой. Тэнд залраад тэнгэрийн тэнгэр ялж төгс нөхцөгсөн бурхан болгоон болгоогоод нягуураа хойд зүг дор тогтоон эх нуур далай олон зуун жил оршоод тэгүүнийг их тэнгис дор болгоон соёрхох бөгөөд лагшин эгц хатуу зогсон тэгүүнчилэн эргэсэн дайныг дарагсан үнэхээр тугуулагсан бурхан дияан бясалгалыг олон тоолошгүй мянга түмээр үзүүлэн оршсон бөгөөд гурван их галавт буян хураасан тул өөрийн лагшин ямагт бурханы явдал, ерөөлийн хүчээр буян илт биелэн зохиосон болой. Тэгээд тэр цагт тэнгэрийн тэнгэр ялж төгс нөхцөгсөн тэгүүнчилэн ирэгсэн бурхан шагжаа туваа бээр үхэрт ууланд буянт орны алтан хот мандалаас орчлонгийн үзүүр хүртэл адистэдлэн, равнайлан, үйлдээд сахиад хамгаалаад, өлзий оршоогоод, тусгайлан хил тогтоогоод тарни тогтоол уншин үйлдэж буян дор зохиовой.**

Тэгээд тэр цагт тэнгэрийн тэнгэр ялж төгс нөхцөгсөн тэгүүнчилэн иргэсэн дайнаа дарагсан, бурхан шагжаа туваа бээр нөхөд тэдгээр нугууд бүгд дор зарлиглавай. Үхэрт ууланд ялж төгс нөхцөгсөн бурханы орд харш суварга гамасалаган сэлт нь буянт орны тэмдэг ануу. Сайн цагийн мянганы бурхан бүгдийн чаганцан буюу мутрын тэмдэг хийгээд үл холигдох онцгой, нийтийн бус аглагийн ороны мөн чанар уг шалтгаан бүрдсэн буянт орон хэмээмой. Тэгээд тэр цагт тэнгэрийн тэнгэр ялж төгс нөгцөгсөн тэгүүнчилэн ирэгсэн дайнаа дарагсан үнэхээр тугуулсан бурхан шагжаа туваа бээр буянт орон хийгээд огторгуйн бясалгал хийгээд хуварга тус тусийн Гунгаараваа болон орд зүглэгхан хийд орон лугаа тус тусад нь буяны үйл ажил бодитой үйлдэн байх хаан хийгээд ном лугаа төгөлдөр сүсэгтэн өглөгийн эзэн бол лиюүл бүгд хэмээн бошго үзүүлсэн болой.Тэгээд ялж төгс нөхцөгсөн бурхан бээр бодьсадва нугуудад зарлигламой. Язгуур тануу хөвгүүд та нугууд бээр ч ирээдүйн цаг дор энэхүү оронд юу үйлдсэнч хамаг амьтан нугууд их дээдсийн улбааг түргэн

олох бөгөөд Дияан бясалгал түргэн бүтэхүй дор адисла. Тэгээд тэр цагт ялж төгс нөхцөгсөн тэгүүнчилэн иргэсэн бурхан шагжаа туваа бээр цэролнай буюу навчан цэнгээн хэмээх бясалгалаасаа өчүүхэн нэг буцах төдий тэр даруйдаа үхэрт хад уулан дээр бэлтгэсэн дэвсгэр арслант ширээнд заларч очир завилгаагаар оршвой. Тэгээд нягуураа хойд зүг дор тогтоон ялж төгс нөгцөгсөн бурханы ордон суварга гамасалаган хаа байгаа газар нь морилон очиж болгоовой. Тэгээд тэр цагт орчлонгийн бусад орон бүгд дээдсээс бодисадваа нити болон таван мэдрэхүйг илт эзэмшсэн их арш нугууд нэгэн арган дор цугларан ялж төгс нөгцөгсөн Бурхан хаа байгаа дор очин цугламой. Цугларaaд ялж төгс нөхцөгсөн бурханы ордон суварга гамасалаган дор дахин мөргөөд аврал одуулаад ялж төгс нөхцөгсөн бурхан нөхөр сэлт дор мөргөн аврал одуулсанаар нэгэн зүг дор чиглэвэй. Тэгээд тэр цагт ялж төгс нөгцөгсөн бурханы нөхөр ихэнхийг хураан болгоосноор нөхөр тэдгээр нугууд дор ийн хэмээн зарлигласан болой. Сайн галав дор урьд ялж төгс нөхцөгсөн бурхан дөрөв гарсан бөгөөд тэдгээр ч гэсэн бас суварга гамасалаган байх оронд адистэдлэн жанлавласан болой. Сайн галав энэ дор ирээдүй цагийг хураагаад мянган бурханы нэгэн үзүүрт сэтгэлээр энд болох болюу. Тэдгээр бүгд ч нөхөр лугаа сэлт энд залран соёрхоод суварга гамасалаган орон лугаа бүгдийг адистэдлэн жанлавлаж тусад нь хил тогтоон өлзий оршоож буян дор зохиох болой. Би чүү энэ мэт адис тэд жанлавийн цаг дор буун адистэдлэн зохиовой. Тэгээд тэр цагт тэнгэрийн тэнгэр ялж төгс нөхцөгсөн бурхан дияан бясалгалын адилаар илт тугуулгасан бурхан заларахуй хэмээгээд бас чүү тэгүүнчилэн иргэсэн дайныг дарсан үнэхээр тугуулсан бурхан тоолошгүй хэмээх дияан бясалгалд тэгш оршвой. Тэр цагт дияан бясалгалд тэгш оршихуй хийгээд самади бясалгал нугуудыг ч огоот тэтгэн үйлдэхүй дор бодисадва хүч ихтэн бээрч бурхан Одсүрэнгийн суваргын өмнө залрахуй бөгөөд энэ орон дор залрахийн цагт бие дүрс сайтар дор болгохуй хөрс шороог адистэдэлмой жанлавалмой. Тэгүүнчилэн их ерөөлийн хүчээр энэхүү оронд бодисадваа хутагт Манзушир орь залуу хүч бээрээч үхэрт хад уулан дор орд харш нуун үйлдэх хэмээхүй дор болох болюу. Хөрс шороо тэдгээр нугууд ямагт сайн болгохуй дор адистэдлэмой.

Тэгүүнчилэн огторгуй адил хүч хэмжээлшгүй бодисадваа Намхай-Нямбуу буюу огторгуйн зүрхэн хэмээгчич гэсэн орд харшийг аюулийн чуулганаас хамгаалан үлдэж байх хэмээхүй болоод хөрс шороо орчин тэдгээрийг тахилын орон дор урвуулан адистэдэлсэн болой. Тэгүүнчилэн их нигүүлсэнгүйн таалал лугаа төгөлдөр бодисадваа хутагт Арьяабал Жанрайнсэг бурханч адисласан. Орд харш гэгээн гэрэлт хэмээх нэгэн болоод орчин хөрс шороо эгүүн дор илт бүтээл дор жанлавламой. Тэгүүнчилэн мөнхийн асрал лугаа төгөлдөр бодисадваа Жанба буюу ирээдүйн Майдар бурханч орд харш Бисононя хэмээх хүй дор орчин нугуудыг би ямагт илт бүтээл бүтээхүй дор адистэдламой. Тэгүүнчилэн явдал машид ариун бодисадваа Саяын-Нямбуу буюу газрын зүрхэн хэмээх чүү орд харш Иширэ хэмээх бологсон орчин газар дор мөргөлийн зохилдлоготой орон болохуй дор адистэдлэмой. Тэгүүнчилэн Дүлбаа буюу Винайн ёсыг баригч төрөлхтөн нугуудыг гэтэлгэн зохиох эхэн болон эрхшээсэн бодисадваа эмийн хаан буюу манбийн жалба ч гэсэн орд харш Нозо хэмээх болсон дор газар орныг илт бүтээл дор бүтээн адистэдламой. Тэгүүнчилэн ирт хувилгаан их лугаа төгөлдөр бодисадваа Гүндүүсамбуу ч гэсэн орд харш хуварга нугуудыг тэтгэн үйлдэхүй дор болж тэдгээр орчин нугуудыг илт бүтээхүйн бүтээл дор адистэдлэмой. Тэгүүнчилэн ялж төгс нөхцөгсөн бурхан тэргүүтэй бодисадваа бусад нугууд ч гэсэн Даажинбаа Архад нугууд ч Ли орон хаана байгаад орд харш хийгээд Даажинбаа их Архад нугууд бээрч Ли орон хаана байгаа орд харш хийгээд ой цэцэрлэг болон хийдийн орон дор болгоод зүг бүгдээс үлгэрлэвэл арван тавны саран мэт огторгуйн оддын чуулган огоот хүрээлсэн түүний завсараар гэрэл гэгээ түгэх үзэсгэлэнтэй сэтгэл зохистой бүгд дэлгэрээд баясал дор болохыг адистэдлэмой. Бас тэр цагт үхэр хадат ууланд ялж төгс нөхцөгсөн тэгүүнчилэн иргэсэн дайнаа дарагсан үнэхээр тугуулсан бурхан залраад бодьсадваа их баатар сэтгэлтэн нугууд их Архад нугууд бээр элдэв гэрэл туяан байдалтай олон бээр Ли орон бүгдийг гэгээн гэрэл ихээр түгээх болой. Тэгээд эгшин зуур ямагтад их далайн дотроос Лянх цэцэг гурван зуун тавин гурав хувирах болюу. Лянхуа цэцэг нижгээдийн дээр чүү бурхан хийгээд бодисадваа нугуудын дүрс гэрлтэн харагдах болой. Тэгээд тэр цагт тэнгэр нугууд бээр хөх үл харагдах тэмдэгтэй тэр мэт үзэгдэх болоод ялж төгс нөхцөгсөн бурхан дор айлтгаад, ялж төгс нөхцөгсөн бурхан зарлигламой. Язгуур тануу

хөвүүд далайн дотроос гурван зуун тавин гурван бадам цэцэг бурхад хийгээд бодисадваа нарын лагшин лугаа төгөлдөр сэлт гарсанануу ирээдүйн цаг дор энэхүү орон ямагтад бадам цэцэг тэдгээрийн тоогоор орон хийд болон орд харш "Бурханы шашинд хэрэглэгддэг асар ариун мод " гандийн дуугаар дэлгэрэх хийгээд орон хийд хаана очсон ч бодисадваа махасадваа нугууд их баридагаа нугууд элдэв гэрэлэн байдалтай оршиж орон нутгийг адистэдлэн жанлавлаж орон тэдгээр нугууд ялж төгс нөхцөгсөн бурханы ордон суварга гамасалаган буянт орны сэлт лугаа төгөлдөр адистэдлэхийн уг дор сүсэгтэн өглөгийн эзэд нугууд бээр ч тус тусдаа бурхан тэргүүтний дүр ямагтыг хүндэлэн орон тэдгээр нугууд юу зохилдох шалтгаан бүрдэнэ хэмээн урдаас бошгилсон болой. Бас тэр цагт тэнгэр нугууд залран босож ялж төгс нөхцөгсөн бурхан дор ийн хэмээн айлтгасан болой. Хуварга тойн Бурхаан орон игүүн дор ямар мэт болох болюу хэн бээр өглөгийн эзэн болох болюу. Хуварга тойн бурхаан энэ адил их хийдийн орлогч Гуу Сан хэн бээр ямар мэт өглөгийн эзэн дор соёрхох бол хэмээвээс

Ялж төгс нөхцөгсөн тэгүүнчилэн эргэсэн дайнаа дарагсан үнэхээр тугуулсан Бурхан ийн хэмээн зарлиглаваа: Язгуур тануу хөвүүд сонсохтун Би гаслангаас хагацаад "Бурхан мөнх бус дүр үзүүлээд " зуун жил болохын цагт хятад орноос энэтхэгийн хаан Заяаан хэмээхийн хөвүүн мянган тэмдэгт догваа хэмээх хөвүүд нэгэн гарах бөгөөд хөвүүд тус бүр ч орон тэдгээрийг шинээр байгуулах болой, дараа нь хойд зүгээс үхэрт хад ууланд ялж төгс нөхцөгсөн бурханы орд суварга гамасалаган байхын орон тэгүүнчилэн иргэсэн бурхад олон удаа адистэдлэн жанлавласан нэг байхыг харах болно. Энэ ямагт нэгэн хүүтэй эх дор хүүгээ энэрэх мэт ихэнх бурхад адистэд жанлаваа энэхүү орон дор талбиж үйлдэхийг санаад тэр цагт энэтхэгийн хаан Намтойжийн буу буюу Намсрай бясман тэнгэрийн хөвүүн нэг бээр босож үйлдэх болой. Бясман тэнгэрийн хөвүүн ч замбуулингийн энэ Нянанмэд буюу гаслангаас хагацагч хаан хэмээхийн хүү болон төрөх бөгөөд хүү бээр царайлаг сайхан гоо төгөлдөр харахаас үзэмжит нэгэн болой. Хүү бээр тус ихтэй газарын үйл дор хүчтэй нэгэн бөгөөд урьдын буян заяаны ёзоороор эрхшээсэн эгэлийн бус тул хүү түүний нэрийг Саалайнуману хэмээх нэгэн болой. Хүү тэрбээр түргэн өсөж аавын хаант төрийн ханхүү болон эрх мэдлийг нь авсан бөгөөд эд олонтой

өглөгч түшмэл нугуудын ихэнх нь үнэнч шударгуу дор хувиарлаад хаан саалайнуману хэмээхийн их түшмэл Заншой хэмээх тэргүүт олон цэрэг лугаа хамт хятадын оронд эгүүн дор ирсэн болой. Ирээд тэр оронд залбирч талбисан болой. Хаан Саалайнуману тэр ороныг талбихийн тухайд учир шалтгаан нь түүний нэр газрын үйлэнд хүчит хэмээх учир энэ болой. Цаг тэр үед хойд зүгээс энэтхэгийн олон хүмүүс ирсэн болой. Хаан Саалайнуману зүлэг модыг ургуулж цэцэрлэг, гол горхийг арвитган үйлдэж түшмэл Заншой тэргүүтэн ээлж дараалан хот тосгон балгадыг бүтээн байгуулсан болой. Тэр мэт хаан Саалайнуману бээр олон арван жил хаан ширээнд заларч суусан болмой. Хаан тэдгээр нугууд ч ээлж дараалан тус тусын орон дор хийд орон хийгээд орд харш байгуулж зүлэг ногоо цэцэрлэгийг ихээр бүтээсэн. Дахин дахин би ямагт бээр Тойн хуварга болж үлдэмой. Зарим нь язгуур тануу охид хөвгүүд машид өглөг өгч үйлдэмой. Зарим нь цэцэрлэг тоолошгүй олоныг байгуулж Тойн хуваргыг шүтэж үйлдмой. Орон нэгүүн дор бодисадвийн язгуур олон болж үйлдмой. Үргэлжид чухаг дэгээд гурваас буяны язгуур тэргүүтэн хийгээд буяны үйлийг арвидуулж үйлдвой. Тэр мэт орон нигүүн дор хаан Саалайнуману дор орон олон ээц өргөл хүндлэл их үйлдвой. Орон эгүү дор бурхан нижгээд нижгээд гарахын цагт дэлгэрүүлэх болой. Үүний тулд орон бусад хийгээд орон бусдын хүмүүн урт хугацаанд магтаж хийд сүмийг байгуулсан буянануу бурхан мэндэлээд нижгээд тэр цагт хүмүүн нугууд бээр ч чимэг үзэсгэлэнтэй болох болюу. Энэ мэт орон эгүүнд чадагч их арашийн ороноос тэгүүнчилэн иргэсэн бурханы явдал орон суварга гамасалаган хэмээх үхэрт уул түүний ойр хатан голын захад байна хэмээсэн болой. Суварга энэ нь судрын аймгийн дотроос ануу нэр гомоосаалаган хэмээх ертөнцийн ихэнхийн нэр томёонд нь хатан голын зах хэмээн номлосон бөгөөд энэ ямагт хорвоо дуусахын цаг хүртэл суварга хатан голын захад оршино хэмээгээд Одсүрэн бурхан бээр ч суварга энэ хоёрыг дэлгэрүүлэн тахилын орон болгон орчлонг хэзээ дуусахыг хүртэл буянт орон болгон зохиох болюу. Тийн суварга энэ хоёр нь доройтохын цагт орон тэдгээр нугууд доройтон хоосрох болой. Тэгээд тэр цагт нөхөд бүгд тэнд цуглаж тэнгэр нугууд бээр ялж төгс нөхцөгсөн тэгүүнчилэн ирэгсэн бурхан бээр зарлиг хайрлахын айлтгалыг сонсоод суварга гамасалаган хийгээд үхэрт ууланд сүсэгтэн бишрэлтэн их бээр олдох бөгөөд ялж төгс нөхцөгсөн бурхан дор тэргүүн бээрээ мөргөн авралыг

одуулаад мэлмийн өмнө ийн хэлбээр бид нугууд ч цаг энэ үесэд энэ оронд өндөр язгуурыг олон төрөөд тэгүүнчилэн эргэсэн бурханы шашныг хамгаалах хийгээд орон дор номын зарлигийн санваарын зүйлийг доройтуулалгүй үйлдэх болой хэмээн ерөөл талбина. Тэгээд тэр цагт ялж төгс нөхцөгсөн бурхан бээр тэнгэрийн хаан бясманы хөвүүн бодисадваа, махасадваа, хуран мэдэл хэмээх нэгэн хийгээд тэнгэр хүмүүн эгэл нугууд хийгээд лусын хаан чимжиг хэмээх хийгээд тэнгэр огторгуйн ян хэмээх хийгээд тэнгэрийн алтан эрхтэн хэмээх хийгээд охин тэнгэр гохтон хэмээх хийгээд охин тэнгэр найжин хэмээх нугууд дор ийн хэмээн зарлиг хайрлаваа. Язгууртануу хөвүүн нугууд дор суварга гамасалаган хийгээд үхэрт уул лугаа сэлт нугууд миний шашин хийгээд шавь нугууд огоот тэтгэлэгээр огоот хамгаалалаар аварах хийгээд тэтгэх тахилын орон болгож үйлдээ. Орон эдгээрийн хаан хийгээд орныг баригч түшмэл өглөгийн эзэн номод зохилдох огоот тэтгэлэг бээр тэгүүнчилэн үйлдтүгэй. Үхэр хадат уулан дор бушга үзүүлсэн судар энэ нь ч огоот тэтгэж арвидуулахуй дор зохио. Алим бээр тэр цагт орон эдгээрийг тэгж үйлдээ. Далайн цаадах дайсныг бээр ч хооcлон үйлдмой. Судар эдгээрийг унших хийгээд өдрийн уншлага болгон үйлдэх хийгээд тахил үйлдэх хийгээд бясалгаж үйлдвээс орон тэдгээрийн хорлол амирлаж үйлдэх болой. Ирээдүйн цагт хамаг амьтаны үйл тийн боловсрохын тулд орон энэ дор гурвантаа түвд нугууд ирэхийн тул тэр цагт судар энийг арвидуулан зохиож судар энийг сонсовоос судар үүний хүч тэнгэр нугуудыг адис бээр сүжиг үгүй нугууд орноос айн зайлж сэтгэл нь гэмшин үйлдэх болой. Ирээдүйн цагт энэ оронд хятадууд нугууд ирэхийн тул тэр цагт судар нугуудыг энэ мэт боргилуулан арвилуулан зохио. Судар эдгэээрийг сонсосноор тэдгээр нугуудад сүжиг төрмой. Сүжгийн хүчээр орны аюул зайлан хамгаалахын хийгээд буяны үйл илт үйлдэх болой. Тэр шалтгаан судар ану оронд туслахыг өнгөлөн үйлдэх нэгэн болой. Судар эгүүнийг тус эрдэнэ бусад оронд ч олон болой. Бага хугацаанд ч уншваас хүчгүй болой. Тэгүүний тухайд судар эгүүнийг та нугууд огоот зохион үйлдмой. Тэгээд тэр цагт бясман тэнгэрийн хөвүүн тэргүүтэн тэнгэр нугууд лусын хаан хийгээд охин тэнгэр тэдгээр бүгд нөхөр сэлт бүгд босоод ялж төгс нөхцөгсөн бурханы өмнө өвдөгөө нуглан газарт сөхрөөд өмнө нь наминчилан ийн хэмээн айлгамой. Тойн хуварга ялж төгс нөхцөгсөн бурхан та бээр ялж төгс нөхцөгсөн бурханы зарлигийг орой бээрээ

угтан мөргөх болой Дахин соёрхмой. Үзүүлэгч багш ялж төгс нөхцөгсөн бурхан бээр ийн хэмээн зарлигласинчилан суварга гамасалаган хийгээд үхэрт уулийн орон сэлт бүгдэд огоот сахин мөргөмой. Тэгүүнчилэн ирэгсэн бурханы шашин хийгээд бурханы шашны ном лугаа зохилдох хаад хийгээд тойн хуварга хийгээд ном лугаа зохилдох орныг баригч эзэд хийгээд ном лугаа зохилдохөглөгийн эзэд нугууд алин бээр буяны үйлэнд илт үйлдэх хийгээд тэдгээр нугууд ч илт хамгаалах ануу мөргөл. Ялж төгс нөхцөгсөн бурхан ертөнц төгстөл орон игүүн дор чухаг дэгээд гурвыг тахих орон болгох хийгээд орон баригч нугууд ч ном лугаа зохилдуулан орныг тэтгэх хийгээд ном лугаа үл зохилдох амьтан нугуудыг авралдаа үл багтаах ба би бээр чүү огоот хамгаалах хэнгэрэгийг цохих бөгөөдсудар эгүүнийг ли оронд өнөд оршоохын тухайд Ли орны Няног-Ту-Жүрвийн-Жалбуу буюу нарны доогуурхи эзэн хаан хэмээн орчуулагдах хаан хийгээд түшмэл нугууд дор судрыг үүнийг ануу: Ялж төгс нөхцөгсөн бурхан бээр Ли орны тухайд үхэрт хад ууланд номлосон болой хэмээн нэмэн алдаршсан, тулгуурыг нь олох болтугай. Сэтгэл нь өөрчилөгдөж үйлдэх болой. Ялж төгс нөхцөгсөн бурхан тэнгэрийн энэ орон дор чухаг дэгээд гуравыг тахилын оронд үл үйлдэх хийгээд ном лугаа үл зохилдох нугууд олширохын цагт би бээр сэвжид хийгээд хүч бээр дарж үйлднээ. Орон эгүүн дор хувь бүгдийг нь тэнцүү хамгаалж үйлдэнэ. Тэр юуны тухай хэмээвээс би бээр хүч лугаа төгөлдөр сүр жавхлан ануу тэгүүнчилэн ирэгсэн бурханы шашин хийгээд ном луугаа төгөлдөр зохилдох бүгдийг сахин хамгаалаад буяны алив үйлэнд бодитойгоор язгуур бүгдийг арвидуулан үйлдэх болно. Тэгээд тэр цагт ялж төгс нөхцөгсөн бурхан сэнтийнээсээ босож үхэрт хад уулын дээд захад залраад суварга гамасалаган хаана байгаа тэр зүгт болгоогоод адислаад Ли орон бүгд хийгээд далайн дотор орших тоолшгүй амьтан нугуудад гэрэл цацарч их тааллаар түгэн зохиох бөгөөд гэрэл тэдгээр нь таалал энэрлийн ихээр уснаа орших амьтан тэдгээр бүгдийн зовлон амирлах болно. Алагчаалан барих хийгээд хонзогнон дайсагнах лугаа хагацах бөгөөд асралын сэтгэл лугаа төгөлдөр болоод тэнгэрийн амгалан лугаа төгс ээцээс эгшин тэр ямагтад амьтан бүгд тоолшгүй үйлээс хагацаж тэнгэр хүмүүний төрөл авах бөгөөд бурхан ямагт болохын хөрөнгийг эрхшээж бодийн үйлийн тухайд буцалтгүй шулуудмой. Тэгээд тэр цагт ялж төгс нөхцөгсөн бурхан бээр тэнгэр нугууд дор гурвантай хүрч

дуудаад ийн хэмээн зарлигласан болой. Язгуур тануу хөвгүүд та нарын тангараглассн ануу: чин хатуу хичээлээр зүтгэлээр бүтмой. Язгуур тануу хөвгүүд бие бээр тоолшгүй гурван их галавт хатуу явдалыг үзүүлсэн хийгээд суварга гамасалаган орон лугаа сэлтийг та нугууд дор огоот даатгаж байна огоот хамгаалагтун. Та нугууд үйл алин бээр даган санаж барьж байх хийгээд шашин сахих хамгаалах тэр ануу шашин дор тойн хуварга нугуудыг огоот хамгаалж үйлд. Тэр юуны тулд хэмээвээс хүний амьдралын нэгэн хэсэг зуун жил дор өдөр алгасалгүй буяны үндэс тасралгүй үйлдэхүй дор зарим нэгэн бээр тойн хуварга болж шашнаа өнөд оршоох хийгээд урд хойчийн буяны үрийг олонтой хурчилан буулга. тэр юуны тухай хэмээвээс ялж төгс нөхцөгсөн бурхан ганга мөрний элсний тоотой адил урд гэргийтний орныг дэвчиж тойн хуваргын үйлэн дор тэдий ямагт болж их бодийг олсон болой. Би чүү зургаан бармидийг огоот төгсгөөд арван хоёрдох газрыг олсоноор орчлонгийн эцэсийн цагт очиж таслаад хааны ордон харшид төрөөд залуу хаан болж хаан аавын оронд сууж өлзий оршоогоод өөрийн үсийг тонгоргоор авч миний хувцас хэрэглэл үнэ үгүйг эдлэн гөрөөчин мэт суун ил шарын дуваазийг эрхшээсэн болой. Би бээр номын хувцас өмсөж гурван цагийн бурхан бүгд дор мөргөн аврал одуулаад Тойн хуваргын зам мөрийг барьсанд тэнгэр нугууд над доор авралыг одуулаад хойшчилон болсон болой. Би чүү явдал зам тэр ямагтыг бээр үнэхээр сахин тугуулгасан бурхан болсон билээ. Түүний тухайд ялж төгс нөхцөгсөн бурханы шашин ануу үнэн дээд дор мэдээд Тойн хуварга болох ануу буян лугаа төгөлдөр болохыг мэдэж үйлдээ. Орчлон гэргийтнээс их газыг олох хүртэл гэргийтний ажил явдал бээр их Архад хийгээд ханцашгүй үгүй бодийг олох нь хэн ч болж болох асуудал болой. Тойн хуваргын явдал зам нь ертөнцийн дээр тэнгэр тэргүүтэн бүгдийн тахилын орон болой.

Тэгээд тэр цагт тэнгэр хийгээд охин тэнгэр бүгд суудалаасаа босож нэгэн яруу аялгуу ямагт бээр ялж төгс нөхцөгсөн бурханд ийн хэмээн айлтгамой.Тойн хуварга ялж төгс нөхцөгсөн бурхад нугууд бээр бурханы ямар мэт зарлиг хайрласанд мөргөн хүндлэх бөгөөд сэтгэлчилэн үйлдэх ануу. Зарлигаас хэтийдсэн харшилсан нь үгүй болой. Орон энэ дор бурханы шашин хийгээд тэгүүнчилэн ирэгсэн бурханы явдалын орон суварга лугаа сэлт чүү бүгдийг

хамгаалах хийгээд тэтгэх даган барин мөргөхүйгээр ялж төгс нөхцөгсөн бурхан ч бид нугууд дор даатган соёрхвоо. Тэр юуны тулд хэмээвээс : ирээдүйн тэмцэлийн цагт адистэд жанлавийн орон эгүүн дор дайсан олон хийгээд сүсэггүй нугууд буруу тэрсүүд үзэлт нар тэгүүнчилэн заларсан бурханы шашин дор сүжгийн ялгамжааг олохгүй хийгээд бурханы шашин доройтохын цагт ариун хичээл зүтгэлээр шамдахыг хэлмой. Тэгээд тэр цагт ялж төгс нөхцөгсөн бурхан бээр тэнгэр нугууд дор сайн сайн хэмээн таалах бөгөөд дээд төрөлхтөн нугууд сайн сайн болой. Би ч орон эгүүн дор адис тэдэлсэн бөлгөө. Адис тэдлэл тэр ямагт бээр хаалт тавьсан бус болой. Ирээдүйн тэмцэлийн цаг дор орон эгүүнийг доройтохийн тухайд гурвантаа цэрэглэн эзлэх бөгөөд дүгүүрүү хэмээх элдэв хийгээд хор буюу монголчууд хийгээд бусад сүжиг үгүй нугууд ирэх болой. Тэр цагт орон бусад хийгээд бусад нугуудаас тэгүүнчилэн ирэгсэн бурханы хөрөг адис жанлуу нугууд энэ орон дор залраад орныг хамгаалан үйлдэхүй дор зохиох бөгөөд буяны их хүчээр орон эгүүний лаг шавараас арилгах болой. Бурханы хөрөг лагшин тэдгээрийн хойно хойшдоо бодисадваа хийгээд тэнгэр хүчит лус лугаа төгөлдөр олон бээр ирэх ба орны хорлол нугуудыг буцаан үйлдэж дайсан нугуудыг орноосоо хөөх болой дарах болой. Амгалантан хэмээхийн огторгуйгаас тэгүүнчилэн ирэгсэн бурханы амгалан гаран хэмээн бурханы хөрөг заларна. Хойд зүгийн огторгуйгаас гошид дуу хэмээх залрах бөгөөд орны хил бүгдийг хамгаалах болой. Хойд зүг дор Шанший орноос ялж төгс нөхцөгсөн бурханы хөрөг Шанший хэмээх газрын дороос гарах нэгэн болоод орны хил бүгдийг хамгаалахуй болой. Тэгүүнчилэн эргэсэн бурханы хөрөг гайлин хэмээх залрах ба тэр нь урд зүгээс жимаа буюу элс гэх орноос огторгуйд залрах хийгээд хил бүгдийг хамгаалах болой. Тэгүүнчилэн ирэгсэн бурханы хөрөг чиса хэмээх залрах ба тэр нь хойд зүгийн үхэрт уулан дор Одсүрэн бурханы суваргын өмнө орших хийгээд аяга тахимлаг гэлэн нугуудын хийд буяны үндэсийг үйлдэх хийгээд тэгүүнчилэн ирэгсэн бурханы шашны орны завсар бүгдийг сахин үйлдэх болой. Огторгуйд гиваажин буюу буянтан болон үйлдэхийн дотор наймааны цаг Гаадийсаа хэмээх хүртэл ялж төгс нөхцөгсөн бурханы хөрөг хааны ордон орон хэмээх нэгэн дор орших хийгээд огторгуйд буяны орон лугаа сэлт хил хязгаар бүгдийг сахих болой. Хөрст газар Нямоня хэмээхийн үед хаан Ёла хэмээх огторгуйд давхарлдсан бүжиг бүжин үйлдэхүй дээр ялж

төгс нөхцөгсөн бурханы хөрөг жуугар бан хэмээх орших хийгээд огторгуйд диваажин хэмээх орон лугаа сэлт орны завсар бүгдийг сахин үйлдмой. Орд харш дизаяа хэмээх хүртэл ялж төгс нөхцөгсөн бурхан Мармэзадын хөрөг торхонтойгоо залрах бөгөөд хөрөг тэрануу замбуулингийн анхны залрах бүгдийн эхлэл нь болох болой. Хөрөг Ли нугууд ануу тэмдэг тойрон зул өргөж үйлэн дор ормой. Тэгээд Ли орны хөрөг тэдгээр нугуудыг бүгдэд үлгэр болон үзэгдэх болой. Тэгүүнчилэн ирэгсэн бурханы шашин лугаа сэлт орон нугуудад огоот хамгаалагдах болой.

Бас чүү тэгүүнчтлэн ирэгсэн бурхан Ринчинмангийн хөрөг энэ орны төвд залрах бөгөөд арван зүгийг хамгаалан зохиомой. Ертөнц хоосрох хүртэл тэгүүнчилэн ирэгсэн бурханы хөрөг зүг зүгт оршоод тэдгээр нугууд тахилын орон дор үйлдэж орчлонг хэззэ дуусах хүртэл үл хөдлөмой. Орон эдгээрээс төрөлхтөн хүмүүн хийгээд орон бусад төрөлхтөн аль аль нь тэгүүнчилэн ирэгсэн бурханы хөрөг нугууд дор зүрхэнээсээ сүжиглэн биширч үйлдээд энэ ямагт бээр ялж төгс нөхцөгсөн бурханы хөрөг тэдгээр ануу орон эдгээрийг сахин үйлдэхийн тухайд оршин хэмээн сана. Хөрөг тэдгээр нугууд ч бурхан оршсончилон тусыг бүтээх болой. Тэр юуны тулд хэмээвээс хөрөг тэдгээр нугууд би хийгээд гурван цаг дор хамаарагдах бурхан бүгдийн адис тэдийн тухайд болой. Бас чүү орон энэ дор миний хөрөг их тэрэгтэн лугаа адил тэтгэж үйлдэх багөөд огторгуйн диваажин хэмээхийн дотор оршоод тахилын орон дор үйлдэх болюу.Тэгээд орон эгүүн дор зүг хийгээд зүгийн завсар бүгдээс их наймаачид ирэх бөгөөд хорлож үйлдсэн нугууд ч амгалантай болох болой. Бас чүү орон эгүүн дор тэгүүнчилэн ирэгсэн бурханы хөрөг хоёр зуун найм Одсүрэн бурханы суварга сэлт лугаа төгөлдөр болох бөгөөд тэдгээр нугууд ч их эрт хувилгааныг үзүүлж амьтан нугуудын их хилэнцээс огоот арилгаж хорлолыг ариутгахуй дор зохионо. Орон эгүүн дор хорлол хийгээд аюул, аймшиг аль нэг нь гарах аваас орон эгүүний тухайд таван зүг дор найруулан үйлдэх бөгөөд хаан хийгээд түшмэл орныг баригч нугууд алин нэгэн суурь ээцээс хагцаалгүй амгаланд орших бурханы шашнаас буяныг егүүсгэхийг хүсэх болно. Орд харш цармаа хэмээүй хүртэл буян үйлдээ. Тэр юуны тухай хэмээвээс орон егүүний хүн нугууд бээр сүсэг хийгээд үнэхээрийн үзэл ануу эхлээд орд харшийг үүсгэж үйлдэх болой. Зарим нь хаан хийгээд түшмэл нугууд орон хийдийг

захириагч нугууд дор хорлол элдэв байдалтай нэгэн гарваас үхэрт хад ууланд урд үнэхээр тугуулгасан бурхан оршоод залраад суурь түгүүн дор эргэж мөргөж үйлдмой. Орон эгүүний амьтан нугуудаас нүгэлд дурлаж үйлдвээс суварга гамасалаганы өмнө ирж номончилж үйлдмой. Тэр юуны тулд хэмээвээс суварга тэр ануу. Бурхан залрах тэрчилэн тэдгээрийг эргэж тойрох хийгээд цэцэг өргөх хүж уугуулах хөгжим эгшиглүүлэх тахил үйлдвээс завсаргүй таван нүгэл үйдсэн ч тэр нь дарагдан үйлдэх болно. Бусдыг нь хэлээд яах билээ Орон эгүүний хаан хийгээд түшмэл нугууд орны захирагч хэн нэг нь номхон дөлгөөн сахил сахихыг хүсэхүй үхэрт хад ууланд хаана байгааг эрэн олж ялж төгс нөхцөгсөн бурханы хөрөг чийсаа хэмээх хийгээд Одсүрэн бурханы суварга байгаа тэр газарт хуваргууд дор хорлол бүү үйлдээ. тэр юуны тухайд хэмээвээс орон эгүүн дор номын явдал огоот төгссөн хийгээд шагшаабадь сахил санваарь огоот ариун болох нэг нь болюу. Орон эгүүний хүмүүн зарим нь тасрахуй дор хүрвээс тэр үхэрт ууланд орших хутагт хувэрагуудад аврал одуулж үйлдэх бөгөөд тэгвээс тасрахуйгаасаа гэтэлж нярвааныг олох болно. Тэр юуны тусад хэмээвээс орон тэр ануу нярвааныг олох олон мянган хойчийн эцэст орших нугуудад хэрэгтэйн тусад болой. Уг эгүүнээр үхэрт хад ууланд суварга гамасалаган орон хийгээд сэлт тэгүүнчилэн ирэгсэн бурхан нугуудын гох дэгээнд татагдах болой. Тэгээд тэр цагт арван зүгийн бурханы орон ариусаад бодьсадваа олон түмээр цуглаж ялж төгс нөхцөгсөн бурхан хаа байгаа газар очиж өвдөг сөгдөн наманчлах бөгөөд яруу эгшиг нэгэн бээр ийн хэмээн айлтгамой. Ялж төгс нөхцөгсөн тэгүүнчилэн ирэгсэн урхан нугууд бээрч элдэв арга бээр Бурханы явдалын орон хийгээд орон эгүүнийг ариусгаж үйлдээд хамгаалж үйлдээд орчлон хэзээ үгүй болтол их амгалангаар залрах бурханы шашин хийгээд чухаг дэгээд гурвын бишрэлийн орон хийгээд хаан хийгээд түшмэл тэргүүтэн хүмүүний шагшаа бадий лугаа төгөлдөр сүжигтэй орон тэдгээрийн ном лугаа зохилдсон үйлтэй тэдгээр нь үнэ удаан хугацаанд орших хийгээд орон эгүүн дор цаг цагт явдал зам ёс заншил юу үйлдсэн ч хамаг амьтаны буян ихээр дэлгэрч боловсрох хийгээд бурхан ямагтад бодь сэтгэлийг үйлдсэн хийгээд самади бясалгалд тэгш орох хийгээд бурхан ямагтад буцалтгүй энэ адил төрөл авахын тухайд зарим нэгэн бээр хаан язгуурыг огоот барихын тухайд зарим нэг нь хуварга Тойн болохын тухайд гэргийтний тэмдэгийг бусдад дор барихын тухайд болой. Ялж төгч

нөхцөгсөн бурхан бээр зарлиглавай. Язгуур тануу хөвгүүд сайн сайн болой. Язгуур тануу хөвгүүд та нугууд бээр энэ мэт сайн галавийн бурхан нугуудын явдалын орон хийгээд орон эгүүнийг алин бээр амьтан нугууд бурхан ямагтад эргэлзээ үгүй энэ адил ойч рашаан олох болой. Бас тэр цагт тэнгэр бясманийн хөвүүн хэмээх хийгээд Мэпанба тэргүүтэй тэнгэр бүгд бээр ялж төгс нөхцөгсөн бурхан дор ийм хэмээн өчвэй. Ялж төгс нөхцөгсөн бурхан ануу бодисадваа махасадваа нугуудын орон эгүүнийг хамгаалахын тухайд хүч тавих хийгээд ялж төгс нөхцөгсөн бурханы адис тэдийн хүч бээр би ч гэсэн тэгүүнчилэн ирэгсэн бурхадын явдалын оронд адис тэдлэн орон эгүүн бүхэнд хамгаалал орхигдуулахгүйн тухайд хичээл зүтгэл их бээр хүчлэн шамдаж мөргөмэй. Хэрвээ энэ орон дор дүгү тэргүүтэй сүсэг үгүй түрэмгий нугууд хийгээд гурван төрлийн монголын цэрэг довтолон үйлдвээс тэдгээр нь хоор хоорондоо дотор тэмцэлтэй болоод хоор хоорондоо үл зохилдохуй шалтгаанаар доройтож үйлдмой. Бас тэдгээр нь юу хийсэн ч хорлол хийгээд ялж төгс нөхцөгсөн бурханы шашныг айлгаж үйлдэхгүйн тухайд бусдын эрхэнд оруулж үйлдмой. Хэрвээ хятадын цэрэг түрэмгийлж үйдлвээс тэдгээр нугуудын сэтгэлийг сүсэгтэй болгож үйлдэхийн тухайд орон эгүүнээс туслахуй хийгээд гадны орон энэ дор буян юу үйлдэхийн бодит бүтээл агуу их болохын тухайд хайрласан болой. Хэзээ энэ оронд амьтан нугууд хоролж үйлдвээс тэр цагаас буцаж сүсэгтэй болмой. Судар эгүүн ч гэсэн туслан үйлдэхийг зарлигласан болой. Алим бээр цаг тэдгээр ирээдүйд чухаг дэгээд гуравын эд эдлэл дор эрхшээсэн бөгөөд олноос булаах хийгээд амьтаны буян лугаа төгөлдөр болох тэр цагт ч бие бидний нөхөд ягчис сүсэгтэн нугууд хийгээд сүсэггүй нугууд ч эрхшээгдэх болно. Орон эгүүн дор юу хийсэн ч урт хугацаанд нэгэн эмэгтэйг хүртэл буурал эрх бөгөөд орон эгүүн дор аюулийн хүчгүй байхын тухайд зуд турхан өвчин ад гадны дайсаныг амирлуулж хайрласан болой. Ли оронд эд эдлэл тэдгээрийг эрхшээсэн ч өлзийтэй бус явдал гарах хийгээд хэн хэнбээр хаана очсон ч орон тэдгээр бүгдэд эм тус авахгүй хийгээд хямарч үйлдэх болой. Тэдгээрийн орныг баригч хийгээд цэргийн жанжин нугууд доройтож үйлдэх болой. Түвдийн цэрэг нугууд ч доройтож үйлдэх болой. Хэн бээр хаана ч ном лугаа зохиолдох орон эгүүн дор барих хийгээд хамгаалах ануу бид нугууд ч тэдгээрийг огоот тэтгэх хийгээд ялахуйн уг дор ормой. Хэрвээ тэдгээр нугууд ялж төгс нөгцөгсөн бурханы шашныг эвдэх хийгээд ороны хүмүүст

хорлож үйлдэх тэр цагт цэрэг нугууд нь дотроо зөрчилдөөд цэргийн дарга нугууд ч нас богиносон доройтож үйлдэх бөгөөд дэлгэрүүлж буян үйлдвээс урьдын үлгэрлэсэн адил болой.

Ирээдүйн цагт орон эгүүний хаан хийгээд түшмэл буян муутай нугууд нь сүсэг үгүй чухаг дэгээд гурвын гор үл хүндлэл, үл сүсэглэлийн улмаас харшлан үйлдэхүй дор зохиогдох ба эд эдлэл үл тогтох үл олдох амьтаны буян хийгээд төгөлдөр нугууд нь уналд орон тэмцэлдэж ичгүүр сонжгуургүй цаг дор орж хүслийн эрдэм еээр үл эдлэх болой. Хуварга Тойн болох тэдгээр нугуудийн сэтгэл нь уйсалтай нэгэн болох бөгөөд тэдгээр ануу би ч гэсэн орон эгүүн дор очих нэгэн болно. Орон доройтох муутах бусдад булаагдах бөгөөд энэ ёс адил бээр орон эгүүнийг тэтгэх хамгаалах болмой. Ялж төгс нөхцөгсөн бурханы тухайд тэмцэлгүй цагт орон эгүүн нэг дор хичээж амьтаны хорлолын зүг хэлэнцийг арилгах хүчин лугаа төгөлдөр орон нугуудад амьтан нугуудын сүсгийг буцаан үйлдэж сэтгэлийн мэсэн давалгаан тэнгэр хийгээд лус лагчис мангас тэргүүтэн олон болохуйн дор тэдгээр ч гэсэн миний эрхэнд үл ормой. Тиймийн тулд би бээр арга энэ мэтийг үйлдмой. Ялж төгс нөхцөгсөн бурхан бээр зарлигламой. Язгуур тануу хөвгүүн та сэтгэл уйсал бүү үйлдээ. Тэр юуны тухай хэмээвээс дөрвөн тив нь бодисадваа хэмээн тэнгэр хүч ихтэй нугууд лус ягчис тэргүүтэй өндөр газрыг олсон олон бээр тэдгээрт сэтгэл зөөлөн тахил ихийг үйлдэхүй бөгөөд суварга гамасалаган хийгээд орд харш тэргүүтэн орны адис тэд жанлавтай нугууд дор их хөлгөний гурван аймаг савын бэлэг бармидийн чандийг хураасан бурхан ихэнхдээ чухаг дэгээд гурвыг давхарлан машид дэлгэрүүлэн аймаг олныг арвидуулан зохиодог хийгээд орон тус тусаас бодисадваа арван газрыг эрхшээгч тэргүүтэн хүч их бээр хамаг амьтан тэдгээрийн орон эгүүн дор ирж номын агаар цэнгэх хийгээд гурван цаг дор багтах тэгүүнчлэн ирсэн бурхан нугуудын тангарагтай харшлалгүй үйлдэж сайн цагийн мянган бурханы явдалын орон хамгааллын орон болгон үйлдэж орон эгүүнийг хүн хийгээд бурханы шашныг хамгаалан үйлдэхүй дор болгомой. Бас ирээдүйн цаг дор буянт орон эгүүний хааны хүч багасахуй дор болно. Хүч нь багассанаас өөрийн хүчээр орноо засаж чадахгүй хаан нугууд бусдыг хэлээд яахав ээ түвдийн хаан хятадын хаан тэргүүтэн дор аврал хүсээд орноо хамгаалж үлдэх болой. Тэр юуны тулд хэмээвээс ирээдүй

цаг дор хятад түвдийн оронд чухаг дэгээд гурвын хүндлэлийн орон болгоод орон тэдгээр ч бодисадваа махасадваагийн орон болох болюу. Амьтан тэдгээр нугууд ч их бодийн зам дор эрэн хайж сүсэг ёсчилон дагаж эх хөлгөн дор сүсэглэн бясалгал дор ормой. Тэдгээрийн хүчээр Ли орны хүмүүн хийгээд чухаг дэгээд гуравын үндэс нь үл хөдөлмой. Дээд төрөлхтөн та нугууд ч түвд хятадын хаад түшмэл нугууд хэн ч суварга гамасалаган хийгээд буянт орон эгүүн дор өргөл хүндлэл хийх болмой. Орон эгүүн дор буян юу үйлдвээс бодитой нэмэгдэх бөгөөд орон эгүүний Миняог сүсэг үгүй бусад орон дор захирч зовлонгоос нь хагацаан амгалангийн орон дор хөтөлнө үнэхээрийн үзэл хийгээд буян дор баясахуйн сэтгэлийг төрүүлнэ. Буяны үндэс тэгүүний хүчээр дээд төрөлхтөн та нугуудын буяны ёзоор тунгалагшин жавхаажаад найз нөхөд арвидухуй бөгөөд бурхан ямагтад ойр болох ба гурван цагт багтах ялж төгс нөхцөгсөн бурханы увидас уламжлалаар анагаах болой. Энэ мэт орон эгүүний амьтан бүгдийн тухайд буцалтгүй бодисадийн үйлэн дор төгөлдөршиж энэрэнгүй үзэл амгалан лугаа хоосролгүй атаа хорсолыг асар тэвчимой. Ажилдаа урлалтай номон дор баясалтай үнэхээр төв үзэлтэн буруу үзэл бүгдээс тэвчсэн зөөлөн сэтгэлтэй болох бөгөөд учир шалтгаан буян хэмээмой. Орон эгүүний огторгуйд ч хүмүүн асрангуй хийгээд зөөлөн сэтгэл лугаа төгөлдөр бөгөөд суварга болон орд харш олныг чимэн зассан ба түүний тухайд огторгуйд буянтан хэмээсэн болой.

Бас чүү орон бусад нугууд ээцээс амьтан хүмүүн сүсэг үгүй уурыг баригч нугууд энэхүү оронд ирмэгц бүгд ёсыг нь дагаж номхордог бөгөөд орон эгүүнээс төрсөн амьд болгон төгс эдлэл төгөлдөр тэдгээр нугуудын сэтгэл нь зөөлөн энэрэнгүй асрангуй уур алагчаалал үгүй өш хонзон бүгдийг тэвчээд бодисадваа зүг зүгээс цугларч тэдгээр бүгд энэхүү оронд оршин тэнгэр хийгээд лус огторгуйд орших тэнгэр ягчис бүгд сэтгэл нь ичгүүр сонжгууртай бөгөөд номын үүдний дуу хаана түгэнэ тэнд очдог сүсэглэдэг тэгээд тэр цагт нөхөр нугуудын өс барихын тухайд бодисадваа махасадваа зөөлөн эгшигт манзушир бурханы хүчээр ийн хэмээн соёрхвой. Ялж төгс нөхцөгсөн бурхан юуны тухайд эрт хувилгаан энэ мэт үзүүлвээ хэмээвээс ялж төгс нөхцөгсөн бурхан бээр яруу эгшигээр зарлиг хайрлаваа. Зөөлөн эгшигт манзушир бурханы номын үүд тэдгээр ануу буянт орноос төрсөн амьтан нугуудын

тухайд, дөрвөн нөхөр нугуудын тухайд үлэмж адис тэдлээд үзүүлсэн нь энэ бөгөөд номын үүдануу бодисадваа нугуудын зовлон өчүүхэн шамдал өчүүхэн эрхтийг мэдсэнээр огоот ариусан хувирч номын үүд тэдгээр нь ч мэдэл болмой. Ирээдүйн төрөлхтөн нугууд ануу нялх үеэсээ дээш элт номон дор мэдэн баясах хийгээд тоглохдоо ч гсэн номын ёсоор өгүүлдэг нэгэн болой. Амьтан тэдгээр нугуудын эрх огоотыг шинэжилэн харвaас номын зорилго асар арвин тул ялж төгс нөхцөгсөн бурханы лагшинг ч харах болой. Номын сонор машид арвин тул ном үнэхээрийг эндүүрэлгүй сонсдог болой. Тэдгээр нөхөд нугууд нь хуран мэдэл хийгээд ном бүгдийн үйлэнд ч сэтгэлээ асар гэтэлгэж үйлддэг бөгөөд сэтгэл энэ адил орон хийдийн адис тэд жанлаваар буяны зүг хичээдэг болмуй. Бас чүү үхэрт хад ууланд тэдгээр бүгд илт бүтээхүй дор бүтээл олох бөгөөд шулмас хэлэнцтэн нугууд ч уншилгүй олдог тул бусдыг хэлээд ч яалтай билээ. Энэ адил бөгөөд тэнгэр нугуудийн нөхөр ягчис буюу гандирс хүмүүн хийгээд юу чадахаараа болж үйлдэнэ. Суварга гамасалаган үхэрт хад ууланд очоод тэдгээрийг олж үзэхгүй боловч холоос хараад ч сэтгэл нь амгалантай болдог бөгөөд уг шалтгаан тэдгээр ануу. Үхэрт хад уулын суварга гамасалаган тэргүүтний завсарт очоод замбараатай сүсэгтэй бол аврал хийгээд ертөнцийн орон бусдад амьдарах орших амьтан нугууд ч мөргөлийн илт орон болмой. Суварга гамасалаган хийгээд үхэрт хар ууланд буянт орон хийгээд огторгуйн буянтаны таалал адис тэд жанлавийн нэрийг сонсосноор сүжиг төрөх төдий ч хэлэнц ихээр арилдаг болой. Тэгээд тэр цагт ялж төгс нөхцөгсөн бурхан бээр нас лугаа төгөлдөр шавь Шааригйбуу хийгээд бясман тэнгэрийн хөвүүн дор зарлигламой. Язгуур тануу та хоёр сонсоо: Эх далай эгүүнийг Шааригйбуу гэтлэх бөгөөд хойд зүг дор хараад маш ариун тарган дотор эр дор уснаа орших амьтан нугуудад хорлол үйлдэхгүй хамгаалаад орон эгүүний хилийг тогтоо. Тэгээд их баридигаа Шааригйбуу хийгээд бясман тэнгэрийн хөвүүн тэгүүнчилэн мөргөе хэмээн соёрхоод ирт хувилгаанаар огторгуйгаас Шааригйбуу хаана байгаа зүгт очих болой. Шааригйбуу ануу гартаа харсал бариад бясманийн хөвүүн ануу гартаа жад барин Шааригйбуугийн зүгт босоод хойд тийшээ харан зогсов. Усны мангас нэгийг бариад далайн амьтан нугууд лугаа сэлтийг ариун таргын дотор тавиад энэ ямар мэт суварга гамасалаган хийгээд үхэрт ууланд Ли орон тэдгээрийг илт байгуулсан болой. Тэгээд ялж төгс нөхцөгсөн бурхан

хутагт арьяабал мэлмийгээрээ болгоогчийн эрхт хийгээд асралт тэргүүтэй бодисадваа найм хийгээд бодисадваа их Архад сэлт лугаа бясман тэнгэрийн хөвүүн Чимцэг тэргүүтэй найман их тэнгэр нөхөр гурван түм таван мянга таван зуутайгаа суварга гамасалаган тэргүүтэн дор огоот даатгах бөгөөд тэнгэр тэдгээрч тэгүүнчилэн хүч нэмэгдмой. Ялж төгс нөхцөгсөн бурхан ч тэгүүнчлэн нэмэгдмой. Ялж төгс нөхцөгдсөн бурхан хийгээд сүсэгтэн бас орон эгүүн дор хилэнц үл үйлдэгчид болоод орон эгүүний олон эрдэмтэн лугаа төгөлдөр болвоо. Тэгээд тэр цагт урдын ялж төгс нөхцөгсөн бурхан бээр гурав хүртэл адис тэдлэн жанлавласнаар их гэрэл таалал энэрлээр төгөлдөр болмуй. Аяа уснаа оршигч амьтан нугуудын сэтгэл огоод ариусаад буян лугаа төгөлдөр үйлдсэнээс усан дотор дахин гараад арван зүгийн бурхадын орон бүгдэд түгсэн болой. Бас их гэрэл тэдгээр нугууд дахин буцаад бодисадваа нугуудын оронг адистэдлээд их Шарабагаа нугуудын орныг адистэдлээд далайн дотроос гарч Лянхуан дээр ялж төгс нөхцөгсөн бурханы хөрөг оршоод тэр нь тэдгээр нугуудын гэрэл лугаа холилдон сүлэлдэж огторгуй дор хувилахуй бөгөөд дээрээс нь огторгуйг бүрхэх буюу Ли орон бүгд тэнгэрийн цэцэгэн хур буумой. Тэнгэрийн цэцэг тэдгээр нт өөр хоорондоо шүргэлцэж номын дуу гаргах бөгөөд бурхан хийгээд ном хуваргын тэмдэг үнэхээр төв үзэл бэлэг оюун шагшаабади буяны ёзоор хийгээд тэгүүнчлэгдэн ирэгсэн бурханы бэрх явдал ерөөл хийгээд бодисадваа нарын ирт хувилгаан амьтан нугуудын огоот үйлийн үр боловсроод гэлэн хуварга нугуудын дөрвөн үр дэлгэрч мөнхөд оршихуйн бясалгалд ороод буцалгагүй үр олоод дайснаа дарсан архад хийгээд гурван орчлонгийн үйлээс элт живээд тийн нярвааны гурван үүд хийгээд хуран мэдлийн аюул хийгээд санан дурьдахийн наманчилгаа хийгээд хутагтын дөрвөн үнэн хийгээд ирт хувилгааны хөл хэмээх бясалгал хийгээд самади хийгээд хураахуйн дөрвөн бодьгал хийгээд тус тусдаа үнэхээрийн язгуур хийгээд дүрсгүй тэгш орох дөрөв хийгээд эрхтэн огоот ариусаад бодийн зүг лугаа зохилдох номын хязгаарын дуу дуурсах болоод бас сэтгэл огоот ариусаад бодийн туслах хийгээд бодийн мөр хийгээд тэгш орох хийгээд газарын хүч нигүүлсэл их асрал шүтэн барилдлага эргэлзээг ариусган бурхан ямагтад буцалтгнүй хийгээд дияан хийгээд илт онол хийгээд төрөөгүй номон дор тэсээд үл холиод бурхан ямагт болоод мөнх бус хийгээд зовлон хийгээд эзэн биегүй хийгээд хоосроод үйлдэх хийгээд үл төрөх хийгээд

чанга зөв бариад үнэхээр төв үзлийг эцэслээд тэгүүнчилэн ирэгсэн бурханы зүрхэн дор багтаж асар атхаг үгүй бэлэг бэлгийг олоод ёгузор таринч нугууд бээр тус тусын өөрийн язгуурын явдалын орон хийгээд төрөлхийтэн зовлон хөгширөл зовох бүгдээс хагацаж гоо нөхөдтэй учрах хүсээд эс олохын зовлонгийн дуу дуурсах болой. Бас чүү таван цогцос нугууд дор амьтан үгүй амьдрах бодьгаль амь үгүй номын үнэн төрөл үгүй хориг үгүй мөнх үгүй, тасрах үгүй, ирэх үгүй, одох үгүй, чухаг дэгээд гуравын адис жанлав хийгээд таван амьтан нугуудын эндүүрэл зүүд адил хийгээд орчлонгийн хуран мэдэл шорон адил хийгээд илбэ хийгээд зэрэглээ хийгээд мөсөн дээр тусах сарны туяа хийгээд хадны цуурай мэт хэмээхийн дуу дуурсагдах болой. Бас сүжиг лугаа илт олоод хичээнгүй хийгээд арван буяны үйлийн зам хийгээд орчлонгийн уйсал хийгээд тэр адил тэргүүтэн олон мянгаар болох болюу. Тэгээд цугларсан түмэн олон тэдгээр нугууд дор ялж төгс нөхцөгсөн тэгүүнчилэн ирэгсэн дайнаа дарагсан үнэхээр тугуулгасан бурхан ийн хэмээн зарлиг хайрлав. Хурсан түмэн тэдгээр ялж төгс нөхцөгсөн бурханы сургаалийг даган баясан илт сүслэн магтмой.

# ХУТАГТ ҮХЭРТ УУЛАНД АЙЛТГАСАН БУРХАН БАГШИЙН БОШИГ ЛҮНДЭН

/Түвд эх/







གཟུངས་བསྡུས

B 248

ལ་བབ་བོ། །དེ་ནས་དེའི་ཚེ་ལྷའི་ཡང་ལྷ་སངས་རྒྱས་བཅོམ་ལྡན་འདས་འཁོར་ཕལ་པོ་ཆེ་དང་། ནམ་མཁའ་ལ་འཕགས་ཏེ། དྲི་ཟའི་རྒྱལ་པོ་གཙུག་ཕུད་ལྔ་པ་ལ་སོགས་པ་དྲི་ཟ་གྲངས་མེད་
པ་ནི་མདུན་ན་ལྷའི་རོལ་མོ་སྣ་ཚོགས་བྱེད། མི་འམ་ཅིའི་རྒྱལ་པོ་ཡིད་འོང་ལ་སོགས་པ་མི་འམ་ཅི་དུ་མ་ནི་སྟེང་ནས་མཆོད་པའི་ལས་བྱེད་ཅིང་། སངས་རྒྱས་བཅོམ་ལྡན་འདས་ལ་དབྱངས་
དང་ལྷའི་སྐད་ཡིད་དུ་འོང་བས་བསྟོད་བཞིན་དུ། འཁོར་དེ་དག་དང་མཆོད་པ་དེ་དག་དང་བཅས་ཏེ། རི་གླང་རུ་ག་ལ་བ་དེར་གཤེགས་སོ། །གཤེགས་ནས་ལྷའི་ཡང་ལྷ་སངས་རྒྱས་བཅོམ་
ལྡན་འདས་བཞེངས་བཞིན་དུ་ཞལ་བྱང་ཕྱོགས་སུ་མཚོ་ཆེན་པོ་ཡུན་རིང་པོ་ནས་རྒྱ་མཚོ་ལྟར་འདུག་པ་ལ་གཟིགས་ཏེ། སྐུ་དྲང་པོར་བསྲང་ནས་དེ་བཞིན་གཤེགས་པའི་ཏིང་ངེ་འཛིན་བྱེ་བ་
ཕྲག་བརྒྱ་སྟོང་དུ་མ་ལ་སྙོམས་པར་ཞུགས་ཏེ། བསྐལ་པ་གྲངས་མེད་པ་གསུམ་ནས། བདག་ཉིད་ཀྱི་སངས་རྒྱས་ཀྱི་སྤྱོད་པ་སྔོན་ལམ་དང་། བསོད་ནམས་མངོན་སུམ་དུ་མཛད་དོ། །དེ་ནས
དེའི་ཚེ་ལྷའི་ཡང་ལྷ། སངས་རྒྱས་བཅོམ་ལྡན་འདས་ཀྱིས་རི་གླང་རུ་དང་། ཡུལ་དགེ་བ་དང་གསེར་གྱི་དཀྱིལ་འཁོར་ནས། སྲིད་པའི་རྩེ་མོའི་བར་དུ་བྱིན་གྱིས་བརླབས་ཏེ། བསྲུང་བ་དང་།
བཅང་བ་དང་། བཀྲ་ཤིས་དང་། མཚམས་བཅད་པ་དང་། བརླབས་བརྗོད་དང་དགེ་བར་མཛད་དོ། །དེ་ནས་དེའི་ཚེ་ལྷའི་ཡང་ལྷ། སངས་རྒྱས་བཅོམ་ལྡན་འདས་ཀྱིས་འཁོར་དེ་དག་ཐམས

གླང་རུ་ ཤོ་ བརྒྱ་ ཞེར་ལྔ

B 249

༄༅། །ཅེད་ལ་བཀའ་སྩལ་པ། རི་གླང་རུ་བཅོམ་ལྡན་འདས་ཀྱི་ཕོ་བྲང་། མཆོད་རྟེན་གོ་མ་སཱ་ལ་གནྡྷ་དང་བཅས་པ་ཡུལ་དགེ་བ་དང་བཅས་པ་འདི་ནི་བསྐལ་པ་བཟང་པོའི་སངས་རྒྱས
བཅོམ་ལྡན་འདས་ཐམས་ཅད་ཀྱི་ཕྱག་མཚན་དང་། མ་འདྲེས་པ་དང་། ཐུན་མོང་མ་ཡིན་པ་དང་དབེན་པ་ཡིན་ཏེ། རྒྱུ་དེས་ན་ཡུལ་འདི་དགེ་བ་ཞེས་བྱའོ། །དེ་ནས་དེའི་ཚེ་ལྷའི་ཡང་ལྷ། སངས་རྒྱས
བཅོམ་ལྡན་འདས་ཀྱིས་ཡུལ་དགེ་བ་དང་། མཁར་དགེ་བ་ཅན་དང་། དགེ་འདུན་སོ་སོའི་ཀུན་དགའ་ར་བ་དང་། གཙུག་ལག་ཁང་དང་། དགོན་པའི་གནས་དང་། ཡུལ་དེར་སོ་སོ་ནས་བསོད་ནམས
བྱ་བའི་དངོས་པོ་དགེ་བ་བྱེད་པར་འགྱུར་བའི་རྒྱལ་པོ་དང་། ཆོས་དང་ལྡན་པའི་དད་པ་ཅན་དང་སྦྱིན་བདག་དང་ཡི་ཡུལ་ཐམས་ཅད་ལུང་བསྟན་ཏོ། །དེ་ནས་བཅོམ་ལྡན་འདས་ཀྱིས་བྱང་ཆུབ་སེམས
དཔའ་རྣམས་ལ་བཀའ་སྩལ་པ། རིགས་ཀྱི་བུ་ཁྱེད་རྣམས་ཀྱིས་ཀྱང་མ་འོངས་པའི་དུས་ན་འབྱུང་བའི་ཡུལ་འདིར། ཅི་ནས་ཀྱང་སེམས་ཅན་རྣམས་དམ་པ་ཆེན་པོ་མྱུར་དུ་ཐོབ་པར་འགྱུར་བ་དང་ཏིང་
ངེ་འཛིན་འགྲུབ་པར་འགྱུར་བར་བྱིན་གྱིས་རློབས་ཤིག །དེ་ནས་དེའི་ཚེ་བཅོམ་ལྡན་འདས་མཚོ་རོལ་ནས་ཅུང་ཟད་ཅིག་སླར་བཀྲོ་སྟེ། དེའི་མོད་ལ་རི་གླང་རུའི་སྟེང་དུ་གདན་ཁྲི་བཤམས་པ་ལ་སྐྱིལ
མོ་ཀྲུང་བཅས་ཏེ་བཞུགས་ནས། ཞལ་ནུབ་ཕྱོགས་སུ་བཅོམ་ལྡན་འདས་ཀྱི་ཕོ་བྲང་མཆོད་རྟེན་གོ་མ་སཱ་ལ་གནྡྷ་ག་ལ་བ་དེ་ལོགས་སུ་གཟིགས་སོ། །དེ་ནས་དེའི་ཚེ་འཇིག་རྟེན་གྱི་ཁམས་གཞན་དང་།

གཟུངས་བསྡུས

B 250

གཞན་ནས། བྱང་ཆུབ་སེམས་དཔའ་ཉི་ཁྲི་མངོན་པར་ཤེས་པ་ལྔ་དང་ལྡན་པའི་དྲང་སྲོང་མང་པོ་དང་ཐབས་ཅིག་ཏུ་བཅོམ་ལྡན་འདས་ག་ན་བ་དེ་ལོགས་སུ་ལྷགས་སོ། །ལྷགས་ནས་བཅོམ་ལྡན་
འདས་ཀྱི་ཕོ་བྲང་མཆོད་རྟེན་གོ་མ་སཱ་ལ་གནྡྷ་ལ་ཡང་ཕྱག་འཚལ། སྐྱབས་སུ་སོང་། སངས་རྒྱས་བཅོམ་ལྡན་འདས་འཁོར་དང་བཅས་པ་ལ་འང་ཕྱག་འཚལ་སྐྱབས་སུ་སོང་ནས་ཕྱོགས་གཅིག
ཏུ་འཁོད་དོ། །དེ་ནས་དེའི་ཚེ་སངས་རྒྱས་བཅོམ་ལྡན་འདས་ཀྱིས་འཁོར་ཕལ་པོ་ཆེ་འདུས་པར་མཁྱེན་ནས། འཁོར་དེ་དག་ལ་འདི་སྐད་ཅེས་བཀའ་སྩལ་ཏོ། །བསྐལ་པ་བཟང་པོ་འདི་ལ་སྔོན་
སངས་རྒྱས་བཅོམ་ལྡན་འདས་བཞི་བྱུང་སྟེ། དེ་དག་གིས་ཀྱང་མཆོད་རྟེན་གོ་མ་སཱ་ལ་གནྡྷ་ཡུལ་དང་བཅས་པ་བྱིན་གྱིས་བརླབས་སོ། །བསྐལ་པ་བཟང་པོ་འདི་ལ་མ་འོངས་པའི་དུས་ན་འང་།
སངས་རྒྱས་སྟོང་རྩ་གཅིག་འབྱུང་བར་འགྱུར་ཏེ། དེ་དག་ཐམས་ཅད་ཀྱང་འཁོར་དང་བཅས་ཏེ་འདིར་གཤེགས་ནས། མཆོད་རྟེན་གོ་མ་སཱ་ལ་གནྡྷ་ཡུལ་དང་བཅས་པ་བྱིན་གྱིས་རློབ་ཅིང་།
མཚམས་བཅད་པ་དང་། བཀྲ་ཤིས་དང་། དགེ་བར་མཛད་པར་འགྱུར་རོ། །ང་ཡང་ད་ལྟར་བྱིན་གྱིས་རློབ་པའི་དུས་ལ་བབ་པས་བྱིན་གྱིས་རློབ་པར་མཛད་དོ། །དེ་ནས་དེའི་ཚེ་ལྷའི་ཡང་ལྷ།
སངས་རྒྱས་བཅོམ་ལྡན་འདས་ཏིང་ངེ་འཛིན་ད་ལྟར་གྱི་སངས་རྒྱས་མངོན་སུམ་དུ་བཞུགས་པ་ཞེས་བྱ་བ་དང་། གཞན་ཡང་དེ་བཞིན་གཤེགས་པའི་ཏིང་ངེ་འཛིན་གྲངས་མེད་པ་ལ་སྙོམས་པར


B 251


B 252


B 253







གླང་རུ། ཤ བརྒྱ ཉེར་དགུ

B 257

༄༅། །ཚེ་འཁོར་དེར་འདུས་པའི་ལྷ་རྣམས་ཀྱིས། བཅོམ་ལྡན་འདས་ཀྱིས་བཀའ་སྩལ་པའི་གསུང་དེ་ཐོས་ནས། མཆོད་རྟེན་གོ་མ་ས་ལ་གན་དྷ་དང་། རི་གླང་རུ་ལ་དད་པ་དང་
གུས་པ་ཆེན་པོ་སྐྱེད་དེ། སངས་རྒྱས་བཅོམ་ལྡན་འདས་ལ་མགོ་བོས་ཕྱག་འཚལ་སྐྱབས་སུ་སོང་ནས། སྤྱན་སྔར་འདི་སྐད་དུ་བདག་ཅག་ཀྱང་དུས་དེའི་ཚེ་ཡུལ་འདིར་རིགས་མཐོན་པོར
སྐྱེས་ནས། བདེ་བར་གཤེགས་པའི་བསྟན་པ་བསྲུང་ཞིང་། ཡུལ་ཆོས་ཀྱི་བཀའ་ཁྲིམས་མི་ཉམས་པར་བྱེད་པར་གྱུར་ཅིག་ཅེས་སྨོན་ལམ་བཏབ་བོ། །དེ་ནས་དེའི་ཚེ་བཅོམ་ལྡན་འདས་ཀྱིས
ལྷའི་རྒྱལ་པོ་རྣམ་ཐོས་ཀྱི་བུ་དང་བྱང་ཆུབ་སེམས་དཔའ་སེམས་དཔའ་ཆེན་པོ་འདུ་ཤེས་ཅན་ཞེས་བྱ་བ་དང་། ལྷའི་ལྷ་མི་ཕམ་པ་ཞེས་བྱ་བ་དང་། ཀླུའི་རྒྱལ་པོ་ཁྲིམ་ཚོག་ཅེས་བྱ་བ་དང་། ལྷ་
